



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ГАЗРААС 2018  
ОНД БОЛОВСРУУЛАН ГАРГАСАН ДҮРЭМ  
ЖУРАМ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД**







**БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМНЫ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН  
ГАЗРААС 2018 ОНД  
БОЛОВСРУУЛАН ГАРГАСАН  
ДҮРЭМ ЖУРАМ, БОДЛОГЫН  
БАРИМТ БИЧГҮҮД**

---

Улаанбаатар 2018





№	Баримт бичгийн нэр	Дугаар	Огноо	Хуудасны дугаар
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний жишиг шаардлага, үлгэрчилсэн загвар, хэрэглэх зөвлөмж	<b>A/155</b>	2018 оны 03 дугаар сарын 29	5
2	“Бага, суурь бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах журам”	<b>A/168</b>	2018 оны 04 дүгээр сарын 03	29
3	“Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөр	<b>A/181</b>	2018 оны 4 дүгээр сарын 06	34
4	“Боловсролын байгууллагын сургалтын орчин ба дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”	<b>A/239</b>	2018 оны 05 дугаар сарын 01	35
5	“Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”	<b>A/243</b>	2018 оны 05 дугаар сарын 01	42
6	“Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”	<b>A/369</b>	2018 оны 6 дугаар сарын 13	51
7	“Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай”	<b>A/381</b>	2018 оны 6 дугаар сарын 15	56
8	“Сургуулийн аюулгүй орчныг бүрдүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”	<b>A/398</b>	2018 оны 6 дугаар сарын 22	59
9	“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”	<b>A/425</b>	2018 оны 6 дугаар сарын 29	65
10	“Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай”	<b>A/453</b>	2018 оны 6 дугаар сарын 15	73
11	Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан багшийн журналын загвар	<b>A/460</b>	2018 оны 07 дугаар сарын 10	77
12	Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр	<b>A/467</b>	2018 оны 7 дугаар сарын 30	78
13	“Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”	<b>A/476</b>	2018 оны 7 дугаар сарын 31	79
14	Ерөнхий боловсролын тусгай сургуулиудын сургалтын төлөвлөгөө	<b>A/491</b>	2018 оны 08 дугаар сарын 06	87
15	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал	<b>A/549</b>	2018 оны 8 дугаар сарын 30	92
16	Цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх журам	<b>A/608</b>	2018 оны 9 дүгээр сарын 28	95
17	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам	<b>A/612</b>	2018 оны 10 дугаар сарын 1	99
18	“Хичээлийн жилийн бүтэцэд өөрчлөлт оруулах тухай”	<b>A/747</b>	2018 оны 11 дүгээр сарын 29	104

19	Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах нийтлэг журам	<b>A/762</b>	2018 оны 12 дугаар сарын 04	107
20	“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хувийн хэрэг хөтлөх заавар, загвар батлах тухай”	<b>A/773</b>	2018 оны 12 дугаар сарын 06	112
21	Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам	<b>A/812</b>	2018 оны 12 дугаар сарын 20	113
<b>Засгийн газрын бусад гишүүдтэй хамтран баталсан тушаал</b>				
22	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай”	ХНХ/ БСШУС/ ЭМС <b>A/116, A/304, A/197</b>	2018 оны 05 дугаар сарын 21	123
23	“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар коммисын шийдвэрийн маягт, хүүхдийн хувийн хэрэг хөтлөх маягт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийн маягт батлах тухай”	ХНХ/ БСШУС/ ЭМС <b>A/304, A/699, A/460</b>	2018 оны 11 дүгээр сарын 15	124
24	Үлгэрчилсэн загвар, жагсаалт батлах тухай “Хүүхдийн цэцэрлэгийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, ерөнхий боловсролын сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн ажлыг байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрүүл мэндийн кабинетэд байх шаардлагатай эм, багаж хэрэгслийн жагсаалт”	ЭМС/ БСШУС <b>A/494, A/761</b>	2018 оны 12 дугаар сарын 04	126



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Үлгэрчилсэн загвар, аргачлал  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 15.4 дэх хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн 3.2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчдын хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглах "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө"-ний үлгэрчилсэн загварыг нэгдүгээр, "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх суралцагчдын хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх үүрэг бүхий сургуулийн комиссыг жил бүрийн 5 дугаар сард байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

3.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэсэн суралцагчдын талаархи тайланг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны ерөнхий боловсролын бодлогын газарт жил бүрийн 6 дугаар сард багтаан ирүүлж байхыг ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

0900473



Боловсрол, соёл, шинжлэх ухааны, спортын  
сайдын 2018 оны 05 дугаар сарын 14 өдрийн  
№105 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАТЛАВ.Сургалтын менежер .....

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.Сурагчийн бодит байдлын судалгаа

Сургуулийн комиссын хуралдааны огноо .....		Сургуулийн эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ, дүгнэлт: .....	
Сурагчийн овог, нэр .....		огноо: <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
Регистрийн дугаар: .....	Сургуульд элсэн огноо, (нас)	өрсөн	орсон
Анти, бүлэг .....	Хүйс: .....	Төрсөн огноо: .....	.....
Ам бүлийн тоо .....	Хамт амьдардаг гэр бүлийн гишүүд .....	.....	
Гэр бүлийн харилцааны төлөв байдал: .....			
Цэцэрлэгт явсан эсэх (Тийм/ Үгүй).	Эцэг, эх /асран хамгаалагч/-ийн нэр	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэр: Хөгжлийн үнэлгээний сорилд хамрагдсан эсэх [ ] Тийм/ [ ] Үгүй /:	
-Хэрвээ тийм бол, цөцэрлэгийн нэр:	Холбоо барих утас:	-Хэрвээ тийм бол, Сорилын нэр:	
-Хэрвээ үгүй бол, яваагүй шалтгаан:	И-мэйл хаяг	-Үнэлгээ хийсэн байгууллагын нэр -Үнэлгээний үр дүн.	
Оршин суугаа хаяг:		Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байдаг эсэх: ( Тийм/ [ ] Үгүй); -Тийм бол тухайн эрүүл байгууллагын нэр, тавигдсан онош, хяналтын давтамж.	

Төрсөний дараахь /0-24 сар хүртэл/ үеийн хөгжлийн түвшингийн онцлог байдал	
Сургуульд бэлтгэгдсэн байдал /2-5 нас/	
ГСТ-д хамрагдах үеийн хөгжлийн түвшингийн байдал:	Өөртөө үйлчлэх энгийн чадварууд
	Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол
	Нийгэмшихүй
	Бие бялдар, хөдөлгөөн
	Анги удирдсан багшийн тодорхойлолт
Оролцогч талуудын хүсэл, зорилго	Сурагч:
	Эцэг эх /асран хамгаалагч/:
	Багш:

Тэмдэглэл хөтөлсөн Багшийн нэр, гарын үсэг ..... / огноо: 0000 / 0000 / 00

Танилцсан эцэг (эх, асран хамгаалагч)-ийн  
 нэр, гарын үсэг ..... / огноо: 0000 / 0000 / 00

## 2. Урт хугацааны зорилт

Сурацлагчийн овог, нэр ..... (Хичээлийн жил ..... / ..... / .....)  
 Анги, бүлэг ..... Хүйс ..... Төрсөн огноо (нас) .....

Хөгжлийн ай	Урт хугацааны зорилт	Дэмжлэгийн орчин		
		Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг	Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг	Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг
Өөртөө үйлчлэх энгийн чадвар				
Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол				
Нийгэмшихүй				
Бие бялдар, хөдөлгөөн				

\* Зөвхөн шаардлагатай гэж үзсэн хөгжлийн айн зорилтыг дэвшүүлнэ.

Тэмдэглэл хөтөлсөн анги удирдсан багшийн нэр, гарын үсэг ..... / ..... / .....  
 огноо: ..... / ..... / .....

Танилцсан, эцэг (эх, асран хамгаалагч)-ийн нэр, гарын үсэг ..... / ..... / .....  
 огноо: ..... / ..... / .....

**3. Богино хугацааны зорилт**

Суралцагчийн овог, нэр ..... Анги, бүлэг ..... Хүйс ..... Төрсөн огноо (нас) .....

Урт хугацааны зорилт .....

Дэмжлэгийн орчин /хэзээ, хаана/	Улирал	Богино хугацааны зорилт	Суралцагчийн хийх үйл ажиллагаа	Багшийн дэмжлэг, арга зүй	Эцэг, эхийн дэмжлэг, тусалцаа	Улирлын үнэлгээ		
						Сурагчийн үнэлгээ	Багшийн үнэлгээ	Үнэлгээ өгсөн хүний нэр
	1-р улирал							
	2-р улирал							
	3-р улирал							
	4-р улирал							
	1-р улирал							
	2-р улирал							
	3-р улирал							
	4-р улирал							

\* Зөвхөн урт хугацааны зорилтын дэмжлэгийн орчин хэсэгт тусгагдсан тохиолдолд ашиглана.

#### 4. Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж

Сурацлагчийн овог, нэр ..... Анги, бүлэг ..... Хүйс ..... Төрсөн огноо (нас) .....

№	Урт хугацааны зорилт	Дүгнэлт	
		Ололт, амжилт	Сайжруулах чиглэл, зөвлөмж

Тэмдэглэл хөтөлсөн анги удирдсан багшийн  
нэр, гарын үсэг .....

огноо: 11.11.11 11

Танилцсан, эцэг (эх, асран хамгаалагч)-ийн  
нэр, гарын үсэг .....

огноо: 11.11.11 11



Боловсрол, соёл, шинжлэх ухааныг, спортын  
сайдын 2018 оны 13 дугаар сарын 29 өдрийн  
N/155 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

### Удиртгал

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө /цаашид "ГСТ" гэх/, нь хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэгийг үзүүлэх хэрэглэгдэхүүн бөгөөд тухайн хүүхдэд чанартай боловсрол олгох нөхцөл боломжийг бүрдүүлэх арга зам юм.

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, хөдөлгөөний хөгжил үе тэнгийн хүүхдүүдтэй нь харьцуулахад харьцангуй удаан байх тохиолдол байдаг учраас тэдэнтэй нэг ижил агуулгаар суралцах, анги, хамт олноороо хийх үйл ажиллагаанд оролцоход бэрхшээл учирдаг. Энэхүү шалтгааны улмаас ГСТ боловсруулж, хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэг үзүүлж, тухайн хүүхдийг хөгжүүлэх боломжтой.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйлчилгээг сайжруулах, хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, хөгжлийн дэмжлэгийн тогтолцоог бий болгох, бэхжүүлэх "ЖАЙКА Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийг 2015 оны 8 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн. Тус төслийн хүрээнд 2015 оны 12 дугаар сараас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Нийслэлийн боловсролын газар, Монгол Улсын Боловсролын их сургууль, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, Ерөнхий боловсролын оюуны бэрхшээлтэй хүүхдийн тусгай 4 сургуультай хамтран "ГСТ"-ний үлгэрчилсэн загварыг боловсруулж, тэдгээр сургууль дээр туршин, сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

ГСТ нь сурагч бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, төлөв байдлын тухайн үеийн үнэлгээг багтаасан, тэрхүү үнэлгээнд суурилсан урт, богино хугацааны зорилт, сургалтын агуулга, багшийн дэмжлэг, арга зүй зэргийн төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ хийх үйл ажиллагааг нэгтгэн хөтлөх баримт бичиг юм. Тус ГСТ боловсруулах үйл ажиллагаанд анги удирдсан багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, нийгмийн ажилтан, сургуулийн удирдлага, эмч зэрэг бусад холбогдох хүмүүс оролцож, хамтран боловсруулах шаардлагатай. Тэгснээр тухайн сурагчийн хөгжлийг илүү дэмжиж, чанартай боловсрол олгох үйл ажиллагааг зохих түвшинд зохион байгуулж чадна.

### ГСТ-ний зорилго

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлж, түүнд тохирсон тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг үзүүлэх

2. Хүүхдийн хөгжлийн бодит байдалд тулгуурлан сургуулийн болон гэрийн орчинд тухайн хүүхэдтэй ажиллах сургалтын агуулга, багшийн болон мэргэжилтний арга зүй, дэмжлэгийн тогтолцоог тодорхойлж, хэрэглэх

3. Сурагчийн хөгжлийн ахицыг үнэлж, түүний ахуй амьдрал, суралцах үйлд тулгарч буй бэрхшээлийг арилгах

ГСТ-ийг боловсруулахад баримтлах зарчим:

- Суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн. түүний хөгжлийг дэмжсэн байх;
- Зорилт биелэгдэхүйц байх;
- Хүүхдэд дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- Тогтоосон хугацаанд шинэчлэн боловсруулж байх;
- Оролцогч талууд харилцан хүлээн зөвшөөрсөн байх;
- Нууцлалыг чанд хадгалах.

ГСТ-өөр хичээллэх хүсэлтийг гаргах, шийдвэрлэх арга зам:

- ГСТ-өөр хичээллэх хүсэлтийг сурагч, эсвэл эцэг, эх, асран хамгаалагч, эсвэл анги удирдсан багш гаргаж болно.
- Хүсэлт гаргасан тохиолдолд гурван тал /сурагч, эцэг, эх, хариуцах багш/-ын уулзалтыг анги удирдсан багш зохион байгуулна.
- Сурагч, эцэг, эх ба асран хамгаалагч нь суралцагчийн ГСТ-г боловсруулахад санал, хүсэлтээ илэрхийлж, түүний агуулгад тусгуулж болно.
- Сонирхогч талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр ГСТ-өөр хичээллэхээр болбол холбогдох материалыг бүрдүүлэн сургуулийн комисст хандана.
- Сургуулийн комисс хуралдаж, эцсийн шийдвэрийг гаргана.
- Сургуулийн комисст тухайн сургуулийн захирал, сургалтын менежер, заах аргын нэгдлийн ахлагч, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, анги удирдсан багш, судлагдахуун болон заслын багш зэрэг хүмүүсийн төлөөлөл орно.

ГСТ-ний үлгэрчилсэн загварын бүтэц:

1. Сурагчийн бодит байдлын судалгаа
2. Урт хугацааны зорилт, дэмжлэгийн орчин
3. Богино хугацааны зорилт, багш, мэргэжилтний дэмжлэг, арга зүй, үнэлгээ
4. Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж
5. ГСТ-г боловсруулахад анхаарах зүйлс

Тус ГСТ-г боловсруулах аргачлал нь ГСТ-ний үлгэрчилсэн загварыг хөтлөх арга зүй, цаашид тухайн хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, хувь хүний зан чанар, ур чадвар, чадамжийн төвшинд нийцүүлэн өөрчлөн боловсруулахад анхаарах зүйлсийг тус тус багтаасан болно.

#### Хөтлөх заавар

**Нэг.** "Сурагчийн бодит байдлын судалгаа" хэсэгт бичигдэх мэдээллийг сурагчийн эцэг, эх /асран хамгаалагч/-ээс асууж бөглөнө. Үүнд:

- 1.1. "Сургуулийн комиссын хуралдааны огноо" гэсэн хэсэгт Сургуулийн комисс хуралдаж, тухайн сурагчийг ГСТ-өөр хичээллүүлэх шаардлагатай гэсэн шийдвэр гаргасан бол тус хуралдааны огноог "он, сар, өдөр" гэсэн дарааллын дагуу бичнэ. Жишээлбэл, 2000-05-12 гэх мэт.
- 1.2. "Сурагчийн овог, нэр" хэсэгт сурагчийн "Төрсний гэрчилгээнд байгаа овог, нэрийг бичнэ. Сурагчийн удам судрын овгийг хэрэглэхгүй болно. Жишээлбэл, Доржийн Бат
- 1.3. "Регистрийн дугаар " хэсэгт бичигдэх мэдээллийг сурагчийн "Төрсний гэрчилгээ"-нээс харж бичнэ. Жишээлбэл: ХЕ 93050253 гэх мэт
- 1.4. "Сургуульд элсэн орсон огноо (нас)" хэсэгт тухайн сурагчийн ерөнхий боловсролын сургалтын байгууллагад анх элсэн орсон огноог "он, сар, өдөр" гэсэн дарааллын дагуу бичихээс гадна мөн "нас"-ыг хаалтад бичнэ. Харин тухайн сургуульд элсэн орсон, эсвэл шилжин ирсэн огноо болон насыг бичихгүй болно. Жишээлбэл: 2000-09-01 (7 нас) гэх мэт.
- 1.5. "Анги, бүлэг" хэсэгт хэддүгээр ангийн ямар бүлэгт сурч байгааг бичнэ. Жишээлбэл, "2Б" гэх мэт.
- 1.6. "Хүйс" хэсэгт "эр", эсвэл "эм" хоёрын аль нэгийг сонгож бичнэ.
- 1.7. "Төрсөн огноо" хэсэгт сурагчийн төрсөн огноог "Он, сар, өдөр" гэсэн дарааллаар бичнэ. Жишээлбэл, 1993-05-02 гэх мэт.
- 1.8. "Ам бүлийн тоо" хэсэгт сурагчийн өрх гэрт бүртгэлтэй хүний тоог бичнэ. Жишээлбэл, Аав, ээж, хүүхэд, түүний дүү байгаа бол ам бүлийн тоо 4 болно.
- 1.9. "Хамт амьдардаг гэр бүлийн гишүүд" хэсэгт тухайн өрх айлын гишүүдээс гадна хамт амьдарч буй гэр бүлийн гишүүд, хамаатан, төрөл садангийн хамаарлын нэршлийг бичнэ. Жишээлбэл: аав, ээж, эрэгтэй дүү, би, өвөө, нагац ах гэх мэт.
- 1.10. "Гэр бүлийн харилцааны төлөв байдал" хэсэгт хүүхэд маань айлын хэд дэх хүүхэд болох, тухайн гэр бүлийнхэн тухайн хүүхэдтэй хэрхэн харьцдаг, ямар бэрхшээлтэй асуудал тулгардаг, хэрхэн шийддэг талаар дэлгэрэнгүй асууж лавлаж бичнэ. \хэт эрхлүүлэх, шоовдорлох, үл тоох, дохиогоор харилцдаг гэх мэт\
- 1.11. "Цэцэрлэгт явсан эсэх" хэсэгт  Тийм/  Үгүй гэсэн хариултын аль нэгийг сонгож, "✓" тэмдэглэгээг ашиглан бөглөнө.
- 1.12. Хэрвээ "тийм" гэж хариулсан бол Цэцэрлэгийн нэрийг бичнэ. Хамрагдсан насыг

тодорхой бичнэ. Харин “үгүй” гэж хариулсан бол “яваагүй шалтгаан”-ыг сайтар асууж бичнэ. Цэцэрлэгт хамрагдаагүй шалтгааныг аль болох тодорхой асууж бичих хэрэгтэй. Жишээлбэл, -Зөвхөн хүн байгаагүй; -Цэцэрлэг олдоогүй гэх мэт

- 1.13. “Эцэг, эх /асран хамгаалагч/-ийн нэр” хэсэгт тухайн сурагчийн бодит байдлын үнэлгээ хэсгийн ярилцлагад орж мэдээлэл өгч байгаа эцэг, эх /асран хамгаалагч/-ийн нэрийг бичнэ. Мөн энэ хэсэгт тухайн эцэг, эх /асран хамгаалагч/ нь сурагчтай ямар төрөл санаднгийн холбоо хамааралтай болох (ээж, эсвэл аав гэх мэт)-ыг тодорхой бичихээс гадна түүнтэй холбоо барих утас, и-мэйл хаягийг асууж тэмдэглэнэ.
- 1.14. “Оршин суугаа хаяг” хэсэгт эцэг, эх/асран хамгаалагч/-ийн иргэний үнэмлэх дээр бичигдсэн эсвэл, шилжин ирсэн тэмдэглэл бүхий хуудсыг ашиглан хаягийг тодорхой бичнэ. Жишээлбэл, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17-р хороо, 34-р байр, 5 тоот гэх мэт.
- 1.15. “Сургуулийн эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ, дүгнэлт” хэсэгт ерөнхий боловсролын тусгай сургуулийн “Эмнэлэг, сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ, дүгнэлт хийлгэж байсан бол тухайн хуралдаан зохион байгуулагдсан огноо, гаргасан шийдвэр буюу тавьсан оношийг бичихээс гадна бэрхшээлийн нэрийг сонгож, “✓” тэмдэглэгээг ашиглан бөглөнө.
  - Сурагчид тавьсан онош бэрхшээлийн нэрсийн жагсаалтад байхгүй тохиолдолд “Бусад” гэдгийг сонгож, тухайн бэрхшээлийн нэрийг бичнэ.
  - “Дагалдах өвчин, эмгэгийн тухай мэдээлэл” хэсэгт тухайн сурагч өөрийн хөгжлийн бэрхшээлээс гадна эрүүл мэндийн хувьд ямар нэг дагалдах өвчин, эмгэгтэй байх ахул дэлгэрэнгүй нэг бүрчлэн бичиж, тэмдэглэнэ. Жишээ нь: Уналт таталт, зүрхний өвчин, арьсны өвчин гэх мэт/-ийг бичнэ.
- 1.16. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүгнэлт” хэсэгт тус комиссын хурлаар орж “Комиссын шийдвэр” гарсан бол агуулгыг бичнэ.
- 1.17. “Эрүүл мэндийн байгууллагын үзлэгт орж, оношлуулсан эсэх” хэсэгт сурагч өөрийн хөгжлийн бэрхшээл, өвчин эмгэгийн улмаас эрүүл мэндийн байгууллагын үзлэгт орж оношлуулж байсан бол “Тийм/ “Үгүй” гэсэн хариултын аль нэгийг сонгож, “✓” тэмдэглэгээг ашиглан бөглөнө.
  - Хэрвээ “тийм” гэж хариулсан бол үзлэг, оношилгоонд орсон эрүүл мэндийн байгууллагын нэр болон тавьсан оношийг тус тус бичнэ.
- 1.18. “Хөгжлийн үнэлгээний сорилд хамрагдсан эсэх” хэсэгт гадаад, дотоодын байгууллагын үзлэгт хамрагдаж, оношилгоо, үнэлгээ хийлгэж байсан бол тухайн үр дүнг нь бичнэ.
  - Хэрвээ “тийм” гэж хариулсан бол сорилын нэр, үнэлгээ хийсэн байгууллагын нэр,

үнэлгээний үр дүнг тус тус бичнэ. Жишээ нь:

- Сурагч оюун ухааны сорил буюу "IQ"-гийн үнэлгээ хийлгэсэн бол тус IQ-гийн үнэлгээнд авсан оноог бичнэ.
- Хөгжлийн үнэлгээний сорил /"Векслерийн оюун ухааны сорил", "Бэйлигийн нялхсын хөгжлийн сорил", "Денверийн хөгжлийн тандалтын сорил" гэх мэт/-д хамрагдсан бол сорилын үнэлгээг бичнэ.
- Өөр бусад оношилгоо, үнэлгээний сорилд хамрагдаж байсан бол тухайн сорил, үнэлгээний үр дүнг бичнэ.

1.19. "Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байдаг эсэх" хэсэгт тухайн сурагч өөрийн өвчин, бэрхшээлийн улмаас байнгын эмнэлгийн хяналтад байдаг бол "Тийм/ Үгүй" гэсэн хариултын аль нэгийг сонгож, "✓" тэмдэглэгээг ашиглан бөглөнө.

- Хэрвээ "тийм" гэж хариулсан бол тус эрүүл мэндийн байгууллагын нэр, тавьсан онош, хяналтын дагуу ямар хугацаа, давтамжтай үзүүлдэг зэргийг тодорхой бичнэ.

1.20. "Төрсний дараахи /0-24 сар хүртэл/ хүүхдийн хөгжлийн түвшингийн онцлог байдал" хэсгийн мэдээллийг эцэг, эх, асран хамгаалагчаас асууж, эсвэл зарим мэдээллийг "Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр"-ээс харж бичиж болно. Гол нь эх, хүүхдийн эрүүл мэндийн байдал ямар байсан, ямар нэг хүндрэлтэй асуудал тулгарсан эсэх, оношилгоо, эмчилгээ хийлгэж байсан эсэх талаар дэлгэрэнгүй асууж тэмдэглэл хөтөлнө.

1.21. "Сургуульд бэлтгэгдсэн байдал /2-5 нас/" хэсэгт сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байх үедээ эзэмшсэн чадвар, чадамжийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/301 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас"-ыг ашиглан эцэг, эх, асран хамгаалагчаас асууж тэмдэглэхээс гадна эх хүүхдийн эрүүл мэндийн байдал, цэцэрлэгт хамрагдсан үеийн байдал, эсвэл гэрээр хүмүүжиж байх үеийн байдал зэргийг эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн тэмдэглэлээс харах эсвэл эцэг эх, асран хамгаалагчаас асууж бичнэ. /Хавсралтаас үзнэ үү/. Жишээлбэл:

- 3 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бойжилтыг Биеийн хөдөлгөөнөө удирдах чадвар, Нийгэмшихүйн чадвар, Оюун ухааны чадварын байдлаар тодорхойлно.
- 3-6 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бойжилтыг Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж, Нийгэмшихүйн чадамж, хэл, ярианы чадамж, Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамжийн байдлаар тодорхойлно.

1.22. "ГСТ"-нд хамрагдах үеийн хөгжлийн түвшингийн байдал" хэсэгт сурагчийн ГСТ-өөр хичээллэх үеийн буюу хөгжлийн түвшингийн гарааны нөхцөл байдлын талаар дор дурдсан 5 үзүүлэлтийн дагуу түүний эцэг, эх /асран хамгаалагч/ -аас асууж тэмдэглэнэ.

- "Өөртөө үйлчлэх энгийн чадвар" хэсэгт гараа угаах, гутлаа өмсөх, тайлах чадварын талаар асуухаас гадна туслах хэрэглэгдэхүүн хэрэглэдэг эсэх /таяг, тэргэнцэр гэх мэт/, хэрэглэдэг бол сургуулийн орчинд ямар нэгэн хүндрэл учирдаг эсэхийг тодруулна.
  - "Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол" хэсэгт үсэг, тоо тоолол, өнгө ялгах гэх мэт үйл ажиллагааг ямар түвшинд хийдэг талаар тодруулна.
  - "Нийгэмшихүй" хэсэгт бусадтай харьцах, бусдыг дуурайх, өөрийгөө илэрхийлэх арга барил, дүрэм журмыг дагах гэх мэт байдлын талаар тодруулна.
  - "Бие бялдар, хөдөлгөөн" хэсэгт алхах, гүйх, тэнцвэр, бөмбөг шидэх гэх мэт үйлийг хэрхэн хийж гүйцэтгэдэг талаар асууж тодруулна.
  - "Анги удирдсан багшийн тодорхойлолт" хэсэгт тухайн сурагчийн зан төлөв, суралцахуйн бэрхшээл, харилцах чадвар, гэр бүлийн харилцааны тухай юуг анхаарах, түүнтэй харьцахад хэрэглэх арга зүйн талаар өөрийн ажигласан зүйлсийг анги удирдсан багш тэмдэглэнэ.
- 1.23. "Оролцогч талуудын хүсэл, зорилго" хэсэгт энэхүү ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэснээр сурагчид хүүхдийн сонирхлыг бичнэ, эцэг эх, асран хамгаалагч, багш тус бүрийн юунд хүрэхийг зорьж буй хүсэл зорилгыг асууж тодорхой бичнэ.
- "Сурагчийн хүсэл" хэсгийг хоосон орхиж болохгүй. Сурагч өөрийн хүсэл, сонирхлоо илэрхийлж чадсан тохиолдолд бичих, эсвэл өөрийн хүсэл, сонирхлоо бие даан илэрхийлэх чадамжгүй тухай бичиж тэмдэглэнэ.
- 1.24. Энэхүү хэсгийн мэдээллийг бүрэн бөглөсөн гэж үзсэн тохиолдолд тэмдэглэл хөтөлсөн багш болон сурагчийн эцэг, эх /асран хамгаалагч/ нар танилцан гарын үсэг зурна.
- Хоёр. "Урт хугацааны зорилт" хэсэгт сурагчийн тухайн хичээлийн жилд эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн хүрэх түвшинг тодорхойлж дэвшүүлсэн зорилтыг биелүүлэхэд үзүүлэх дэмжлэгийн орчинг сонгож бичнэ.
- 2.1. Тус хэсгийн хүснэгтийн дээд талд "Сурагчийн овог нэр", "Анги, бүлэг", "Хүйс", "Төрсөн огноо" зэргийг дахин бичнэ.
- 2.2. "Урт хугацааны зорилт" хэсэгт сурагчийн тухайн хичээлийн жилд эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн хүрэх түвшинг хүүхдийн хөгжлийн айн түвшинд нийцүүлэн зөвхөн шаардлагатай "ай"-н хувьд зорилтыг тодорхойлж бичнэ. Бүх "ай"-г заавал хамрах албагүй.
- Сурагчийн урт хугацааны зорилтыг тодорхойлоход хүүхдийн хөгжлийн айн

ангиллыг ашиглана.

Жишээлбэл: ".....-г хийж чадна" гэж бичихдээ дэлгэрэнгүй, тодорхой бичнэ. "1-5 хүртэлх цифрийг мэднэ" гэх төдий биш харин "1-5 хүртэлх цифрийг бичдэг, уншдаг, тооны утгыг ойлгодог, цифр болон тоог харьцуулж, харгалзуулж чадна" гэх мэтээр хүүхдийн хөгжлийн бодит байдал, чадамжийн хүрэх түвшинг аль болох дэлгэрэнгүй, тодорхой зорилт болгон тодорхойлно.

Өөртөө үйлчлэх энгийн чадвар	Хэд яриа, танин мэдэхүй, тоо тоолол	Нийгэмшихүй	Хөдөлгөөн
<ul style="list-style-type: none"> <li>•Хувцсаа солих</li> <li>•Хооллолт</li> <li>•Гар угаах</li> <li>•Гутлаа өмсөж, тайлах</li> <li>•Туслах</li> <li>•Сургуульдаа өөрөө ирж, очих</li> <li>•Дэлгүүр явах</li> <li>•Автобусанд суух гэх мэт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Хэлбэр</li> <li>•Өнгө</li> <li>•Тоо</li> <li>•Хэмжээ</li> <li>•Үсэг унших, бичих</li> <li>•Тестэй зүйлээр орлуулан тоглох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Дуурайх</li> <li>•Дохио зангаа ашиглан ярилцах</li> <li>•Дүрэм журмыг дагах г.м</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Бөмбөг шидэх</li> <li>•Алхах, гүйх</li> <li>•Модон шоо өрөх</li> <li>•Товч товчлох</li> <li>•Гутлаа үдэх</li> <li>•Ямар нэг зүйлийг гаргах, хийх г.м</li> </ul>

2.3. "Дэмжлэгийн орчин" хэсэгт "Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг", "Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг", "Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг" гэсэн 3 төрлийн дэмжлэгийн орчинг хэрхэн бүрдүүлж, хэзээ, ямар чиглэлийн дэмжлэг үзүүлэхийг тодорхойлж бичнэ. Тодруулбал,


Сургуулийн амьдрал дахь хичээлийн бус цагийн үйл ажиллагаа	Засан сайжруулах, дэмжлэг үзүүлэх сургалтын цаг	Судлагдахуунаар
<ul style="list-style-type: none"> <li>• Сургуульд өөрөө ирж очих</li> <li>• Хооллолт</li> <li>• Бие засах г.м</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэл яриа</li> <li>• Эмчилгээний биеийн тамир</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол хэл</li> <li>• Математик</li> <li>• Ахуй засал</li> <li>• Байгалийн ухаан</li> <li>• Дуу хөгжим</li> <li>• Биеийн тамир</li> </ul>



Жишээлбэл, Б.Оргилын хувьд:

Хөгжлийн ай	Урт хугацааны зорилт	Дэмжлэгийн орчин		
		Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг	Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг	Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг
Өөртөө үйлчлэх энгийн чадвар	Хувцасны шүүгээгээ олоод хувцсаа өөрөө хийх, авах	Хичээл эхлэхээс өмнө, хичээл дууссаны дараа		
Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	Үндсэн 3 өнгө, дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг ижлээр нь олсх			Математик,
Нийгэмшихүй	Сууж сургах, уух хэрэгцээг нь зурган карт ашиглан илэрхийлж сургах	-Сургуульдаа ирэх, тарах үед багштайгаа -Найз нөхөдтэй уулзахдаа	Ахуй засал	Нийгэм ахуйн баримжаа
Бие бялдар, хөдөлгөөн				

Гурав: "Богино хугацааны зорилт" хэсэгт өмнөх буюу "Урт хугацааны зорилт"-д хүрэх алхмыг хэд хэдэн богино хугацаанд хуваан 3 дэмжлэгийн орчин тус бүрээр зорилт болгон тодорхойлох бөгөөд багшийн хэрэглэх арга зүй, үзүүлэх дэмжлэг зэргийг тус тус тодорхойлж бичнэ. Жишээлбэл, богино хугацааны зорилт нь улирлаар эсвэл хагас жилээр тодорхойлогдож болно.





- 3.1. "Сурагчийн овог нэр", "Анги, бүлэг", "Хүйс", "Төрсөн огноо" зэргийг дахин бичнэ.
- 3.2. Урт хугацааны зорилтыг өмнөх хуудаснаас хуулбарлан бичнэ. Учир нь урт хугацааны зорилт хэсэгт бичигдээгүй зорилтыг богино хугацааны зорилтын хүснэгтэд бичихгүй болно.
- 3.3. Богино хугацааны зорилтын дэмжлэгийн орчин ихээхэ, хаана гэсэн хэсэг дээр "урт хугацааны зорилт" хэсэг дээр сонгогдсон дэмжлэгийн орчинг "Урт хугацааны зорилт" хуудсаас шууд хуулбарлан бичнэ.
- 3.4. Богино хугацааны зорилт нь тухайн сурагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлага, чадамжтай уялдуулан урт хугацааны зорилтыг биелүүлэхэд чиглэгдсэн үе шаттай хэрэгжүүлэх улирлын зорилтууд байна.
- 3.5. "Сурагчийн хийх үйл ажиллагаа" хэсэгт бичигдсэн "Өөртөө үйлчлэх энгийн чадвар", "Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол", "Нийгэмшихүй", "Бие бялдар, хөдөлгөөн" гэсэн хөгжлийн айн хувьд харгалзах хүүхдийн зарим чадвар, чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн хүрэх зорилтыг бичнэ. Энэ хүснэгтэд бичигдэх сурагчийн үйл ажиллагааг нь ямагт "Сурагч" гэсэн үгээр эхэлбэл зохино.
- 3.6. "Багшийн дэмжлэг арга зүй" хэсэгт тухайн хүүхдийн тавьсан зорилгодоо хүрэхэд хэрхэн яаж туслах, хүүхдийн мэдлэг, ур чадварын ямар түвшинг яаж ахиулахын тулд, ямар агуулга судлах, ямар даалгавар хийлгэх, ямар үйлдэлд сургах, ямар арга зүй хэрэглэх, ямар дэмжлэг туслалцаа үзүүлэхийг тодорхой үе шатны дагуу бичнэ. Бичихдээ "Багш" гэсэн үгээр эхлүүлбэл зохино.
  - Энэ хэсэгт багшийн арга зүйн нэрийг Тоглоомын арга, Хуулбарлан таниулах, Үлгэрлэн үзүүлэх, Дүрд тоглох, Тулгуур дохио, Эвлүүлдэг тоглоомын арга гэх бичих биш үйлдэл тус бүрээр нарийвчлан бичнэ.
- 3.7. "Эцэг эхийн дэмжлэг, туслалцаа" хэсэгт богино хугацааны зорилтыг хэрэгжүүлэхэд гэрийн орчин нөхцөлд эцэг, эх асаран хамгаалагч ямар дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг тодорхой бичиж, тэдэнд хлбогдох заавар зөвлөгөөг өгнө. Эцэг эх нь асаран хамгаалагч багштай хамтран төлөвлөнө.
- 3.8. "Улирлын үнэлгээ" хэсэгт суралцагчийн тухайн хугацаанд тавьсан зорилтоо биелүүлсэн явцад хийсэн багшийн ажиглалтын тайлан буюу сурагчийн суралцах үйл явцын үнэлгээ, түүний гаргасан ахиц амжилтыг бичиж богино хугацааны зорилт хэрхэн биелэгдсэнийг үнэлж бичнэ. Тус үнэлгээ нь 2 хэсэг бүхий мэдээллээс бүрдэнэ:
  - Эхлээд "Суралцагчийн үнэлгээ" хэсэгт сурагчийн улирлын зорилт биелсэн эсэх, хөгжлийн ахиц, дэвшил гарсан эсэх, эсвэл урьдчилан таамагласан ахиц, дэвшил хангалттай гараагүй учир, шалтгааныг тодорхой бичиж, дараахь үнэлгээг ашиглан үнэлгээг хийнэ. Үүнд:

1. Маш сайн
2. Хангалттай
3. Сайжирч байгаа

- Дараа нь "Багшийн үнэлгээ" хэсэгт тухайн улирлын зорилт хүүхдийн хэрэгцээ шаардлагад хэр нийцсэн, багшийн сонгосон арга зүй тохирсон эсэх, хүүхдийн ахицыг сургуулийн орчинд төдийгүй гэрийн орчинд хэрхэн дэмжин ажилласан, цаашид анхаарах зүйлсийг тодорхой бичнэ.

3.9. Дэмжлэгийн орчин тус бүрээр хуудсыг нэмж бөглөнө.

3.10. Богино хугацааны зорилтыг биелүүлэхэд "Хичээл, судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг"-ийг тодорхойлохдоо хүүхдийн өдөр тутмын амьдралд зайлшгүй шаардлагатай, хэрэгтэй мэдлэг, чадварыг хичээлийн агуулгадаа сонгон оруулах хэрэгтэй.

- Энэ хэсгийн зорилтын сурагч Б.Оргилын хувьд хэрхэн бөглөсөн жишээг үзнэ үү.

**Богино хугацааны зорилт:**

Дэмжлэгийн орчин /хэзээ, хаана/	Улирал	Богино хугацааны зорилт	Сурагчийн хийх үйл ажиллагаа	Багшийн дэмжлэг, арга зүй	Эцэг, эхийн дэмжлэг, туслалцаа
Хичээл эхлэхээс өмнө хичээл дууссаны дараа	1-р улирал	Хувцасны шүүгээгээ олох	Сурагч өөрийн хувцасны шүүгээн дээр байгаа таних тэмдгийг таних	Багш хувцасны шүүгээн дээр нь улаан дугуй дүрсийг нааж, өөрийнх нь хувцасны шүүгээ болохыг таниулж, таних тэмдгийг нүдлүүлнэ. Хувцасны шүүгээний харалдаа чиглүүлэх тэмдгийг байршуулах	Гэрийн хувцасны шүүгээн дээр улаан дугуй дүрсийг нааж өгөх, өөрийн шүүгээ гэдгийг мэдүүлэх

**Дөрөв.** Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж хэсэгт "Богино хугацааны зорилт" хэсэгт бичигдсэн "Улирлын үнэлгээ" хэсгийн үнэлгээнд тулгуурласан дүгнэлтийг "Ололт амжилт" болон "Сайжруулах чиглэл, зөвлөмж" гэсэн үзүүлэлтийн дагуу анги удирдсан багш бичнэ.

4.1. "Сурагчийн овог нэр", "Анги, бүлэг", "Хүйс", "Төрсөн огноо (нас)" зэргийг дахин бичнэ.

4.2. "Урт хугацааны зорилт" хэсэгт тухайн хичээлийн жилд сурагч биелүүлэх "Урт

хугацааны зорилт” хэсэгт бичигдсэн зорилт тус бүрийг нэг бүрчлэн хуулбарлан бичнэ.

4.3. “Ололт амжилт” хэсэгт Урт хугацааны зорилтыг биелэлтийн явцыг үнэлж, сурагчид гарсан эерэг өөрчлөлт, ололт, амжилт, ахицыг тус тус бичнэ.

4.4. “Сайжруулах чиглэл, зөвлөмж” хэсэгт урт хугацааны зорилт нь хүүхдийн суралцах чадвар, чадамжид нийцсэн эсэх, багшийн гаргасан алдаа, дутагдал зэрэгт тулгуурлан дараагийн хичээлийн жилд ГСТ-өөр хичээллэх эсэх, хичээллэх тохиолдолд сурагчийн хувьд тавих урт хугацааны зорилт, сургуулийн орчин болон гэрийн нөхцөлд үзүүлэх дэмжлэг, туслалцааны талаархи чиглэл, зөвлөмжийг тус тус бичнэ. Жишээлбэл:

**Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж :**

Урт хугацааны зорилт	Дүгнэлт	
	Суралцагчийн үнэлгээ (ололт амжилт)	Сайжруулах чиглэл, зөвлөмж
Хувцасны шүүгээгээ олоод хувцсаа өөрөө хийх, авах	Хувцасны шүүгээний таних тэмдэг болох “улаан дугуй” дүрсийг багшийн тусламжтай олдог болсон боловч өөрөө бие даан гүйцэтгэж чадахгүй байгаа учраас “сайжирч байгаа” гэж үнэлж байна.	Багшийн зааврын дагуу хувцасны шүүгээгээ өөрөө бие даан олж, хувцасны шүүгээ нээж хувцсаа хийдэг болсон. Харин бие дааж гүйцэтгэж чадахгүй байгаа тул тус зорилт нь сурагчийн чадвар, чадамжид ахадсан байна. Иймд тус чадварыг сурагч өөрөө бие дааж гүйцэтгэх зорилтыг дараагийн хичээлийн жилд ГСТ-өөр хичээллэх явцад олгох. Багшийн зүгээс тухайн хүүхдийн сонирхолд тулгуурласан аргыг ашиглах шаардлагатай. Эцэг, эхийг гэрийн нөхцөлд туслан дэмжих арга зүйд сургахад анхаарах.

Тав. ГСТ-г боловсруулахад анхаарах зүйлс:

5.1. Зорилтыг эерэг хэлбэрээр бичнэ. Жишээ нь: “Завсарлагааны цагаар гүйхгүй” гэх биш харин “Завсарлагааны цагаар гүйлгүй, алхаж дараагийн үйл ажиллагаа руу шилжинэ” гэх мэт.

5.2. Ямар зүйлийг чаддаг болох тухай дэлгэрэнгүй тодорхой бичих

5.3. Богино хугацааны зорилт нь тавьсан хугацаандаа биелэгдэхүйц байхаар бичнэ.

5.4. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн давуу ба сул тал, онцлог, хэрэгцээ шаардлагыг харгалзсан байх

5.5. Арга зүйн дэмжлэг үзүүлэх явцад тухайн хүүхдэд ахиц гарах бүрт урамшуулан дэмжих олон талт аргыг хэрэглэн итгэл төрүүлдэг байх

5.6. Хүүхдэд эзэмшүүлж буй мэдлэг, дадал чадварыг хэрэглээ болгон хэвшүүлэхэд гэрийн нөхцөлд яаж хамтран ажиллахыг тусгахыг эрмэлзсэн байх.

5.7. Хүүхдийн хүрч чадах түвшинг хэт ахиулан тавихгүй байх

5.8. Багш нар хамтарч ажилласан байх

5.9. Улирал бүрд хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэн ГСТ-нд өөрчлөлт оруулах эсэхийг нягталж байх

5.10. Хичээлийн явц дахь хүүхдийн байдалд ажиглалт хийн, цаашид анхаарах бусад анхаарах зүйлийн талаар бичих

5.11. Үнэлгээ хийх явцад, хичээлийн явц дахь хүүхдийн байдлыг нэмээд, хүүхдийн бүтээл, тарааж өгөх материал, тест, багшийн тэмдэглэл зэргийг ашиглан үнэлгээ хийх

5.12. Эцэг эх, асран хамгаалагчтай нь мэдээлэл солилцон, гэртээ байх үеийн байдалд нь дүн шинжилгээ хийж түүнийгээ мөн үнэлгээндээ тусгана.

5.13. Дэвшүүлсэн зорилт, арга зүй, багшийн дэмжлэгийн үнэлгээ нь дараагийн улирлын богино хугацааны зорилт болон арга зүйтэй холбох зорилготой үнэлгээ тул аль болох нарийвчлан тодорхой бичих

Хавсралт

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын  
2015 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1/302

## ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН АХИЦЫГ ҮНЭЛЭХ АЖИГЛАЛТЫН ХУУДАС

### ТАЙЛБАР:

Хүүхэд тус бүрийн чадвараас хамааран "Чаддаггүй" бол 1, "Дэмжлэгтэй" бол 2, "Чаддаг" бол 3 гэсэн үнэлгээг хүснэгтэд тэмдэглэнэ. Нийт онооны дүнг тухайн хэсгийн чадварын тоонд хувааж "Гүйцэтгэлийн дундаж" гарна.

### 1. Биеийн хөдөлгөөнөө удирдах чадвар

№	Чадвар	Чаддаг -гүй	Дэмж- лэгтэй	Чаддаг
1.1	Шалан дээр байгаа зүйлийг доош бөхийн барьж авна.			
1.2	Ор болон өмдөр сандал дээр гарч, бүүж чадна.			
1.3	Том хайрцагт юмсыг зөөж хийнэ.			
1.4	Хөтөвч, сүүлтүүрт бие засахдаа өөрөө сууж, босно.			
1.5	Шатаар өгсөж, уруудна.			
1.6	Аяга, халбагаа зөв барьж хэрэглэнэ.			
1.7	Зузаан (картонон) хуудастай номын хуудсыг нэг нэгээр нь эргүүлнэ.			
1.8	Бүдүүн харандаа, тосон харандаа ашиглаж, цаасан дээр зураас татна.			
1.9	Хувцсаа өөрөө тайлна.			
1.10	Гараа угааж, арчина.			
1.11	Цэвэрхэн хооллоно.			
1.12	"Болно", "Болохгүй" гэсэн энгийн зааврыг ойлгож биелүүлнэ.			

## 2. Нийгэмшихүйн чадвар

№	Чадвар	Чаддаг -гүй	Дэмж- лэгтэй	Чаддаг
2.1	Өөрийн эд юмсыг бүсдынхаас ялгана.			
2.2	"Би өөрөө" гэж үйл хийхийг эрмэлзэнэ.			
2.3	Өөрийн хэрэгцээг дуу авиа, нүүрний хувирал, үгээр илэрхийлнэ.			
2.4	Ойр орчныхоо хүнтэй дотносоно.			
2.5	Тааламжтай байгаагаа илэрхийлнэ. (Жишээ нь: Хөгжим сонсоод инээмсэглэх, биеэрээ найгах)			
2.6	Өөртөө тааламжгүй байдлыг дуу авиа, үг, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлж, насанд хүрэгчдээс тусламж, чиглэл хүлээнэ.			
2.7	Юмсыг зориулалтаар нь хэрэглэнэ. (Жишээ нь: Харандаагаар зурах, халбагаар хоолоо идэх, хөтөвч хэрэглэх)			
2.8	Бүсдын үйлдлийг ажиглана, дуурайна. (Жишээ нь: Хүүхэлдэй бүүвэйлнэ, хооллоно.)			

## 3. Оюун ухааны чадвар

№	Чадвар	Чаддаг -гүй	Дэмж- лэгтэй	Чаддаг
3.1	Хүн, амьтан, юмсыг зургас таньж, асуухад зааж нэрлэнэ.			
3.2	Амьтдын дуу авиаг дуурайж дуугарна.			
3.3	Юмсыг төрлөөр нь ялгана. (Жишээ нь: Бөмбөг, машиныг тус тусад нь)			
3.4	Янз бүрийн хэмжээ, хэлбэртэй тоглоомоор тоглоно, асуухад "том", "жижиг"-ийг заана, хэлнэ.			
3.5	"Нэг", "Олон"-г ялгаж хэлнэ.			
3.6	Гэр болон цэцэрлэгт байгаа дуртай зүйлийнхээ байрлалыг мэднэ.			
3.7	Хогийг саванд нь хийнэ.			
3.8	Нэг үйлдэлт зааврыг дагана. (Жишээ нь: "Надад бөмбөг аваад ир" гэхэд авчрах)			
3.9	Богино өгүүлбэрээр ярина. (Жишээ нь: "Би явна", "Ээждээ өгнө")			

**ТАЙЛБАР:**

Багш хүүхдийг тодорхой үйл гүйцэтгэх явцад ажиглаж, тухайн чадамжийг илрүүлэх асуултуудын ард дөрвөлжин буюу дугуй дотор байгаа 1-5 хүргэлх онооноос тохирох оноог сонгож тэмдэглэнэ. Дөрвөлжин доторх оноо нь хүүхдийн гүйцэтгэж буй үйлийн гүйцэтгэлийн чанар ямар байгааг ("тохирцоор"), дугуй дотор байгаа нь хүүхдийн сонирхол, сэдэл, дадал хэвшлийн эзэмшилт ямар байгааг (ажиглагдаж буй "давтамжаар" буюу хэр олон удаа "тохиолдож" байгаагаар) илрүүлднэ. Дөрвөлжин, дугуй доторх тооны аль аль нь ахих тутам хүүхдэд тухайн асуултын дагуу чанарын ахиц гарч байгааг илтгэнэ.

Багш оноо тус бүрийн ард буй тайлбарын утгыг маш сайн анхаарч, тохирох эсхийг нягтлан тэмдэглэнэ. Бүх асуулт гаглагдсаны дараа эхлээд тухайн чадамжийн хэсэг тус бүрийн онооны дүн, гүйцэтгэл (Онооны дүнг асуултын тоонд хуваана.)-ийг, дараа нь тухайн чадамжийн нийт оноог нэгтгэж, гүйцэтгэлийн дунджийг гаргана.

**Давтамж**

- ① Огт тохиолддоггүй.
- ② Хаяаа нэг тохиолддог.
- ③ Байн байн тохиолддог.
- ④ Ихэнхдээ тохиолддог.
- ⑤ Дандаа / байнга тохиолддог.

**Тохирцо**

- 1 Огт тохирохгүй байна.
- 2 Ховор тохирч байна.
- 3 Дундаж хэмжээнд тохирч байна.
- 4 Ихэнхдээ тохирч байна.
- 5 Яг тохирч байна.

**1. ХӨДӨЛГӨӨН, ЗРҮҮЛ МЭНДИЙН ЧАДАМЖ**

**1.1. Биений хөдөлгөөнөө удирдах**

1.1.1	Тэнцвэрээ хадгалан 20 см өргөн зургаасан дундуур давж гишгэхгүйгээр арагш ухарч явна.	1	2	3	4	5
1.1.2	Дүүрэн үстай ундааны шилэн аяга (стакан)-ыг нэг гартаа бариад усыг цалгиулахгүйгээр өрвөний нэг талаас нөгөө тал хүртэл алхана.	1	2	3	4	5
1.1.3	Тасалгаан дотор хурдаа тохируулж гүйнэ.	1	2	3	4	5
1.1.4	Хөлийг салгалгүйгээр зургаасны дагуу үсэрнэ.	1	2	3	4	5
1.1.5	Шаланд ойлгож дамжуулсан бөмбөгийг алдахгүйгээр хоёр гараараа барьж авна.	1	2	3	4	5
1.1.6	Хоёр гараараа дундаж хэмжээтэй (диаметр нь 10 см орчим) бөмбөгийг дээш шидээд, алдахгүй барьж авна.	1	2	3	4	5
1.1.7	Нэг гараараа жижиг бөмбөгийг 1 метр орчим өндөрт шидээд, унагахгүй барьж авна.	1	2	3	4	5
1.1.8	Баиг алдахгүй оноо.	1	2	3	4	5
1.1.9	Цэгэригийг нэг гараараа түрж өнхрүүлднэ.	1	2	3	4	5
1.1.10	Налуу шатанд авирна.	1	2	3	4	5
1.1.11	Хүүхдийн өндөрт тохирсон савлуураас нэг нэг гараараа ээлжлэн барьж, 1 метр зайд явна.	1	2	3	4	5
1.1.12	Дээсэнд алдахгүйгээр 5 удаа үсэрнэ.	1	2	3	4	5
1.1.13	Өгсөн дохионы дагуу хөдөлгөөнөө эхэлж, дуусгана.	1	2	3	4	5

**1.2. Гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах**

1.2.14	Хувцсаа тайлж, өмсөнө. (Жишээ нь: Төвчилнө, цахилгаан татах, гутлаа үдэх.)	1	2	3	4	5
1.2.15	Гурваар жигд сүлжинэ. (олс, үяа)	1	2	3	4	5
1.2.16	Ирмэгүүдийг яг давхцуулан цаасан нүгэлбэр хийнэ.	1	2	3	4	5
1.2.17	Дүрсийг хүрээнээс гаргалгүй будна.	1	2	3	4	5
1.2.18	Шагайг онож нясална.	1	2	3	4	5
1.2.19	Энгийн дүрсийг дүүрайлган зурна. (Жишээ нь: Гэр, мод, машин)	1	2	3	4	5
1.2.20	Дүрсийг хүрээний дагуу хайчилна.	1	2	3	4	5



### 1.3. Эрүүл мэндээ хамгаалах

1.3.21	Гараа бохирдсон үед нь болон бие зэссаны дараа сануулгаг үйгээр угаана.	①	②	③	④	⑤
1.3.22	Хоолой, амаа бие даан зайлна.	①	②	③	④	⑤
1.3.23	Бие зэссаны дараа ариун цэврийн цаасыг бие даан зөв хэрэглэнэ.	①	②	③	④	⑤
1.3.24	Хувцсаа орчин, үйл ажиллагаандаа тохируулан өмсөнө. (Жишээ нь: Гадаа тоглох, дасгал хөдөлгөөн хийхэд)	①	②	③	④	⑤
1.3.25	Сайн зажилж, тайван хооллоно.	①	②	③	④	⑤
1.3.26	Ямар хүнсний зүйл хүний биед сайн, мууг мэднэ. (Жишээ нь: Сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо; их хэмжээтэй чихэрлэг зүйл, хийжүүлсэн үндаа)	①	②	③	④	⑤
1.3.27	Хийж болохгүй, осолтой үйлдлүүдийг мэднэ. (Жишээ нь: Халуун зуухнаас хол байх, морь малын хөлд ойртохгүй байх)	①	②	③	④	⑤
1.3.28	Ангийн аюулгүйн дүрмийг мөрдөнө. (Жишээ нь: Хайчны амьг хаах, харандааны үзүүрийг доош харуулж өгөх)	①	②	③	④	⑤

## 2. НИЙГЭМШИХҮЙН ЧАДАМЖ

### 2.1. Зан чанар

2.1.1	Шинэ дасгал, даалгаврыг хийж үзэхдээ итгэлтэй байна.	①	②	③	④	⑤
2.1.2	Өөрийн хийх үйлээ сонгоно. (Жишээ нь: Сургалтын аль төвд ажиллах, ямар дурд тоглох)	①	②	③	④	⑤
2.1.3	Чадах зүйлээ бие даан гүйцэтгэнэ. (Жишээ нь: Тоглоомоо хураах, хувцсаа өмсөх, тайлах)	①	②	③	④	⑤
2.1.4	Хийж бүтээсэн зүйлдээ баярлана.	①	②	③	④	⑤
2.1.5	Эхэлсэн зүйлээ хийж дуусгана.	①	②	③	④	⑤
2.1.6	"Болно, болохгүй", "Сайн, муу"-г ялгана.	①	②	③	④	⑤
2.1.7	Шинэ зүйлд соргог хандаж сонирхоно, оролдож, түршиж үзнэ.	①	②	③	④	⑤
2.1.8	бусад хүүхэд, томчуудаас өөр санал бодолтой байвал эмээхгүйгээр өөрийнхөө санааг хэлнэ.	①	②	③	④	⑤
2.1.9	Асуудал, зөрчлийг өөрийн хэр хэмжээнд шийдвэрлэнэ.	①	②	③	④	⑤

### 2.2. Сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, удирдах

2.2.10	Тухайн нөхцөл байдалд тохирсон сэтгэл хөдлөлийг үзүүлж чадна. (Жишээ нь: Жүжгийн инээдэмтэй хэсгийг үзээд баясан инээх)	①	②	③	④	⑤
2.2.11	Магтаал, зөвлөлийг мэдэрч сэтгэгдлээ илэрхийлнэ. (Жишээ нь: Эмлэхэд дуугаа хурааж дүнсийх, магтуулсан бол үрамшин хийж буй зүйлдээ шамдах, нүүр царайд нь баясал тодрох)	①	②	③	④	⑤
2.2.12	Өөрийнхөө сэтгэл хөдлөлийн шалтгааныг тайлбарлана. (Жишээ нь: Яагаад уурласан, яагаад үйтгартай байгаа)	①	②	③	④	⑤
2.2.13	Уур бухимдлаа тайван давж гарна. (Жишээ нь: Бэгшаараа аргадуулах, өөр зүйлд анхаарч хийх)	①	②	③	④	⑤
2.2.14	Бусдыг мэдэрч, зохицон харилцана. (Жишээ нь: Нэгнийгээ үйлбал аргадах, найзынхаа тоглоомыг авахад дургүйцвэл буцаан өгөх)	①	②	③	④	⑤



### 2.3. Бусадтай харилцах

2.3.15	Бусдын баяр баясгаланг хуваалцана.	1	2	3	4	5
2.3.16	Цэцэрлэгтээ дуртай ирж, чөлөөтэй, таатай байдаг.	1	2	3	4	5
2.3.17	Өөрөө санаачилж, бусадтай харилцаа тогтоосно.	1	2	3	4	5
2.3.18	Олно өмнө гарахаасаа айж сандрахгүй байна. (Жишээ нь: Үлгэр өгүүллэг ярих, дуулах, жүжигчлэн тоглох)	1	2	3	4	5
2.3.19	"Баярлалаа", "Уучлаарай" үгийг зохих тохиолдолд тогтмол хэрэглэнэ.	1	2	3	4	5
2.3.20	Бусдын тоглоом, эд зүйлсийг хэрэглэхдээ зөвшөөрөл авна.	1	2	3	4	5
2.3.21	Аливаа үйлийг гүйцэтгэхдээ өөрийн ээлжийг хүлээнэ.	1	2	3	4	5
2.3.22	Амлалтаа биелүүлнэ, бусдаас амлалтандаа хүрэхийг шаардана.	1	2	3	4	5
2.3.23	Дүрэм журам, зааврыг дагаж биелүүлнэ.	1	2	3	4	5

## 3. ХЭЛ ЯРИАНЫ ЧАДАМЖ

### 3.1. Сонсох, ойлгох

3.1.1	Байгалийн дуу чимээ, амьтдын дуу авиаг сонсож ялгана. (Жишээ нь: Усны чимээ, тэнгэрийн дуу, шувуудын жиргээ)	1	2	3	4	5
3.1.2	Урт, богино эгшигтэй үгийг ялгаж сонсоно. (Жишээ нь: сар-саар, үл-үүл)	1	2	3	4	5
3.1.3	Ойролцоо дуудлагатай үгийг ялгаж сонсоно. (Жишээ нь: Энх мөнх, дэлгэр цэлгэр, яруу даруу)	1	2	3	4	5
3.1.4	Үлгэр зохиолыг анхааралтай, идэвхтэй сонсоно. (Жишээ нь: Ярьж байгаа хүний нүүр рүү харах, ойлгосон хэсгээ бусдадаа ярих, тайлбарлах, ойлгоогүй зүйлээ тодруулан асуух)	1	2	3	4	5
3.1.5	Үлгэр зохиолоос төрсөн мэдрэмжээ илэрхийлнэ. (Жишээ нь: Инээх, хөмсгөө зангидах, алга таших)	1	2	3	4	5
3.1.6	2-оос цөөнгүй үйлдэл шаардах зааварчилгааг дагаж биелүүлнэ. (Жишээ нь: Эхлээд тоглоомоо хураана, дараа нь зурагтай номоо авч үзнэ)	1	2	3	4	5

### 3.2. Ярих

3.2.7	Бусдын асуултыг анхааралтай сонсож, тохирох хариулт өгнө.	1	2	3	4	5
3.2.8	Өөрийн санаа бодлоо ойлгомжтой илэрхийлнэ.	1	2	3	4	5
3.2.9	Үлгэр, өгүүллэг, болсон үйл явдлыг бусдад ярина.	1	2	3	4	5
3.2.10	Ангиараа хийж буй ярилцлага, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцоно. (Жишээ нь: Санаачилгаараа ярих, асуулт тавих)	1	2	3	4	5
3.2.11	Үлгэр, өгүүллэгийн өрнөл, төгсгөлийг гүйцээн зохиомжлон ярина.	1	2	3	4	5
3.2.12	Сайн мэдэх үлгэрийн агуулгыг зургийн дарааллын дагуу ярина.	1	2	3	4	5
3.2.13	Онъсого, түргэн хэллэг, зүйр цэцэн үг хэлнэ.	1	2	3	4	5
3.2.14	Өөрөө зурагт ном бүтээж агуулгыг тайлбарлана.	1	2	3	4	5

### 3.3. Унших, бичих бэлтгэл

3.3.15	Номын зургийг тайлбарлан ярина.	1	2	3	4	5
3.3.16	Ойр орчиндоо буй тэмдэг, тэмдэглэгээг "уншиж" чадна. (Жишээ нь: Явган хүний гарц, автобусны зогсоол, түргэн тусламжийн машин)	1	2	3	4	5
3.3.17	Богино хэмжээний шүлэг уншина.	1	2	3	4	5
3.3.18	Зурган бүдүүвч ашиглан өгүүллэр зохионо.	1	2	3	4	5
3.3.19	Өөрийн дуртай үлгэрийн баатрыг зурна.	1	2	3	4	5
3.3.20	Төрөл бүрийн зураас зурна. (Жишээ нь: Цэг, ташуу, махир, тахир, нуман зураас)	1	2	3	4	5

#### 4. ОРЧНОО ТАНЬЖ МЭДЭХ, ОРЧИНТОЙГОО ХАРИЛЦАХ ЧАДАМЖ

##### 4.1. Орчноо шинжлэн судлах

4.1.1	Байгаль орчинд болон туршилтын явцад ажигласан үзэгдлийн учир шалтгааны талаар асуулт тавьж, таамаглал дэвшүүлнэ.	1	2	3	4	5
4.1.2	Үйл явдал, учир шалтгааны талаар лавлана. (Жишээ нь: Яагаад ийм байдаг гэж?, Яагаад оройтсон бэ?)	1	2	3	4	5
4.1.3	Ургамлын ургалтад агаар, ус, гэрэл, дулаан яаж нөлөөлдгийг тайлбарлан ярина.	1	2	3	4	5
4.1.4	Байгаль шинжлэлийн туршилтад дуртай оролцоно. (Жишээ нь: Хөвөх, живэх, унах, хийсэх)	1	2	3	4	5
4.1.5	Юмсын шинж чанарыг сонирхоно, ялгана. (Жишээ нь: Хатуу-зөвлөн, хүнд-хөнгөн, гөлгөр-бэрзгар, гашуун-чихэрлэг, чанга-сул)	1	2	3	4	5

##### 4.2. Орчинтойгоо харьцах

4.2.6	Байгальд юу нь гоё сайхан байгааг илэрхийлэн ярина.	1	2	3	4	5
4.2.7	Орчноо цэвэр байлгана. (Жишээ нь: Хогоо хогийн саванд хийнэ)	1	2	3	4	5
4.2.8	Тоглосон, хэрэглэсэн зүйлээ буцааж байранд нь хураана.	1	2	3	4	5
4.2.9	Ургамлыг арчилж үргүүлнэ. (Жишээ нь: Услах, арчих, хөрсийг сийрэгжүүлэх, хатсан навчийг түүх)	1	2	3	4	5
4.2.10	Нутаг орныхоо гоё, сайхан зүйлийг дүрслэн зурна, тайлбарлана.	1	2	3	4	5



Захиргааны хэм рэгээгэмгий  
актын улсын нэгдсэн саянд  
2018 оны 04 сарын 03-ны  
өдрийн 3825 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар, Насан туршийн боловсролын үндэсний төв, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газар, аймаг, дүүргийн Насан туршийн төвийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 362 дугаар тушаалаар баталсан "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

800743

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 04 дугаар сарын 03-ны  
өдрийн 1/168 тоот тушаалын ..... хавсралт



## БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРӨӨР СУРГАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Иргэнд тодорхой хугацааны боловсролыг нөхөх, бие даах хэлбэрээр эзэмшүүлэх зорилго бүхий бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад нийцсэн сургалтын албан бус хэлбэрийг дүйцсэн хөтөлбөрийн сургалт гэнэ.

1.2. Албан боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй сургуулийн насны хүүхдэд суурь боловсрол заавал олгох, бүх нийтийн ерөнхий боловсрол нөхөн эзэмших, бие даан суралцах хүсэлтэй иргэдэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол эзэмшүүлэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Дүйцсэн хөтөлбөрийн сургалт (цаашид "сургалт" гэх)-ын агуулга, арга зүй, хэлбэр, хугацаа нь суралцагчдын боловсрол эзэмших хэрэгцээ, боломж, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн, олон хувилбартай, уян хатан, чөлөөтэй, нээлттэй байна.

1.4. Сургуульд огт суугаагүй, хоёр ба түүнээс дээш жил завсардсан иргэнийг дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамруулна.

### Хоёр. Сургалтын зохион байгуулалт

2.1. Насан туршийн боловсролын үндэсний төв, аймаг, нийслэлийн Боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн Засаг дарга захирамж гаргаснаар хуулийн этгээд (цаашид "сургалт зохион байгуулагч" гэх) дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулна.

2.2. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг сургууль түшиглэсэн байдлаар, алслагдсан сум, багт явуулын багшийн болон холимог бүлгийн (танхимын, зайны, гэрийн буюу шавь сургалт, түр цугларалт, бие даах) сургалтын хэлбэрээр зохион байгуулна.

2.3. Сургалт зохион байгуулагч дараах шаардлагыг хангасан байна.

2.3.1. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөр"-т нийцүүлэн боловсруулж, аймаг, нийслэлийн Боловсролын газраар баталгаажуулсан байх;



2.3.2. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн модуль, багшийн ном, сургалтад ашиглах сурах бичиг, ном, гарын авлагыг бэлтгэсэн байх;

2.3.3. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах байр танхим, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байх;

2.3.4. Сургалт зохион байгуулах багш багшлах эрхтэй, дүйцсэн хөтөлбөрийн агуулга, холимог бүлгийн арга зүйн сургалтад хамрагдсан байх;

2.3.5. Сургалтын зохион байгуулалтын зардлыг нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаас гадна хөтөлбөр төсөл, хандив, тусламж, хамтрагч байгууллагын дэмжлэг бүхий санхүүгийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байх.

2.4. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж буй анги, түвшний зөрүүтэй суралцагч гэрээт хугацаанд зохих түвшний агуулгын стандартыг хангасан тохиолдолд анги дэвшүүлэн суралцуулж боловсролын бичиг баримтыг баталгаажуулна.

### **Гурав. Сургалтын баримт бичиг**

3.1. Сургалтын хөтөлбөрийг дор дурдсан шаардлагын хүрээнд боловсруулан баталгаажуулсан байна;

3.1.1. Бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад нийцсэн, амьдрах ухаанд суурилсан агуулга;

3.1.2. Бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартын арга зүйд тулгуурлан зайны болон холимог бүлгийн сургалтын зарчмыг баримталсан, суралцагчдын хэрэгцээ сонирхолд суурилсан арга зүй;

3.1.3. Бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад нийцэж, суралцагчдыг хөгжүүлэхэд чиглэсэн үнэлгээ.

3.2. Сургалтын төлөвлөгөөнд дараах агуулгыг тусган баталгаажуулна.

3.2.1. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын хичээлийн жилийн бүтэц, зайны болон бие даах, танхимд хичээллэх сургалтын цагийн хэмжээ, хичээлийн хуваарь;

3.2.2. Багшлах боловсон хүчин, санхүүгийн нөөцийн хуваарилалт, тооцоо;

3.2.3. Боловсролын түвшин бүрээр судлах сурах бичиг, модулийн төрөл, тоо;

3.2.4. Давтлага, шалгалтын хуваарь.

3.3. Сургалтын явцад дор дурдсан баримт бичгийг хөтөлнө. Үүнд:

- Ангийн журнал;
- Анги удирдсан багшийн дэвтэр;
- Суралцагчийн хувийн хэрэг;

- Суурь боловсролын гэрчилгээ;
- Бүрэн дунд боловсролын үнэмлэх;

3.4. Суралцагч бие даан суралцсан мэдлэг, чадварын түвшинг тогтоолгох хүсэлтээ аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төв, нэгжээр уламжлан Боловсролын газарт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

3.5. Аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төв, нэгж нь Боловсролын газрын гаргасан шийдвэрийг үндэслэн сургуульд огт суугаагүй, бие даан зохих түвшний мэдлэг, чадвар эзэмшсэн суралцагчдад хувийн хэрэг нээн тухайн ангийн сурлагын амжилтын түвшний үнэлгээг нөхөн бичиж, холбогдох шийдвэрийг хавсарган баталгаажуулна.

#### **Дөрөв. Сургалтын хэлбэр, хугацаа**

4.1. Дүйцсэн хөтөлбөрийн танхимын сургалт 9 дүгээр сарын 1, бусад хэлбэрийн сургалт 10 сарын 1-ээс эхлэх бөгөөд тухайн хичээлийн жилд сургалт зохион байгуулах сургуулийн удирдлага, хичээл заагч багш нар сургалтад хамрагдах суралцагч тэдний хууль ёсны төлөөлөгчтэй гэрээ байгуулна.

4.2. Сургалтын үргэлжлэх хугацааг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө”-ий 70-аас доошгүй хувь байхаар төлөвлөнө.

4.3. Сургалтыг суралцагчийн мэдлэг, чадварын түвшин, суралцах боломжид үндэслэн танхимын, зайны, бие даах, гэрийн буюу шавь сургалт, түр цугларалтын аль нэгээр, эсвэл эдгээрийн хосолсон хэлбэрээр зохион байгуулах бөгөөд журмын 4.2-т заасан сургалтын хугацааг баримтална.

4.4. Суралцагч танхимаас бусад хэлбэрээр суралцах гэрээ байгуулсан тохиолдолд 4.2-т заасан төлөвлөгөөт цагийн гуравны нэгийг заавал танхимын сургалтаар судлах бөгөөд жилд хоёроос доошгүй удаа, 14 хоногоос доошгүй хугацаагаар сургалтад хамрагдана.

4.5. Сургалтыг 10-аас доошгүй суралцагчтай бүлэг байхаар зохион байгуулна.

4.6. Сургалт эрхлэх, бүртгэх, сунгах тусгай зөвшөөрлийг Боловсролын тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

#### **Тав. Сургалтын явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ**

5.1. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын газар, Насан туршийн боловсролын үндэсний төв, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын мэргэжлийн хяналтын алба тус тус хяналт тавьж, зөвлөн тусалж ажиллана.

5.2. Хамран сургалт, захиргааны удирдлага, зохион байгуулалтаар хангах үүргийг бүх шатны Засаг дарга хүлээх бөгөөд сургалтын явц, чанар, үр дүн, хамрагдалтын талаар сургалт зохион байгуулагчаас гаргасан статистикийн

мэдээллийг хянах чиг үүргийг аймаг, нийслэлийн Боловсролын газар тус тус гүйцэтгэнэ.

5.3. Суралцагчийг ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн суралцуулах асуудлыг сургалт зохион байгуулагч, ерөнхий боловсролын сургууль, Боловсролын газар, орон нутгийг Засаг даргын Тамгын газартай хамтран шийдвэрлэнэ.

5.4. Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж, төгсөлтийн шалгалт өгөх суралцагчдын дэлгэрэнгүй мэдээллийг сургалт зохион байгуулж буй сургуулийн захиргаа аймаг, нийслэлийн Боловсролын газраар дамжуулан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх ба төгсөлтийн шалгалт өгөх, боловсролын үнэмлэх, гэрчилгээ олгох үйл ажиллагааг бага, дунд боловсролын төгсөлтийн шалгалтын журмаар зохицуулна.

#### **Зургаа. Сургалтын санхүүжилт**

6.1. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж буй нэг суралцагчид ногдох нормативт зардлыг Засгийн газраас тогтоосон хэмжээний дагуу улсын төсвөөс санхүүжүүлнэ.

6.2. Дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулахад суралцагчаас төлбөр авахгүй бөгөөд бага, суурь боловсролын сурах бичиг, сургалтын модулиудыг үнэ төлбөргүй ашиглуулна.

6.3. Журмын 4.3-т заасан танхимын сургалтаас бусад хэлбэрийн сургалтыг орон нутагт зохион байгуулахад шаардагдах нэмэлт зардал (унаа, шатахуун, багшийн томилолт, урамшуулал, нүүдлийн үйл ажиллагааны бусад зардал зэрэг)-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

6.4. Төсөл, хөтөлбөр, хандив тусламж, өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг санхүүжилтийн бусад эх үүсвэртэй байж болно.

6.5. Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдын статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлэн баталгаажуулж, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/181

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйл, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах заалтыг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын 3.2.14 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулах, багш нарт зориулсан сургалт зохион байгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтэд тус тус даалгасугай.

3. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчныг бүрдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургууль бүрт гамшиг, онцгой байдлын үеийн дасгал сургуулилт хийх кабинет байгуулах зардлыг судлан, 2019 оны төсөвт тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Санхүү хөрөнгө оруулалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Х.Галсанхүүд даалгасугай.

4. Суралцагчдыг гамшиг, онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварт сургах “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед тэдний сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцсэн байдлаар бусад мэргэжлийн байгуулагуудтай хамтран үр дүнтэй зохион байгуулахыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэнд даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

0300563





**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2018.05.14 № 1-3/2427  
танай 2018.05.07ны № 10/4428 -т

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД  
Ц.ЦОГЗОЛМАА ТАНАА**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам батлах тухай” А/239 дүгээр тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 390.1 дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдье.

ДЭД САЙД



Б.ЭНХБАЯР

08 2475  
Doc.yam 25.2018



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
~~2018 оны 05 сарын 18~~-ны  
сдрийн ~~3901~~ дугаар

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/239

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.6, 3.2.14 дэх зорилтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газарт тус тус даалгасугай.
3. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Аймаг, Нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.
4. Журмын хэрэгжилтэд жил тутам хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ны  
өдрийн 123 тоот тушаалын хавсралт



**БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ОРЧИН,  
ДОТУУР БАЙРАНД ХҮҮХЭД ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨХӨӨС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь цэцэрлэг, сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд цэцэрлэг, сургууль, дотуур байрын орчинг судалж, үнэлэх, эрсдэлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардлагатай тусламж, үйлчилгээнд холбон зуучлах, сурагчдын дунд үе тэнгийн дарамт, дээрэлхэл, хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх, хүүхдэд эерэг харилцаа, ёс зүй, хууль эрх зүйн мэдлэг олгох, хүүхдийн сурч, амьдрах орчинг аюулгүй, ээлтэй болгох үйл ажиллагааг хамруулна.

1.3. Хүчирхийллээс бий болсон хор хохирлыг арилгах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэхээс бусад хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг энэхүү журмаар зохицуулахгүй.

**Хоёр. Хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх  
үйл ажиллагааны үндсэн зарчим**

2.1. Хүүхдийн нэр төр, өөртөө итгэх итгэл, үнэлэмжийг хүндэтгэж, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаална.

2.2. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид, хүүхдийн бие бялдар, нийгэм-сэтгэл хөдлөл, танин мэдэхүй онцлогт тохирсон байна.

2.3. Хүүхдийн хувийн халдашгүй байдлыг хүндэтгэж, нууцыг хадгална.

2.4. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хүүхдийн насны онцлог, ялгаатай хэрэгцээг харгалзсан байна.

**Гурав. Үйл ажиллагааны чиглэл**

3.1. Цэцэрлэг, сургууль, дотуур байрын багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад хүүхдийн эрх, хамгаалал, харилцаа хандлагын талаар дор дурдсан чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг сургууль дээр зохион байгуулна.

3.1.1. Хүүхдийн эрх хамгааллын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх;

3.1.2. Хүүхэд хүмүүжүүлэх, хүүхэдтэй харилцах эерэг харилцааны аргад суралцах;

3.1.3. Хүүхдэд сөрөг зан үйл төлөвшихөөс урьдчилан сэргийлж, эерэг зан үйлийг дэмжих;



3.1.4. Ялгаварлан гадуурхал, ялгаатай байдлын талаарх хүүхдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, үе тэнгийн дээрэлхэлтийг зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж ажиллах;

3.1.5. Аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлтээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, сэтгэлзүйн бэрхшээлийг даван туулах чадвар олгох;

3.2. *Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүрээнд дараах тандалт судалгааг хагас жил тутам зохион байгуулна.*

3.2.1. Цэцэрлэг, сургууль, дотуур байрын материаллаг болон нийгэм сэтгэлзүйн нөхцөл байдалд үнэлгээ хийж, нөхцөл байдлын талаар дүгнэлт гаргах;

3.2.2. Нөхцөл байдлын үнэлгээнд суурилан хүүхдэд учирч болзошгүй эрсдэл болон хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэдтэй ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган анги удирдсан багш, эцэг эхтэй хамтран ажиллах.

3.2.3. Багш, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нь хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг тандан судална.

3.3. *Нийгэм, сэтгэлзүйн үйлчилгээ /зөвлөгөө, дэмжих үйлчилгээ/*

3.3.1. Суралцагчдад сэтгэл санааны хямрал, гутрал, тогтворгүй байдлыг даван туулахад чиглэсэн үйлчилгээг нийгмийн ажилтан, хүүхдийн сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн сэтгэл зүйч үзүүлнэ.

3.3.2. Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлсэн байгууллага, ажилтан сургуулийн нийгмийн ажилтанд хүүхдийн мэдээллийг нэг бүрчлэн өгч хамтарч ажиллана.

3.3.4. Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэхэд холбогдох хууль, дүрэм, журам, ёс зүйг баримтлан хүүхдэд хүндэтгэлтэй хандах, хүүхдийн сэтгэл зүй, насны онцлогт тохирсон асуулт асуух, хүүхдийг буруутгасан аливаа асуулт, үйлдэл гаргахгүй байхад анхаарч ажиллана.

3.4. *Цэцэрлэг, сургууль, дотуур байрын орчныг хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр дараах ажлыг зохион байгуулна.*

3.4.1 Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг хяналтын камертай болгон түүнийг ашиглах, бичлэг хадгалах, хянах дүрэм, журам батлан мөрдүүлнэ.

3.4.2. Цэцэрлэг, сургууль, дотуур байрын өрөө тасалгаа, анги танхим, заал, коридор, бие засах газар, ариун цэврийн өрөөг хүүхдэд аюулгүй, ээлтэй байхаар тохижуулна.

3.4.3. Цэцэрлэг, сургууль, дотуур байрын орчин болон ариун цэврийн гадна байгууламжтай бол түүнд хүрэх зам, талбай, орчныг гэрэлтүүлгээр хангаж, байнгын ажиллагаа, хараа хяналттай байлгана.

3.5. *Эрхзүйн орчинг бүрдүүлж ажиллах*

3.5.1. Цэцэрлэг, сургууль, дотуур байранд гадны хүн нэвтрэхэд баримтлах дэгийг дотоод журамдаа тусган хэрэгжүүлнэ.

3.5.2. Цэцэрлэг, сургууль, дотуур байранд багш, ажилтан ажилд авах шалгуурт хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчил, гэмт хэрэгт холбогдож байгаагүй талаар тусгана.

3.5.3. “Бага насны хүүхдийг заавал эцэг эх, асран хамгаалагчаас хүлээн авах, хүлээлгэн өгөх /гараас гарт/ журам” боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

3.5.4. Цэцэрлэг, сургууль бүр хүүхэд хамгааллын бодлогод нийцүүлэн “Хүүхэд хамгааллын дүрэм”-ийг баталж, мөрдөнө.

### 3.6. Мэдээлэл хүлээн авах, холбогдох байгууллага, ажилтанд мэдээлэх

3.6.1. Сургалтын орчин, дотуур байранд хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа зөрчил илэрсэн, харсан, сэжиг таамаг мэдэгдсэн тохиолдолд тухайн цэцэрлэг, сургууль, дотуур байрын багш, ажилтан, нийгмийн ажилтан, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захиралд мэдэгдэнэ.

3.6.2. Багш, ажилтан, суралцагчдын зүй бус, ёс зүйгүй үйлдлийн тухай үнэн зөв, бодит мэдээллийг хүлээн авах, шалгах, хариу арга хэмжээ авах тухай “Мэдээллийн журам” боловсруулан мөрдөх, дотоод хяналтын тогтолцоотой байна.

3.6.3. Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй гэж үзвэл мэдээллийг Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад /хамтарсан багийн гишүүд/, цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн Засаг даргад болон хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утасны үйлчилгээнд мэдээлж, холбогдох арга хэмжээ, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

## Дөрөв. Хэрэгжүүлэх арга зам

4.1. Цэцэрлэг, сургууль, дотуур байранд хүүхэд сурч, амьдрах аюулгүй орчинг бүрдүүлэх, суралцагч бүрийг хүүхдийн эсрэг хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бүхий л үйл ажиллагаанд сургууль, эцэг эх асран хамгаалагч, орон нутгийн удирдлага, хүүхэд хамгааллын хамтарсан баг, олон нийтийн хүчин чармайлтыг нэгтгэн, уялдаа холбоог хангаж ажиллана.

4.2. Цэцэрлэг, сургууль, дотуур байранд өөрийн үнэлгээ хийхэд эцэг эхчүүдийн оролцоог хангаж, үйл ажиллагаанд гарсан ахиц өөрчлөлт, хүндрэл бэрхшээлээ тодорхойлж, тухайн нөхцөл байдлыг сайжруулахад хамтран ажиллана.

4.3. Сургууль дээрх аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд аймаг, сум, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-тэй хамтран ажиллаж болно.

4.4. Хүүхдийг аливаа хүчирхийлэл, авто замын осол, гэмтэл болон болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж хичээл эхлэх, тарах үед “сургуулийн цагдаа” /school police/-г эцэг эхийн оролцоог хангаж, хамтран зохион байгуулж болно.

4.5. Цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан ажиллана.

4.6. Хүүхдийн талаарх мэдээллийн нууцыг хадгалж ажиллана.

4.6.1. Хувь хүүхэдтэй холбоотой асуудлаар эцэг эх, асран хамгаалагчтай ганцаарчлан уулзана.

4.6.2. Хүүхдийн талаарх хувийн мэдээллийг /эрүүл мэнд, зан төрх, хөгжлийн үзүүлэлт г.м/ багш, эцэг эхээс нь бусад хүмүүст үзүүлэх, дамжуулахыг хориглоно.

4.6.3. Хүүхдийн хувийн мэдээллийг бусдад тараахыг хориглоно. /хүүхдийн зургийг сурталчилгаанд хэрэглэх, хүүхдийн нэртэй материал хэвлэн нийтлэх, хүүхдээс ярилцлага авч хэвлэл мэдээллээр гаргах г.м/

### **Тав. Удирдлага, зохион байгуулалт**

5.1. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь сургуулийн хүүхэд хамгаалал, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхижүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үр дүнг хянах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангана.

5.2. Хүүхдийн эрх, хамгаалал, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал удирдаж, холбогдох зардлыг тухайн жилийнхээ төсөвт тусгаж ажиллана.

5.3. Цэцэрлэг, сургууль, дотуур байр нь өөрийн үнэлгээ болон хүүхэд хамгааллын чиглэлээр анхаарах эрсдлийн хүчин зүйлсийн үнэлгээнд үндэслэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллана.

5.4. Дотуур байр, эцэг эх, хүүхдийн үүрэг хариуцлагыг тусгасан гурван талт хамтарсан гэрээг хичээлийн жилийн эхэнд байгуулж, хичээлийн жилийн төгсгөлд дүгнэн, цаашид авах арга хэмжээний талаар хамтран хэлэлцэж, онцлох асуудлыг дараа жилийн гэрээнд тусгана.

5.5. Цэцэрлэг, сургууль, дотуур байранд багш, ажилтан ажилд авах шалгуурт хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчил, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхийг тусгана.

### **Зургаа. Хяналт, үнэлгээ**

6.1. Цэцэрлэг, сургууль, дотуур байрын өөрийн үнэлгээ болон үйл ажиллагаандаа эрсдлийн үнэлгээг жил бүр цэцэрлэг, сургуулийн удирдлага, эцэг эхийн төлөөлөлтэй хамтран хийж, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хүргэх өндөр эрсдэлтэй үйл ажиллагааны жагсаалтыг гарган эрсдлийг бууруулах арга хэмжээ авна.

6.2. Үйл ажиллагааны тайланг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал хичээлийн жилийн төгсгөлд хамт олон, эцэг эх, сургуулийн зөвлөлд танилцуулж, жил бүрийн 05 дугаар сарын 20-ны дотор аймаг, нийслэлийн боловсролын газарт хүргүүлнэ.

6.3. Аймаг, Нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс нь журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийж, үр дүн бүхий тайланг



06 дугаар сарын 01-ний дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.4. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн боловсролын газраас ирүүлсэн тайлан мэдээнд хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, шаардлагатай тохиолдолд зөвлөмж, чиглэл хүргүүлнэ.

### **Долоо. Бусад**

7.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- оОо ---



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2018.05.21 № 1-1/2535  
танай 2018.05.07-ны № 18/4962-Т

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД  
Ц.ЦОГЗОЛМАА ТАНАА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм батлах тухай" А/243 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3909 дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдье.



Ц.НЯМДОРЖ

08 1889

Doc.yam a5.2018





Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2018 оны 05 сарын 28-ны  
өдрийн 3209 дугаар

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/248

Улаанбаатар хот

Дүрэм, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.18 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм"-ийг нэгдүгээр, "Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ыг хоёрдугаар, "Гомдол, хүсэлт гаргах маяг"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ёс зүйн дүрмийг бүх түвшинд мөрдөж зөрчил гаргасан албан хаагчид холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн захирал, эрхлэгч, эрх бүхий байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

3. Дүрэм, үлгэрчилсэн журмыг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус даалгасугай.

4. Дүрэм, үлгэрчилсэн журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр тооцон, улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны "Дүрэм батлах тухай" А/41 дүгээр тушаал, 2016 оны "Дүрэм батлах тухай" А/281 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

1000898

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны 05 сарын 01 өдрийн тушаалаар  
тушаалын 1 дүгээр хэсэрт

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, АЛБАН БУС, НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН БАГШ, УДИРДАХ БОЛОН БУСАД АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Ерөнхий боловсролын сургууль (цаашид сургууль гэх), цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтан албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах зарчим, даган биелүүлэх ёс зүйн хэм хэмжээг тогтоож, ёс зүйн зарчим, хэм хэмжээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, багш мэргэжлийн нэр хүндийг хамгаалахад энэхүү ёс зүйн дүрмийн зорилго оршино.
- 1.2. Ёс зүйн дүрмийн эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын багц хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зорчлоос урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенци болон холбогдох бусад хууль тогтоомж байна.
- 1.3. Ёс зүйн дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, туслах багш, удирдах болон бусад ажилтан /цэцэрлэгийн арга зүйч, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, номын санч, эмч/ дагаж мөрдөнө.
- 1.4. Энэхүү ёс зүйн дүрмээр тогтоосон зарчим, хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ.
- 1.5. Энэхүү дүрмийн 1.3-т зааснаас бусад, сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн ажилтан /жижүүр, үйлчлэгч, нягтлан бодогч, нярав болон бусад/-ны ёс зүй, харилцаанд тавих шаардлагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд тусган зохицуулна.

### Хоёр. Баримтлах зарчим

- 2.1 Сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтан үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.
  - 2.1.1 Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;
  - 2.1.2 Хүнлэг энэрэнгүй, шударга ёсыг дээдлэх;
  - 2.1.3 Мэргэжлийн нэр хүнд, үнэ цэнийг хамгаалах;
  - 2.1.4 Ёс суртахууны үнэ эр дуурайлалтай ажиллах;
  - 2.1.5 Чанартай, хүртээмжтэй боловсролыг эрхэмлэх;
  - 2.1.6 Хуулийг чанд сахиx, хариуцлагатай байх;
  - 2.1.7 Аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх/тэгш байдлыг хангах

### Гурав. Багшийн мэргэжлийн нэр хүндийн баталгаа

#### 3.1 Багш, удирдах ажилтан

- 3.1.1 Мэдлэг, боловсрол, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх;
- 3.1.2 Сургалтын ажлыг чанар, үр өгөөжтэй зохион байгуулах;
- 3.1.3 Суралцагчид туслах, үлгэрлэх;
- 3.1.4 Ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байх;
- 3.1.5 Хувцаслалт, биеэ зөв авч явахад анхаарах;
- 3.1.6 Баримт нотолгоонд тулгуурласан, үнэн зөв мэдээлэл, мэргэжлийн үйлчилгээ, зовлогоо үзүүлэх;

#### 3.2 Эцэг эх, олон нийт

- 3.2.1 Боловсролын байгууллагаар үйлчлүүлэгчид багшийн нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн үзэх;

- 3.2.2 Багш хууль тогтоомжоор заасан ажил үүргээ гүйцэтгэх үйл явцыг санаатай болон санамсаргүйгээр тасалдуудахгүй байх;

#### **Дөрөв. Ёс зүйн хэм хэмжээ**

Сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтан дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

#### **4.1 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх:**

- 4.1.1 Хичээл, сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор хүүхэд, эцэг эх, олон нийт болон хамтран ажиллагчидтай хууль бус санхүү, эд хөрөнгийн харилцааг тэвчих;
- 4.1.2 Хүүхэд, багш болон бусад ажилтны талаар шийдвэр гаргахдаа хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй асуудлыг шийдэхээс татгалзах, урьдчилан сэргийлэх;
- 4.1.3 Байгууллагын эд хөрөнгийг хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх;
- 4.1.4 Үндсэн ажлаас гадуур хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад давхар ажил, үүрэг эрхлэхгүй байх;
- 4.1.5 Хүүхэд болон эцэг, эх, асран хамгаалагчаас тоног төхөөрөмж, эд материал зэргийг худалдан авахыг ятгах, хууль бус орлого олохоос татгалзах;

#### **4.2 Ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх:**

- 4.2.1 Хүүхдийг гэр бүлийн байдал, хөгжил, суралцах чадвараар нь ялгаварлахгүй байх, сурлагын амжилтыг бодитой үнэлэх;
- 4.2.2 Эцэг, эх, асран хамгаалагч, олон нийт, хамтран ажиллагчдаа нас, хүйс, хувийн онцлог, албан тушаал, мэдлэг, туршлагаар нь ялгаварлахгүй, ажил тэгш хүндэтгэлтэй хандах, хамт олны эв нэгдлийг дээдлэх;
- 4.2.3 Сургууль, багшийн ажлын амжилтыг чухалчлан суралцагчийг олимпиад, уралдаан, тэмцээнд оролцох, элсэлтийн ерөнхий шалгалт өгөх хичээл болон хичээлийн тоог хязгаарлах зэхүл албадлага үзүүлэх үйлдэл гаргахаас зайлсхийх;
- 4.2.4 Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдийн эрүүл мэнд хохирох, бэлгийн дарамтад өртөх, үе тэнгийнхэн болон гадаад орчин, цахим орчны сөрөг нөлөөнд автахыг анхаараагүйгээс тэдний эрх, эрх ашиг хохирох байдалд хүргэхээс сэргийлэх;

#### **4.3 Албан тушаалаа урвуулан ашиглахаас сэргийлэх:**

- 4.3.1 Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, хамтран ажиллагчдыг доромжлох, нэр төрийг гутаахгүй байх;
- 4.3.2 Хүүхдийн эрх, эрүүл мэндийг хохироох, амралт чөлөөт цагийг хасах замаар өөрийн ажлын амжилтыг урьтал болгохоос сэргийлэх;
- 4.3.3 Хүүхэд, гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагчтай холбоотой мэдээллийн нууцыг хадгалах;
- 4.3.4 Өөрийн болон байгууллагын нэр хүнд, амжилтын төлөө хамт олон, хувь хүний нэр төр, эрүүл мэнд, сэтгэл санаа, хувийн өмчид хохирол учруулахгүй байх;
- 4.3.5 Удирдах ажилтан нь албан тушаалын давуу талаа ашиглан бусдын нэр хүндэд халдах, хууль бус томилгоо, ажил үүргийн хуваарилалт хийх, үнэлгээ дүгнэлт өгөх зэргээс зайлсхийх, хамт олны дунд таагүй уур амьсгал үүсгэх аливаа үйл, үйлдэлд оролцохгүй, хөхүүлэн дэмжихгүй байх;
- 4.3.6 Удирдах ажилтан нь ашиг сонирхлын зөрчилтэй болон зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлын үед шийдвэр гаргах, оорийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгохтой холбоотой үйлдэл үл гаргах;
- 4.3.7 Боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх/, сургалтын баримт бичиг /сурагчийн хувийн хэрэг, ангийн журнал/ хуурамчаар үйлдэх, эсвэл хуурамч бичиг баримтад гарын үсэг зурах, баримт бичиг нөхөж бичих, засварлах, устгах, хуудас солихгүй байх;

#### **4.4 Албадлага, дарамт үзүүрэхээс сэргийлэх:**

- 4.4.1 Сургууль, цэцэрлэгийн нэр барьж сурагч, эцэг, эх, асран хамгаалагчаас хувийн холбогдолтой мэдээлэл гаргаж өгөхийг шаардахгүй байх, хүсээгүй мэдээллийг нь авахгүй байх;
- 4.4.2 Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэл үзүүлэхүй байх;

- 4.4.3 Хүүхдийн дунд сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа явуулахдаа сургууль, цэцэрлэгийн нэрийг барьж хүүчээр албадахгүй байх;
- 4.4.4 Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хувийн үзэл бодол, улс төрийн байр сууриа хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, хамт олонд тулган хүлээлгэхгүй, уриалахгүй байх;
- 4.4.5 Ном, сургалтын хэрэглэгдэхүүн, бусад зүйлийг тулган борлуулахгүй, хуульд заагаагүй төлбөр, хураамж, хандив өгөхийг шаардахгүй байх, хүлээн авахаас татгалзах;
- 4.4.6 Шударга, үнэн бодит шүүмжлэлд хүндэтгэлтэй хандах.

#### 4.5 Бэлэг сэлт, хээл хахууль авахаас сэргийлэх:

- 4.5.1 Ажил, үүргээ гүйцэтгэсний толоо сурагч, эцэг эхээс шан харамж, хээл хахууль авах, өгөхөөс татгалзах, зуучлахгүй байх;
- 4.5.2 Төгсөлт, элсэлт зэрэг албан ёсны арга хэмжээ, баяр ёслолын үед хүүхэд, тэдний асран хамгаалагч, эцэг эхийн зөвлөлийг үнэтэй бэлэг өгөхөөс арга үй байдалд хүргэхгүй байх;
- 4.5.3 Хуульд заасан толбөр, хураамж, хандив, хөрөнгийн зарцуулалттай холбоотой тайлаг мэдээг цаг тухайд нь шударга, ил тод тайлагнадаг байх;

#### Тав. Хариуцлага

- 5.1 Дүрмийг зөрчиж, ёс зүйн зөрчил гаргасан нь зохих журмын дагуу хийсэн шалгалтаар тогтоогдсон, ёс зүйн зөвлөлийн шийдвэрийг биелүүлээгүй боловсролын салбарын ажилтнуудад эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

#### Зургаа. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт

- 6.1 Ажил олгогч энэхүү ёс зүйн дүрмийг багш, удирдах болон бусад ажилтанд танилцуулж, ёс зүйн дүрмийг мөрдүүлж хэрэгжүүлэх, ёс зүйн зорчлоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах үүрэгтэй.
- 6.2 Ажил олгогч ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах, хариуцлага хүлээлгэх талаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, багш, удирдах болон бусад ажилтны хөдөлмөрийн гэрээ, үр дүнгийн гэрээнд тусгана.
- 6.3 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг нь жилийн ажлын тайландаа ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг талаар хийсэн ажлаа тусгайлан тайлагнана.
- 6.4 Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх ёс зүйн зөвлөл хяналт тавьж, мониторинг хийж ажиллана.
- 6.5 Аймаг, нийслэлийн Засаг дарга нь эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээ, санамж бичгийн дагуу аймаг, нийслэлийнхээ багш нарын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг тайлагнах үүрэг хүлээнэ.
- 6.6 Нийслэлийн Засаг дарга нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дүүргийн Засаг даргатай дүүргийнхээ хэмжээнд Ёс зүйн зөвлөл байгуулж ажиллах боломжийг бүрдүүлж болно.
- 6.7 Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
- 6.8 Ёс зүйн зөвлөлөөс ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулах сургалт, үйл ажиллагааны зардлыг аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын төсөвт тусгаж санхүүжүүлнэ. Мөн сургалт, үйл ажиллагааг төсөлд, хөтөлбөр болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

---000---

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны 15 сарын 01 өдрийн дугаар  
тушааны 2 дугаар хайралт

## ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.6. Ёс зүйн зөвлөл нь /цаашид “Зөвлөл” гэх/ “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, хариуцагаа хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.
- 1.7. Зөвлөл нь “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”, холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.8. Зөвлөл нь үйл ажиллагаандаа тэгш хандах, шударга ёсыг баримтлах, нууцыг хадгалах, хараат бус байх зарчмыг баримтална.

### Хоёр. Ёс зүйн зөвлөл

- 2.1. Зөвлөл нь аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, нутгийн захиргааны болон орон нутгийн хүүхэд хамгаалал, боловсролын байгууллагын төлөөлөл бүхий 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Боловсролын газар, зөвлөлийн бүрэлдэхүүний эрх ашгийг хууль ёсоор төлөөлөх олон нийтийн болон мэргэжлийн байгууллага хамтран зохион байгуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 4 жил тутам шинэчилнэ.
- 2.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн Засаг дарга батална.
- 2.4. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийг аймаг, нийслэлийн Засаг дарга тэргүүж, нарийн бичгийн даргаар Боловсролын газрын дарга ажиллана.
- 2.5. Зөвлөл нь ёс зүйн зөрчил, авилга, ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар хариуцлага хүлээж байгаагүй гишүүдээс бүрдэнэ.
- 2.6. Зөвлөлийн гишүүн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гишүүнээс чөлөөлж, нөхөн сонгоно.
- 2.7. Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:
  - 2.7.1. Багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах, санал, зөвлөмж өгөх;
  - 2.7.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн хамт олны дунд багш, удирдах болон бусад ажилтны мэргэжлийн болон хувь хүний ур чадвар, хандлагад зөрөг нөлөө үзүүлэх сургалт тогтмол зохион байгуулах;
  - 2.7.3. Ёс зүйн зөрчил болон ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд дүн шинжилгээ хийж, учир шалтгааныг магадлан тогтоож шийдэх арга замыг тодорхойлох;
  - 2.7.4. Хууль бус ямар нэгэн үйлдлээс урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагавар үүссэн нөхцөл байдлыг арилгах, зөрчил дахин давтагдахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх;
  - 2.7.5. Багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, дүгнэлтийг хүлээн авах;
  - 2.7.6. Багш, удирдах болон бусад ажилтны үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар шалгалт явуулж, дүгнэлт гаргах, хариу өгөх;

- 2.7.7. “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”-ийг хэрэгжүүлэх талаар голөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийн талаар олон нийтэд болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;
- 2.7.8. Ёс зүйн зөрчил, хариуцлагын талаар мэдээллийн сан бүрдүүлнэ.
- 2.8. Зөвлөлийн гишүүн нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг шалгах, нууцыг чанд хадгалах, хуралд оролцож санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хурлаас гарах шийдвэрт хариуцлагатай оролцох, ёс зүйн зөрчил гарсан эсэхэд саналаа хэлэх, зөвлөлийн даргын томилсноор зөвлөлийн хурлыг даргалах бүрэн эрхтэй.
- 2.9. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна зөвлөлийн хурлыг товлон зарлах, бэлтгэлийг хангуулах, хурлыг удирдах, гомдол, хүсэлтийг хүлээн авах, өөрийн эзгүйд зөвлөлийн хурлыг удирдах гишүүнийг томилох бүрэн эрхтэй.
- 2.10. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрт бүх гишүүдээр гарын үсэг зуруулж, баталгаажуулах, баримт бичгийг эмхэлж архивын нэгж болгох, зохих байгууллага, хувь хүнд ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг хүргүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.
- 2.11. Ёс зүйн зөвлөлийн гишүүн дараах тохиолдолд гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагааг явуулж болохгүй.
- 2.11.1. Гомдол, хүсэлтийг өөрөө гаргасан бол;
- 2.11.2. Тухайн багш, удирдах ажилтан, гомдол, хүсэлт гаргасан этгээдтэй эсхүл тэдний гэр бүлийн гишүүдтэй төрөл, садан байвал;
- 2.11.3. Өөрөө шууд буюу шууд бусаар уг асуудалд хувийн сонирхолтой гэж үзэх үндэслэл байгаа бол;
- 2.12. Зөвлөлийн гишүүдийн 70 хувиас дээш ирцтэй хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.
- 2.13. Хурлын шийдвэр гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.
- 2.14. Зөвлөл нь Засаг даргын тамгын газрын албан бичгийн хуудас, тэмдгийг хэрэглэнэ.
- 2.15. Зөвлөлийн гишүүдэд Засаг дарга болон Боловсролын газар, хэлтсийн төсөвт багтаан хууль тогтоомжид заасан хэмжээгээр урамшуулал олгоно.

### **Гурав. Гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаа**

- 3.1. Багш болон бусад ажилтны ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдлыг тухайн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлага, удирдах ажилтан ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдлыг тухайн аймаг, нийслэлийн Зөвлөлийн дарга тус тус “Гомдол, хүсэлт гаргах маягт”(Хавсралт 3)-ын дагуу хүлээн авна. Амаар гаргасан гомдлыг гомдол гаргагчаас маягтаар баримтжуулж авна.
- 3.2. Гомдол хүлээн авагч нь гомдлын нууцлалыг чанд хадгална.
- 3.3. **Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн түвшинд гомдол, хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа:**
- 3.3.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн удирдлага гомдлын дагуу багш болон бусад ажилтныг ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг хянан шалгуулахаар 3 буюу түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон ажиллуулна.
- 3.3.2. Ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажилтан, ажлын хэсэг нь гомдол, хүсэлттэй холбоотой нотлох баримт цуглуулж, тухайн асуудалд хамааралтай этгээдүүдтэй ярилцлага хийсний үндсэн дээр дүгнэлт, санал гарган Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлэнэ.



- 3.3.3. Сургууль, цэцэрлэгээс гаргасан шийтгэлийг эс зөвшөөрсөн тохиолдолд багш болон бусад ажилтан ёс зүйн зөрчил 3 буюу түүнээс дээш удаа давтан гаргасан тохиолдолд аймаг, нийслэлийн зөвлөлд гомдлоо гаргана.
- 3.3.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн түвшинд ёс зүйн зөрчилтэй холбогдон гарсан гомдлыг 14 хоногийн дотор шалгаж дүгнэлт гаргана.
- 3.4. Зөвлөл гомдол, хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа:**
  - 3.4.1. Ёс зүйн зөрчил 2 буюу түүнээс дээш удаа давтан гаргасан, удирдах ажилтны ёс зүйн зөрчилтэй холбогдон гарсан гомдлыг 30 хоногийн дотор шалгаж дүгнэлт гарган холбогдох байгууллага болон гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ.
  - 3.4.2. Зайлшгүй тохиолдолд гомдлыг шалгах хугацааг 30 хоног сунгаж гомдол гаргагчид албан ёсоор мэдэгдэнэ.
  - 3.4.3. Дүгнэлт нь нотлох баримтад үндэслэгдсэн байна.
  - 3.4.4. Зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн эрх бүхий албан тушаалтан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”, Боловсролын тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж, хариу өгнө.
  - 3.4.5. Зөвлөл нь дүгнэлтийн дагуу авсан арга хэмжээнд хяналт тавьж ажиллана.
- 3.5. Ёс зүйн зөрчилд ногдуулсан хариуцлагыг үндэслэлгүй эсвэл, хүндэдсэн гэж үзвэл тухайн багш, удирдах болон бусад ажилтан 30 хоногийн дотор зөвлөлд бичгээр гомдлоо гаргаж болно.
- 3.6. Гомдол гаргагч багш, удирдах болон бусад ажилтан ёс зүйн зөрчил гаргасан талаар гүтгэсэн, худал мэдүүлсэн тохиолдолд түүнд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж, учруулсан бодит хохирлыг барагдуулна.
- 3.7. Энэхүү үлгэрчилсэн журмыг үндэслэн аймаг, нийслэлийн хэмжээнд үйлчлэх Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг аймаг нийслэлийн засаг даргын захирамжаар батлан хэрэгжүүлж болно.

-----o0o-----

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны 05 сарын 01 өдрийн 1248  
тушаалын 3 дугаар хавсралт



Ёс зүйн зөрчил гаргасан гэх гомдол /хүсэлт/-ийг дараах маягтын дагуу гаргана.

### ГОМДОЛ, ХҮСЭЛТ ГАРГАХ МАЯГТ

Огноо:

Нэр, хаяг, утасны дугаар:

Гомдол /хүсэлт/ гаргагчийн имэйл хаяг:

Хариуцагчийн нэр, албан тушаал, ажлын газар:

Гомдол /хүсэлт/-ийн агуулгыг товч танилцуулна уу.

Гомдол /хүсэлт/ гаргаснаар ямар үр дүнд хүрэхийг зорьж буйгаа танилцуулна уу.

Та асуудлыг шийдэхээр оролдлого хийж байсан уу. Дараах арга замуудаас аль нэгийг нь сонгон хэрэглэж үзсэн үү. Тийм бол баталгаажуулна уу.

1. Ёс зүйн зөрчил гаргасан багш, ажилтантай бичлэн уулзаж ярилцсан ч асуудал шийдэгдээгүй.
2. Сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн удирдлагатай уулзаж ярилцсан ч асуудал шийдэгдээгүй.
3. Аймаг, нийслэлийн холбогдох албан тушаалтантай уулзаж ярилцсан ч асуудал шийдэгдээгүй.
4. Миний бие Ёс зүйн дүрмийг уншиж танилцсан бөгөөд хамрах асуудал нь мөн хэмээн итгэж байна.

Та ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж буй болон гомдол /хүсэлт/ гаргасан талууд уулзаж болох өдөр сар, газар болон асуудлыг шийдэхэд зайлшгүй шаардлагатай шийдлийг санал болгоно уу. Мөн өөрийн гомдол /хүсэлт/-ийн нотлох баримтыг хавсаргана уу.

Дээр дурдсан бүх мэдээлэл үнэн зөв, бүрэн гэдэгт миний бие өөрийн мэдлэг, мэдээллийн хүрээнд баталж байна.

Гомдол /хүсэлт/ гаргагчийн гарын үсэг:

Гомдол /хүсэлт/ хүлээн авагчийн тэмдэглэгээ:

-----000-----





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/369

Улаанбаатар хот

Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх  
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг, 13, 14 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2018 оны 46 дугаар зарлигийн 2 дахь заалт, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.8, 3.2.10, 3.2.11, 3.2.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, үйл ажиллагааг хугацаанд нь чанартай гүйцэтгэхийг Дээд боловсролын бодлогын газар, Ерөнхий боловсролын бодлогын газар, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар, Соёл, урлагийн бодлогын газар, Шинжлэх ухаан, технологийн бодлогын газар, Биеийн тамир, спортын бодлогын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын үндэсний төв, Монгол Улсын Боловсролын Их сургууль, Монгол Улсын Их сургууль, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, арга хэмжээ, үйл ажиллагааны явцыг хагас, бүтэн жилд тайлагнаж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд /Г.Ганбаяр/-д даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

001306

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 06 дугаар сарын 13-ны  
өдрийн 1/369 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ БИЧГИЙН ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР  
АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ, үйл ажиллагааны чиглэл	Хугацаа он, сар	Хариуцах нэгж, байгууллага
A)	<b>Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль</b>		
1	Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн монгол хэл, бичиг, уран зохиол, монголын түүхийн сургалтын цөм хөтөлбөр, сурах бичиг, үнэлгээний даалгавар, бусад хэрэглэгдэхүүний чанар, хүртээмж, хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах	2018 06-08	ЕББГ МУИС БҮТ
2	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөг үндэсний бичиг, өв соёлд тулгуурлан шинэчилж, хэрэгжүүлэх	2018	ЕББГ БХ
3	Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, уран зохиол, монголын түүхийн болон сургалтын бусад цөм хөтөлбөрийг үндэсний бичиг, өв соёлд тулгуурлан шинэчилж, хэрэгжүүлэх	2018-2019	ЕББГ БХ
4	Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиол, монголын түүхийн сургалтын агуулгыг сурагчдад ёс суртахууны хүмүүжил, төлөвшил олгох чиглэлээр шинэчлэн боловсруулах, судлах цагийг нэмэгдүүлэх, бага ангид үздэг байсан "Унших бичиг" хичээлийг сэргээх	2018-2019	ЕББГ БХ
5	Монгол бичгийн сургалтын орчин бүрдүүлэхийн тулд ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн уран зохиол, монголын түүхийн сурах бичгийг нэн түрүүнд үндэсний бичигт хөрвүүлэн хэвлэх	2018-2019	ЕББГ БХ
6	Төрийн, орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил, үндэсний хос бичгээр хөтлөн явуулах болон үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжихтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн бага ангид үндэсний бичгийн хичээл оруулах, 1-12 дугаар ангийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, баримт бичгийг үндэсний бичигт хөрвүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	2018-2020	ЕББГ БХ
7	Бага ангийн багш нарын монгол бичгийн мэдлэг, чадварын түвшин тогтоож, тэднийг давтан сургах, мэргэшүүлэх	2018	ЕББГ МУБИС БМДИ
8	Өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль (төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг болон гадаад хэл заах тусгай зөвшөөрөл бүхий цэцэрлэг, сургууль багтана), Насан туршийн боловсролын төвийн удирдах ажилтан, багш нар, сурагчдын монгол бичгийн мэдлэг, чадварын түвшин тогтоож, улмаар чадварыг нь дээшлүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	2018	ЕББГ БҮТ БМДИ НТБҮТ

Төрийн захиргааны  
яаралтын газар

9	Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй монгол хэл, бичиг, уран зохиол, монголын түүхийн багш нарын монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг тэдний төгссөн их, дээд сургуулийн монгол бичгийн хөтөлбөрийн түвшинд шинжилж, дүгнэх	2018	ЕББГ БҮТ
10	Сурагчдад монгол бичгийн хичээлийг үр дүнтэй зааж сургаж байгаа багш нарын бүтээлч арга туршлагыг судлах, илрүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулах	Жил бүр	ЕББГ МУБИС БХ
11	Монгол хэл, бичгийн сургалтын зорилго, агуулгыг оновчтой тодорхойлох, арга зүйг шинэчлэх эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж, дүгнэх	2018	ЕББГ БХ
12	Монгол хэл, бичиг, уран зохиол, монголын түүхийн эрдэмтэн судлаач, багш нарыг хамруулан үндэсний чуулга уулзалт зохион байгуулах	Жил бүр	ЕББГ БХ
13	Боловсролын хүрээлэнд монгол хэл, бичиг, соёл, түүх, уран зохиолын сургалт хариуцсан нэгж (сектор)-ийг шинээр байгуулж, ажиллуулах	2018	ЕББГ СХОГ
14	Гадаадад амьдарч буй монгол иргэд, хүүхэд, залууст үндэсний бичгийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх	2018	ЕББГ БХ
15	Монгол бичгийн дагнасан улсын сорилго (олимпиад) зохион байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх	2018	ЕББГ
16	Хүүхэд залуусыг монгол хэл, бичиг, соёлд тулгуурлан хүмүүжүүлж төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын сургалтын байгууллага, эцэг эхийн хүлээх үүргийг хуульчлах, эцэг эхчүүдийн үндэсний зөвлөгөөн зохион байгуулах	2018	ЕББГ
17	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулинд цэцэрлэгийн насны хүүхдэд гадаад хэл сургахыг хориглох, Бага, дунд боловсролын тухай хуулинд сурагчдад 12 нас хүртэл гадаад хэл сургахыг хориглох нэмэлт заалт тус тус оруулах	2018	ЕББГ СӨББГ
Б)	<b>Их, дээд сургууль, коллеж</b>		
18	Багш бэлтгэдэг, өмчийн бүх хэлбэрийн нийт их, дээд сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиол, монголын түүхийн сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах	2018 09-11	ДББГ МУБИС
19	Багш бэлтгэдэг, өмчийн бүх хэлбэрийн их, дээд сургуулиудад үндэсний бичиг, уран зохиол, монголын түүх хичээлийг заавал судлах эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлэх	2018	ДББГ
20	Өмчийн бүх хэлбэрийн их, дээд сургууль коллежийн багш, оюутнаас монгол хэл, бичгээр унших, бичих чадварын түвшин тогтоох шалгалт авч, нэгтгэн дүгнэх	2018 09-10	ДББГ ЕББГ БҮТ
21	Их, дээд сургууль, коллежид элсэн суралцагчдаас авах монгол хэл, бичгийн элсэлтийн шалгалтын даалгаврын хувь хэмжээг адил тэнцүү байхаар боловсруулж, оюутан элсүүлэх журамд үндэсний бичгийн босго оноог өндөр тогтоохоор нэмэлт оруулах	2019	ДББГ БҮТ



22	Сурган хүмүүжүүлэх ухаан, хэл шинжлэл, уран зохиол, сэтгүүл зүй, нийгмийн ажилтны чиглэлээр их, дээд сургуульд элсэгчдээс авах монгол хэл, бичгийн шалгалтын тусгайлсан журам боловсруулж, хэрэгжүүлэх	2018-2019	ДББГ
23	Монгол хэл, бичиг, уран зохиол, монголын түүхийн багш бэлтгэдэг их, дээд сургуульд өндөр оноотой сурагч элсүүлэх, сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэгт нэн тэргүүнд хамруулах эрх зүйн орчин бүрдүүлэх, үндэсний бичгийн сургалтын чанарыг сайжруулах, төгсөгчдийн монгол бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	2018-2020	ДББГ
24	Үндэсний бичгийн сургалтын орчин бүрдүүлэхэд санаачилга гарган үр дүнтэй ажилласан ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийг урамшуулах, дэмжих эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлэх	Жил бүр	ДББГ ЕББГ СХОГ
В) <b>Шинжлэх ухаан, соёл, спортын болон бусад байгууллага</b>			
25	"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-II" хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг олон нийтэд тайлагнах	2018 09	ХШУДАГ
26	Монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хадгалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III" нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2018 10	БСШУСЯ
27	Бүх нийтийн монгол бичгийн унших, бичих, сонсох, ярих чадварын түвшинг тодорхойлох шалгуур үзүүлэлт боловсруулан стандартчилах	2019-2020	ШУТБГ ХЗХ
28	Бүх шатны сургалт, эрдэм шинжилгээний ажилд шинжлэх ухааны нэр томъёо, мэргэжлийн үг хэллэг монгол хэл рүү хөрвүүлэн хэрэглэх дүрэм боловсруулан хэрэгжүүлж, хэвших	2018-2019	ШУТБГ ХЗХ
29	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын номын санг монгол бичгээр хэвлэгдсэн ном зохиолоор баяжуулах, төсөв хөрөнгө шийдэж, санхүүжүүлэх (Монгол Улсад болон Өвөр Монголын өөртөө засах оронд үндэсний бичгээр хэвлэгдэж буй монгол зохиолчдын зохиол бүтээлээс худалдаж авах)	Жил бүр	СУБГ СХОГ
30	Монгол бичгийг бие даан сурах гарын авлага, толь бичиг, брайл үсгийн ном зохион хэвлүүлэх, цахим хэрэглээнд үндэсний бичгийг нэвтрүүлж, ашиглах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	2018-2019	ШУТБГ ХЗХ
31	Үндэсний бичгээр хэвлэгдсэн эртний түүхэн сурвалж, ховор, хуучин номыг дахин хэвлүүлж, ард иргэдэд түгээх, тэднийг соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан, төсөв хөрөнгө шийдэж, хэрэгжүүлэх	2018-2024	ШУТБГ СУБГ
32	Кирил бичгээр хэвлэгдсэн монголын түүх, ёс заншил, уран зохиол, хүүхдийн жүжгийн шилдэг бүтээлийг үндэсний бичигт хөрвүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	2018-2024	ШУТБГ СУБГ
33	Үндэсний өдөр тутмын сонин хэвлэлийн бүрэн болон хагас нүүрийг үндэсний бичгээр хэвлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, төсөв хөрөнгөөр дэмжих	2018-2019	СУБГ СХОГ



34	Бүтээлээ үндэсний бичгээр хэвлүүлсэн зохиолч, судлаач, иргэдийг (ном, сэтгүүл, сонин зэрэг) урамшуулан дэмжих журам боловсруулж, хэрэгжүүлэх	Жил бүр	ШУТБГ СУБГ
35	Үндэсний бичгийн хэрэглээний орчин бүрдүүлэн ажиллаж байгаа шинжлэх ухаан, боловсрол, соёл, спортын байгууллага, хамт олныг урамшуулан дэмжих журам боловсруулж хэрэгжүүлэх	Жил бүр	БСШУСЯ Аймаг, нийслэлийн Засаг дарга
36	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хамтран ажилладаг аж ахуйн нэгж, компани, төрийн бус байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд ард иргэдийг үндэсний бичиг үсэгт сургах ажлыг хамтран зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	2018-2024	ШУТБГ СУБГ
37	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байгууллагууд албан бичгээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	2018 06-11	БСШУСЯ
38	Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III болон монгол үндэстний оюуны соёлын үнэт, бахархалт өв, монгол хэл, сэтгэлгээ, соёл иргэншлийн аюулгүй байдлыг хадгалан батжуулагч үндэсний бичиг, эртний түүхэн сурвалж, ховор, хуучин ном, уран зохиолын талаар олон нийтэд ухуулан таниулах, судлуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах, сурталчлах ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	2018-2024	ШУТБГ СУБГ
39	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээ мэдээлэл зар сурталчилгаа нь утга агуулга, хэл найруулга, зөв бичих дүрмийн алдаагүй байх, зурагтаар гарах гадаад улс орны кино, нэвтрүүлгийг хязгаарлах, түүнд хяналт тогтоох эрх зүйн орчныг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэж, хэрэгжүүлэх	2018	СУБГ
40	Монгол хэл, бичиг, соёлд тулгуурлан монгол хүүхдийн үлгэрлэн дууриах үндэсний баатрыг бүтээх, уг баатрын үйл хэргийг үзүүлсэн хүүхэлдэйн кино, жүжиг, уран сайхны кино хийж, зурагтаар нэвтрүүлэх	2019-2024	СУБГ
41	Монгол хэл, бичгийн дурсгал, соёлын өвийг хамгаалах, үндэсний бичгээрх оюуны өв сан, ардын аман зохиол болон монгол утга зохиол, түүхийн сургалт, судалгааны төслүүдийг Шинжлэх, ухаан технологийн сан, бусад эх үүсвэрээс төсөв хөрөнгө шийдэж санхүүжүүлэх	2018-2024	ШУТБГ СУБГ
42	Байгууллага, хамт олноороо үндэсний бичигтэн болох хөдөлгөөн өрнүүлж, шалгаруулах	Жил бүр	Аймаг, нийслэлийн Засаг дарга
43	Монгол хэлний тухай хуулийн 6.3, 7.3, 7.4, 13.1.1, 13.1.2, 13.1.4, 13.1.5, 16.1.1 дэх хэсгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргах, сургалтын төлөвлөгөөний дагуу монгол хэл, бичиг, уран зохиол, монголын түүхийн хичээл судалдаггүй ерөнхий боловсролын сургуулиудын тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэлх арга хэмжээ авах	2018	ЕББГ ХШУДАГ БХ

МОНГОЛЫН УЛС

.....оо0оо.....



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/381

Улаанбаатар хот

Хичээлийн жилийн бүтэц  
шинэчлэн батлах тухай

Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсэг, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" улсын 2 дугаар зөвлөгөөнд оролцогчдын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, сум, тосгон, багийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг нэгдүгээр, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг хоёрдугаар хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан хичээлийн жилийн бүтцийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд мөрдсүгэй.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны "Хичээлийн жилийн бүтэц батлах тухай" А/85 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

8301571



Аймаг, сүм, тосгон, багийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц



Улирлал	Нэгдүгээр улирал								Хоёрдугаар улирал								Гуравдугаар улирал						Дөрөвдүгээр улирал					Сургалтын 7 хоног													
	IX		X		XI		XII		I		II		III		IV		V		VI																						
Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41
7 хоног																																									
I	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						7 долоо хоног					32													
II	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						8 долоо хоног					33													
III	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													
IV	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													
V	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													
VI	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													
VII	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													
VIII	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													
IX	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													
X	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													
XI	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													
XII	8 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног						9 долоо хоног					35													

Тайлбар:

- 1, 2, 3 дугаар улирлын амралт Даваа гаралт эхэлж, Баасан гаралт дуусна.
2. Суралчид 3 дугаар улирлын дундуур Цагаан сарын үеэр 1 долоо хоног амарч, Бага анги 9, дунд, ахлах анги 10 долоо хоног тус тус хичээллэнэ. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүд тохиож буй 7 хоногт амарна. Шинийн 1, 2-ны өдөр 7 хоногийн Бямба, Ням гаралт томоовол дараа 7 хоногт нь амарна.
3. Газар зүйн бүслүүр, цаг уурын онцлог, мал төлгөх хугацаанаас хамааран 30 дугаар 7 хоногийн амралтыг 32 дугаар 7 хоногт, 31 дүгээр долоо хоногийн амралтыг 29 дүгээр долоо хоногт тус тус шилжүүлж болно.
4. Хичээлийн жилийн 39, 40 дүгээр 7 хоногт 3-12 дугаар ангид Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулна.

Тэмдэглэгээ:

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц.



Улирал	Нэгдүгээр улирал								Хоёрдугаар улирал								Гуравдугаар улирал								Дөрөвдүгээр улирал								Сургалтын 7 хоног																	
	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22		23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39
Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41									
7 хоног	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								32									
I	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								33									
II	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
III	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
IV	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
V	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
VI	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
VII	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
VIII	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
IX	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
X	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
XI	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									
XII	8 долоо хоног								7 долоо хоног								9 долоо хоног								8 долоо хоног								9 долоо хоног								35									

Тайлбар:

- 1, 2, 3 дугаар улирлын амрагт Даваа гарат эхэлж, Баасан гарат дуусна.
2. Хичээлийн жилийн 39, 40 дүгээр 7 хоногт 3-12 дугаар ангид Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зөхсөн байгуулна.





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/398

Улаанбаатар хот

Г Дунд хугацааны төлөвлөгөө батлах тухай Г

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дугаар заалтыг үндэслэн Засгийн газрын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7 дугаар зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр 2018-2020 онд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга (Т.Ням-Очир), шаардагдах зарим зардлыг улсын төсөвт тусгах ажлыг зохион байгуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Х.Галсанхүү)-т тус тус даалгасугай.

3. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутам нэгжийн зөвлөлд танилцуулж байхыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга (Т.Ням-Очир)-д үүрэг болгосугай.

САЙД  ЦЭЦӨГЗОЛМАА

1387



Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын сайдын 2018 оны 06 дугаар  
сарын 22-ны өдрийн 188/18 тоот  
тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН АЮУЛГҮЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ  
ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018-2020/

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга зам	Төсөв /сая төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллага
<b>Эрх зүйн орчинг боловсролгүй болгох чиглэлээр</b>						
<i>Үр дүн: Ерөнхий боловсролын сурагчид нийтийн тээвэрээр үнэ төлбөргүй зорчих боломж бүрдэнэ.</i>						
1	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг нийтийн тээвэрээр үнэ төлбөргүй зорчуулах эрх орчинг бий болгох	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын зорчилтын дэлгэрэнгүй судалгаа авах Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчуулахад шаардлагатай төсвийн тооцоо гаргах, Боловсролын тухай хуулинд өөрчлөлт оруулах		2018  2018	НБГ  БСШУСЯ	НТГ  НЗДТГ
2	Гамшиг онцгой байдлын үед боловсролын салбарын тасралтгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлогын чиглэлийг Боловсролын 2030 он хүртэлх мастер төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх	Боловсролын 2030 он хүртэлх мастер төлөвлөгөөнд тусгах		2019	БСШУСЯ	ОБЕГ, олон улсын байгууллага, ТББ
3	Ерөнхий боловсролын сургуулийн орчны стандартыг боловсруулж, батлуулах	Стандарт батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах		2019-2020	БСШУСЯ	СХЗУТ
4	Боловсролын удирдлага мэдээллийн системд гамшигийн эрсдлийн чиглэлийн мэдээ, мэдээлэл оруулах.	Ерөнхий боловсролын сургуулийн өргөрөг, уртрагийн байршил, Гамшиг онцгой байдлын үед сургуульд хүрч очих газрын зураг г.м		2019	БСШУСЯ	

5	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургагч багш бэлтгэх	Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудыг сургагч багшаар бэлтгэх	5.0	2018-2019	БСШУСЯ	НБГ ЗЦА
	Ерөнхий боловсролын сургуулийн автобус үйлчилгээнд Монгол улсын стандарт MNS6440:2011-ын дагуу үзлэг шалгалт хийж, стандартын шаардлагыг хангаж буй сургуулийн автобуст хүүхэд тээвэрлэх зөвшөөрөл олгох	Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн автобусны стандарт хангалтад үзлэг, шалгалт хийх, дүгнэлт гаргах		2018	НБГ	НТГ
6	Онцгой байдлын хариу арга хэмжээний бодлого, чиглэл нь хууль эрх зүйн орчин, үндэсний болон олон улсын техникийн стандартууд, Засгийн газрын хуулиар хүлээсэн хүний эрхийн холбогдох үүрэг амлалтад нийцэж буй байдалд үнэлгээ хийх	Стандарт хангахгүй байгаа сургуулиудад зөвлөмж, чиглэл хүргүүлж, зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах		2018-2020		
7		Үнэлгээний үр дүнд суурилан боловсролын хариу арга хэмжээний стратегийг өөрчлөх, төлөвлөх		2020	БСШУСЯ	ОБЕГ, олон улсын байгууллага, ТББ
<b>Хүүхдийг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр</b>						
<i>Үр дүн: Ерөнхий боловсролын сургуулийн багш, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдүүд замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголттой болж, урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.</i>						
8	Зам тээврийн осол, гэмтэл, нас баралтын талаар нөхцөл байдлын судалгаа хийж, эрсдлийг бууруулах арга хэмжээ авах	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран нөхцөл байдлын судалгаа хийж, дүгнэлт гаргах	2.0		БСШУСЯ	ЭМЯ, ЗЦА
9	Ерөнхий боловсролын сургуулийн гадаад, дотоод орчныг бүрэн камержуулах	Судалгаанд суурилан эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авах			АНБСУГ	ЕБС
10	Ерөнхий боловсролын сургуулийн автобусны чанар, хүртээмжийг	Сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах		2018	АНБСУГ	ЕБС
	намагшилга, үйлчилгээний шаардлыг хангах	Нийслэлийн хэмжээнд сургуулийн автобус шаардлагатай сургуулийн судалгааг хийж, жагсаалтыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх			НБГ	НЗДТГ

		2018-2020	НЭДТГ	НБГ
<p>сайжруулах</p>	<p>Сургуулийн автобус төслийн хүрээнд автобусаар хангах ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах</p>	<p>2019</p>	<p>БСШУСЯ</p>	<p>МХЕГ, ОБЕГ, олон улсын байгууллага, ТББ</p>
<p>11</p>	<p>Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн судалгаа, гамшгийн эрсдлийн үнэлгээ хийх</p>	<p>2020</p>	<p>БСШУСЯ</p>	<p>ОБЕГ, олон улсын байгууллага, ТББ</p>
<p>12</p>	<p>Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний талаар дотоодын ба олон улсын байгууллагуудтай үр дүнтэй мэдээлэл солилцох уулзалт зохион байгуулах, хамтран ажиллах</p>	<p>2018</p>	<p>БСШУСЯ</p>	<p>АНБСУГ ЗЦА</p>
<p>13</p>	<p>Аймгийн боловсрол, соёл, урлагийн газар, Нийслэлийн боловсролын газарт хүүхдийг зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, ажлын чиглэл хүргүүлэх</p>	<p>2018</p>	<p>БСШУСЯ</p>	<p>НБГ Монголын Иргэний Аюулгүй байдлын академи</p>
<p>14</p>	<p>Хүүхдийг аливаа болзошгүй эрсдэл, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд сурагчдад зориулсан гарын авлагыг сургуулиудад хүргүүлэх</p>	<p>2018</p>	<p>БСШУСЯ</p>	<p>АНБСУГ ЗЦА ГХУСАЗЗ</p>
<p>15</p>	<p>Замын хөдөлгөөнд аюулгүй оролцох мэдлэг, дадал олгоход эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр өдөрлөг, сургалт зохион байгуулах</p>	<p>2018-2020</p>	<p>АНБСУГ ЗЦА ГХУСАЗЗ</p>	<p>Төрийн ба ТББ</p>



16	Хүүхдийн дүрэмт хувцас үйлдвэрлэдэг аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн нийт сурагчдыг "Цацруулагчтай ханцуйвч"-тай болгох	Хүүхдийн дүрэмт хувцас үйлдвэрлэдэг компанитай хамтран ажиллах	2019-2020	БСШУСЯ НБГ АНЗДТГ ЗЦА	Дүрэмт хувцас үйлдвэрлэгч аж ахуй нэгж, байгууллага
17	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын сурах бичгийн хавтасны ар, өвөр талд Замын хөдөлгөөнд аюулгүй, зөв оролцох мэдлэг олгох мэдээлэл, зурагт хуудас бэлтгэн тогтмол хэвлэн гаргах	Зурагт хуудас бэлтгэх, хэвлэлтэнд оруулах	2018-2020	БСШУСЯ НБГ АНЗДТГ ЗЦА	Хэвлэлийн компаниуд
18	Хүүхдийг аливаа болзошгүй эрсдэл, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх хүрээнд хичээл эхлэх, тарах үед "сургуулийн цагдаа" /school police/-г эцэг эхийн оролцоог хангаж, хамтран зохион байгуулах	Сургуулийн цагдаа" эргүүлийг эцэг эхийн оролцоотойгоор тогтмол зохион байгуулах Бага ангийн сурагчдыг хичээлд ирэх, тарахад "гараас гарт" хүлээлцэж байх ажлыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулиудад хэвшүүлэх	2018-2020	АНБСУГ	ЕБС
19	БСШУС-ын сайдаас жил бүр Аймаг, Нийслэлийн засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээнд сургуулийн бүс, техникийн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх ажлыг тусгаж, үр дүнг тооцох	Үр дүнгийн гэрээний төсөлд жил бүр санал оруулж, хэрэгжилтийг хангуулах	2018-2020	БСШУСЯ	АНЗДТГ
20	Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгүүдэд "Замын цагдаагаас мэдээлж байна" самбарыг байршуулж, мэдээ мэдээллээр хангаж ажиллах	Багш, сурагчагчийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн самбар ажиллуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах	2018	НБГ ЗЦА	Төрийн болон ТББ

<p>2014 онд батлагдсан ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын MNS:2014-6444 "Сургуулийн бүс, техникийн шаардлага" стандарт шаардлагын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх</p>	<p>MNS:2014-6444 "Сургуулийн бүс, техникийн ерөнхий шаардлага"-ын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, зорчих хэсэгт байрласан, эрсдэлтэй бүсэд байгаа зарим сургууль орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай сургуулийн жагсаалтыг гаргах</p>	<p>2018</p>	<p>БСШУСЯ ЗЦА</p>	<p>АНБСУГ</p>
<p>21</p>	<p>Улаанбаатар хотын төвийн болон захын бүсэд ачаалал ихтэй авто замын ойр байрлах ерөнхий боловсролын сургуулийн орчинд гэрлэн дохио, хурд сааруулагч, туузан хашлага, замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх</p>	<p>2018-2020</p>	<p>НЗДТГ НБГ</p>	<p>ЗЦА</p>
<p>22</p>	<p>Эцэг эх, багш, олон нийтэд чиглэсэн нөлөөлөл, сурталчилгааны ажил зохион байгуулах</p>	<p>2018</p>	<p>АНБСУГ</p>	<p>ЗЦА</p>

НЗДТГ-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар  
АНЗДТГ- Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар  
НБГ-Нийслэлийн Боловсролын газар  
АНБСУГ-Аймаг, Нийслэлийн Боловсролын газар  
ЗЦГ-Замын Цагдаагийн газар  
МХЕГ-Мэргэжлийн хяналтын ерөнхий газар  
СХЗУТ-Стандарт хэмжил зүйн үндэсний төв  
ОБЕГ-Онцгой байдлын ерөнхий газар  
НТГ-Нийтийн тээврийн газар  
ДБХ-Дүүргийн боловсролын хэлтэс

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2018 оны 02 сарын 23-ны  
өдрийн 3962 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад мөрдсүгэй.

3. Энэхүү журмыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг үнэлэхэд баримталсугай.

4. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.

5. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

6. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Журам, загвар шинэчлэн батлах тухай" А/309 дүгээр тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

0301553



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн  
А/425 дугаар тушаалын хавсралт

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН БОЛОН СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ



### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадварын ахиц амжилт, үр дүн, төлөвшлийг үнэлж, дүгнэх, хөндлөнгийн хяналт, чанарын үнэлгээ хийхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Суралцагчийн үнэлгээ нь сурлагын ахиц, амжилтыг үнэлж, сургалтын арга хэлбэр, зохион байгуулалтад тохируулга хийх; анги дэвших болон сургууль төгсөх шалгалт *Цаашид "улсын шалгалт" гэх/* нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж, сургуулийн үйл ажиллагаа, багшийн арга зүй, ур чадварыг сайжруулах; чанарын үнэлгээ нь боловсролын чанар, үр дүнг тодорхойлж, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгоход тус тус чиглэнэ.

### Хоёр. Үнэлгээнд баримтлах зарчим

2.1. Үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;

2.2. Үнэлж дүгнэх үйл ажиллагаа нь зорилготой, сургалтын хөтөлбөрт нийцсэн, суралцагчийн нас, сэтгэхүй, хөгжлийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг харгалзсан, агуулга, хэлбэр нь уян хатан, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид ойлгомжтой, нээлттэй, ил тод байх;

2.3. Анги дэвших болон улсын шалгалтын сэдэв, даалгавар нь танин мэдэхүйн түвшинд нийцсэн, тохирц, найдварыг шалгасан, нууцлалыг хадгалсан, шалгуулагчдыг хүндэтгэсэн, найдвартай байх.

### Гурав. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ

3.1. Суралцагчийн үнэлгээ нь тэдний эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулахад чиглэнэ.

3.2. Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.

3.3. "Шалгуурт суурилсан үнэлгээ" нь суралцагчийн амжилтын түвшинг хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ.

3.4. Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж, батална.

3.5. Оношлох үнэлгээ нь хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилгоор хийх үнэлгээ байна. Оношлох үнэлгээг ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт, сорил, судалгаа гэх мэт хэлбэрээр хийнэ.

3.6. Явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын явцад тогтмол хийх үнэлгээ байна.

3.7. Явцын үнэлгээг хичээлийн явцад суралцагчийн суралцах үйлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, асуулт, ярилцлага, хэлэлцүүлэг, бие даах ажил, рубрик, суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ гэх мэт арга, хэлбэрээр багш хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичиг /багшийн журнал/-т стандарт бус тэмдэглэгээгээр тэмдэглэж болно.

3.8. Үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил /II улирлын төгсгөл/, хичээлийн жилийн эцэс /IV улирлын төгсгөл/-т хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.

3.9. Үр дүнгийн үнэлгээг аман болон бичгийн шалгалт, сорил, туршилт, судалгааны ажил, тайлан, төсөлт ажил, илтгэл, эссе, бүтээл, биечлэн хийж гүйцэтгэх зэрэг хэлбэрээр хийнэ.

3.10. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэхэд I, II ангид оношлох болон явцын үнэлгээ, III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.

3.11. Үр дүнгийн үнэлгээ нь тухайн хичээл, судлагдахууны агуулгын хүрээнд дараах 8 түвшинтэй байна.

Түвшин	Үнэлгээ, хувиар	Үнэлгээний түвшний шалгуур
VIII	90-100	<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, хууль зарчим, зүй тогтлыг бүрэн ойлгож, шинжлэх ухааны үг хэллэг ашиглан аливаа асуудлыг тайлбарлах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, санал гаргах түвшинд эзэмшсэн</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах ямар ч нөхцөлд хэрэглэдэг</li> <li>Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг</li> <li>Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг</li> <li>Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс оновчтой илэрхийлдэг</li> </ul>
VII	80-89	<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль, зүй тогтол, хоорондын хамаарлыг ойлгож эзэмшсэн</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил бус нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг</li> <li>Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг</li> <li>Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгодог</li> <li>Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ оновчтой илэрхийлдэг</li> </ul>
VI	70-79	<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль зүй тогтлыг ойлгосон</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг</li> <li>Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах үйлийг зааврын дагуу төлөвлөдөг</li> <li>Асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг боловсруулах тохирох аргыг сонгон хэрэглэдэг</li> <li>Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг</li> </ul>
V	60-69	<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчим, хуулийг ойлгосон</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо шинэ нөхцөлд зааврын дагуу хэрэглэдэг</li> <li>Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах, төлөвлөхөд оролцдог</li> <li>Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах тохирох аргыг сонгодог.</li> <li>Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, гол санааг илэрхийлдэг</li> </ul>
IV	50-59	<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг бүрэн ойлгосон.</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нөхцөлд хэрэглэдэг</li> <li>Асуулт асуух, асуудал таамаглал дэвшүүлж, шинжлэн судлах үйлд оролцдог.</li> <li>Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах аргыг сонгон хэрэглэхийг хичээдэг.</li> <li>Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, санал бодлоо энгийн байдлаар илэрхийлдэг</li> </ul>



III	40-49	<ul style="list-style-type: none"> <li>• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг ойлгох, тайлбарлах түвшинд эзэмшсэн</li> <li>• Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил, хялбар нөхцөлд хэрэглэдэг</li> <li>• Бусдын дэмжлэгтэй, зааврын дагуу хялбар асуудлыг шийдвэрлэдэг</li> <li>• Асуулт асууж, таамаглал дэвшүүлдэг</li> </ul>
II	30-39	<ul style="list-style-type: none"> <li>• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх, цэжлэх түвшинд эзэмшсэн</li> <li>• Эзэмшсэн мэдлэг ойлголтоо заавар, аргачлалын дагуу ашигладаг</li> </ul>
I	0-29	<ul style="list-style-type: none"> <li>• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх түвшинд эзэмшсэн</li> </ul>

3.12. I-II ангид суралцагчийн тухайн хичээлийн жилд хүрсэн үр дүнг явцын үнэлгээнд үндэслэн анги удирдсан багш дүгнэн хувийн хэрэгт бичиж, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

3.13. III-XII ангийн суралцагчийг бүлэг сэдвийн төгсгөлд, хичээлийн жилийн II, IV улирлын эцэст тус тус багш үнэлнэ. Энэхүү үнэлгээний үр дүн /хувь/-г ангийн журналд тэмдэглэнэ. IV улирлын эцэст хийсэн үнэлгээ /хувь/ нь жилийн эцсийн дүн байна.

3.14. III-XII ангийн жилийн эцсийн дүн болон анги дэвших, улсын шалгалтын дүнг ангийн журнал, суралцагчийн хувийн хэрэгт анги удирдсан багш тус тус тэмдэглэнэ.

3.15. Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна.

3.16. Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ.

3.17. Ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага багшид зөвлөн туслах зорилгоор суралцагчийн мэдлэг, чадварын түвшинд хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийж болно. Энэхүү үнэлгээ, хяналт-шинжилгээ нь тухайн байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

3.18. Суралцагчийн төлөвшлийг хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажилд оролцсон байдал, идэвх санаачилгын талаарх хичээл заадаг болон анги удирдсан багшийн тэмдэглэл, баримт нотолгоонд үндэслэн дараах чиглэлээр дүгнэж, суралцагчийн хувийн хэрэгт бичнэ.

- санал бодлоо илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, зөрчил, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх байдал;
- бие даан сурах арга барил, бусадтай хамтран ажиллах;
- шинжлэн судлах хүсэл эрмэлзэл, сонирхол, оролцоо;
- соёл, уламжлалаа дээдлэх, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч, ажил хэрэгч байдал;
- хувийн болон орчны эрүүл ахуй, аюулгүй амьдрах, байгальтай харьцах, хамгаалах, нийгмийн харилцаанд оролцох хандлагад гарч буй өөрчлөлт;
- шинэ орчин, харилцаанд дасан зохицох чадварт гарч буй өөрчлөлт.

3.19. Анги удирдсан багш суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний талаарх дүгнэлт, саналыг хичээлийн жилийн II, IV улирлын эцэст эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

3.20. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний мэдээлэл нууцлалтай байх бөгөөд энэхүү мэдээлэлтэй багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч цахим болон бусад хэлбэрээр танилцах боломжийг сургууль бүрдүүлнэ.

### Дөрөв. Анги дэвших шалгалт, түүний зохион байгуулалт

4.1. Анги дэвших шалгалт нь суралцагчийн мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшинг тогтооход чиглэнэ.

4.2. Сургууль нь энэхүү журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуурын дагуу дараах чиглэлээр журмын 3.9-д заасан хэлбэрээс сонгож анги дэвших шалгалтыг зохион байгуулна.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын чиглэл
Бага боловсрол	III	1	Нэгдмэл агуулга /III ангийн хөтөлбөрийн агуулгаар/
	IV	2	<ul style="list-style-type: none"> <li>Сургууль сонгох 1 хичээл</li> <li>Нэгдмэл агуулга /шалгалттай хичээлээс бусад/</li> </ul>
Суурь боловсрол	VI	2	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Сургууль сонгох 1 хичээл</li> </ul>
	VII	3	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Сургууль сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/</li> </ul>
	VIII	3	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Суралцагч сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/</li> </ul>
Бүрэн дунд боловсрол	X	3	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Суралцагч сонгох 1 хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/</li> </ul>
	XI	3	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Сонгох хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгэм судлал, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/</li> </ul>

4.4. Журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуур болон "Анги дэвших шалгалтын бюлпринт" /цаашид бюлпринт гэх/, шалгалт зохион байгуулах нэгдсэн удирдамж, шалгалтын үр дүнд шинжилгээ хийх маягт, зөвлөмжийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор ерөнхий боловсролын сургуульд хүргүүлнэ.

4.5. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь ерөнхий боловсролын сургуулийн анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн "Даалгаврын нээлттэй сан" бүрдүүлж, өмчийн бүх хэлбэрийн сургуульд хүргэх, түүнийг хэрэглэх арга зүйгээр хангах ажлыг хичээлийн жилийн турш зохион байгуулна.

4.6. Анги дэвших болон улсын шалгалт зохион байгуулах ажлыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон "Шалгалтын комисс" зохион байгуулна. Комиссын дарга нь сургуулийн захирал байх бөгөөд сургалтын менежер, багш, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулна. Комиссын гишүүн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл шалгалтын сэдэв, даалгавар боловсруулахад оролцохгүй.



4.7. Энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.7.1. анги дэвших шалгалт зохион байгуулах удирдамж, дэг боловсруулж, хэрэгжүүлэх;

4.7.2. анги дэвших шалгалттай холбогдон гарсан аливаа гомдол, маргааныг эцэслэн шийдвэрлэх;

4.7.3. шалгалтын үнэлгээ, дүн мэдээг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагаас өгсөн зөвлөмж, маягтын дагуу нэгтгэн, шалгалт зохион байгуулж дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдамжаар хангах, хяналт тавих.

4.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын үр дүнд шинжилгээ хийж, сургууль бүрд зөвлөмж боловсруулж, жил бүрийн 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

4.9. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын дүнд үндэслэн зөвлөн туслах ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.10. Сургууль энэхүү журмын 4.8-д заасан зөвлөмжид үндэслэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөн явуулна.

#### Тав. Улсын шалгалт, түүний зохион байгуулалт

5.1. Улсын шалгалт нь бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сурлагын амжилтад хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийхэд чиглэнэ.

5.2. Улсын шалгалтын үр дүн нь бага, дунд боловсролын сургалтын үр ашиг тооцох, сурлагын амжилтыг сайжруулах суурь мэдээлэл болно.

5.3. Бага, суурь бүрэн дунд боловсролын түвшний төгсөх ангийн суралцагч дараах хичээлээр улсын шалгалт өгнө.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын агуулга
Бага боловсрол	V	3	1. Монгол хэл 2. Математик 3. Хүн ба байгаль
Суурь Боловсрол	IX	4	1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт: /суралцагч аль нэгийг сонгоно./ • Байгалийн ухааны нэгдмэл агуулга • Нийгмийн ухаан, түүх /нэгдмэл агуулга/ 4. Гадаадхэл /англи хэл, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/
Бүрэн дунд боловсрол	XII	4	1. Монголхэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх аль нэгийг сонгоно/ 4. Гадаад хэл /англи, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/

5.4. Улсын шалгалтын товыг боловсролын үнэлгээний байгууллагаас жил бүр тогтоох бөгөөд шалгалтыг улсын хэмжээнд зэрэг эхлүүлж, дуусгана.

5.5. Улсын шалгалтын үнэлгээг энэхүү журмын 3.11-д заасан үнэлгээгээр үнэлнэ.

5.6. Олон улсын хөтөлбөрийн сургалттай болон гадаад улстай хамтарсан ерөнхий боловсролын сургуулийг төгсөгчийн шалгалтын хуваарь улсын шалгалттай давхцах тохиолдолд боловсролын үнэлгээний байгууллага зохицуулж болно.

5.7. Боловсролын үнэлгээний байгууллага нь “Улсын шалгалтын бюпринт” /цаашид бюпринт” гэх/, шалгалтын сэдэв боловсруулах, дүгнэх зөвлөмжийг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор баталгаажуулж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

5.8. Боловсролын үнэлгээний байгууллага нь бага, суурь, бүрэн дунд боловсролын анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн “Даалгаврын нээлттэй сан” /цаашид “даалгаврын сан” гэх/ бүрдүүлэх, шинэчлэх, баяжуулалт хийх ажлыг хариуцна.

5.9. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь “Улсын шалгалтын комисс”-ыг жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор байгуулна. Энэхүү комисс нь тухайн орон нутагт улсын шалгалт зохион байгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

5.10. Сургууль дээр улсын шалгалт зохион байгуулахтай холбогдуулан энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.10.1. улсын шалгалтын удирдамж, дэгийг боловсруулж, шалгалтыг зохион байгуулах;

5.10.2. шалгалт эхлэхээс 1 өдрийн өмнө энэхүү журмын 5.7-д заасан бюпринт, зөвлөмжийн дагуу улсын шалгалтын сэдэв боловсруулж, нууцлалыг хариуцах;

5.10.3. шалгалтын дүн мэдээг боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавих;

5.10.4. хөгжлийн бэрхшээлтэй суралцагч шалгалт өгөх тохиолдолд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон шалгалтын орчин бүрдүүлэх;

5.10.5. улсын шалгалттай холбогдон гарсан аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэх;

5.10.6. шалгалтын материал, тайланг сургуулийн архивт хүлээлгэн өгөх.

5.11. Шалгалт зохион байгуулах хугацаанд улсын болон олон улсын уралдаан, тэмцээнд оролцсон суралцагчийн улсын шалгалтын үнэлгээг нотлох баримтад үндэслэн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

5.12. Суралцагч өвчлөх, ар гэрийн гачигдал тохиолдох болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас шалгалт өгөөгүй эсвэл дутуу өгсөн тохиолдолд улсын шалгалтын үнэлгээг жилийн эцсийн үнэлгээгээр тооцож болно.

5.13. Боловсролын үнэлгээний байгууллага нь боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан улсын шалгалтын дүнд шинжилгээ хийж, жил бүрийн 10 дугаар сард багтаан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ.

5.14. Журмын 5.9-д заасан “Улсын шалгалтын комисс” нь улсын шалгалт зохион байгуулсан тайланг нэгтгэн, шалгалт дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### **Зургаа. Чанарын үнэлгээ, түүний зохион байгуулалт**

6.1. Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.

6.2. Чанарын үнэлгээг боловсролын үнэлгээний байгууллага зохион байгуулна.



6.3. Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна.

6.4. Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээ зохион байгуулах товыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтооно.

6.5. Чанарын үнэлгээг зохион байгуулах агуулгын хүрээ, шалгуурыг боловсролын үнэлгээний байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага хамтран жил бүрийн 01 дүгээр сард багтаан тогтооно.

6.6. Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулах удирдамж, аргачлалыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулна.

6.7. Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээний өгөгдлийн сан үүсгэх, дүн шинжилгээ хийж, тайлан, санал, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.8. Чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн энэхүү журмын 6.7-д заасан байгууллага бодлого боловсруулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.

6.10. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага чанарын үнэлгээний тайланд үндэслэн сурлагын амжилтыг сайжруулах төлөвлөгөө гаргаж ажиллана.

6.12. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.

### **Долоо. Бусад**

7.1. Аливаа төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх, шалгалт зохион байгуулахыг хориглоно.

.....0 0 0.....



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/453

Улаанбаатар хот

Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай

Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" улсын 2 дугаар зөвлөгөөнд оролцогчдын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын төлөвлөгөөг нэгдүгээр, дунд ангийн сургалтын төлөвлөгөөг хоёрдугаар, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг гуравдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангид 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

3. Шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /М.Итгэл/, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөр, багийн бүрэлдэхүүн батлах тухай" 2014 оны А/240 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2015 оны А/220 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Сургалтын төлөвлөгөө батлах тухай" 2017 оны А/61 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

001590

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын

2018 оны 07 дугаар сарын 09 -ны өдрийн

А/453 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



БАГА АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д.д	Хичээл	Анги					Нийт цаг
		I	II	III	IV	V	
1	Бэлтгэл хөтөлбөр	60					60
2	Монгол хэл	203	224	231	231	231	1120
3	Математик	116	160	165	165	165	771
4	Хүн ба орчин	87	96	99			282
5	Хүн ба нийгэм				33	66	99
6	Хүн ба байгаль				66	66	132
7	Дүрслэх урлаг, технологи	58	64	66	66	66	320
8	Хөгжим	58	64	66	66	33	287
9	Биеийн тамир	58	64	66	66	66	320
10	Эрүүл мэнд				33	33	66
11	Англи хэл					99	99
	Дүн	640	672	693	726	825	3556
Сургалт дэмжих үйл ажиллагаа							
1	Иргэний боловсрол (ёс суртахуун)	29	32	33	33	33	160
2	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	58	32	33	33	33	189
	Дүн	87	64	66	66	66	349
	Жилийн нийт цаг	727	736	759	792	891	3905
	Долоо хоногийн нийт ачаалал	22.7	23.0	23.0	24.0	27.0	
	Өдрийн ачаалал	4.5	4.6	4.6	4.8	5.4	

Тайлбар:

- Хичээлийн жилд I, II анги 32 долоо хоног, III-V анги 33 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа I-II ангид 35 минут, III-V ангид 40 минут байна.
- Нэгдүгээр ангийн "Бэлтгэл" хөтөлбөр нь сурагчдыг сургуулийн амьдрал, сурах үйл ажиллагаанд бэлтгэхэд чиглэсэн нэгдмэл агуулгатай үйл ажиллагаа бөгөөд хичээлийн жилийн эхэнд хэрэгжүүлнэ.
- Сургалт дэмжих үйл ажиллагааны цагийг хичээлийн цагт тооцно. Иргэний боловсрол, хичээлээс гадуурх үйл ажиллагааг зөвлөмжийн дагуу хэрэгжүүлнэ.
- Иргэний боловсрол нь сурагчдыг үндэсний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг дээдлэн хайрладаг, хамтач энэрэнгүй, үнэнч шударга, эх оронч, ёс суртахуунлаг иргэнийг төлөвшүүлэхэд чиглэнэ.
- Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цаг нь сурагчдын оролцоонд суурилсан үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэхэд чиглэнэ.



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны 07 дугаар сарын 09 -ны өдрийн  
1453... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ДУНД АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д.д.	Хичээл	Анги	VI	VII	VIII	IX	Нийт цаг
1	Монгол хэл		105	70	70	70	315
2	Үндэсний бичиг		70	70	70	70	280
3	Уран зохиол		70	70	70	70	280
4	Математик		175	140	140	140	595
5	Мэдээллийн технологи		35	35	35	35	140
6	Физик		35	70	70	70	245
7	Биологи		35	70	70	70	245
8	Хими		35	70	70	70	245
9	Газар зүй			35	35	35	105
10	Түүх		35	70	70	70	245
11	Нийгэм судлал			35	35	35	105
12	Дүрслэх урлаг		35	35	35		105
13	Хөгжим		35	35	35	35	140
14	Зураг зүй						
15	Технологи		70	70	70	70	280
16	Биеийн тамир		70	70	70	70	280
17	Эрүүл мэнд		35	35	35	35	140
18	Англи хэл		105	105	105	105	420
19	Орос хэл			70	70	105	245
		Дүн	945	1155	1155	1155	4410
Сургалт дэмжих үйл ажиллагаа							
1	Иргэний боловсрол		35	35	35	35	140
2	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа		35	35	35	35	140
		Дүн	70	70	70	70	280
		Жилийн нийт цаг	1015	1225	1225	1225	4690
		Долоо хоногийн нийт ачаалал	29.0	35.0	35.0	35.0	
		Өдрийн нийт ачаалал	5.8	7.0	7.0	7.0	

Тайлбар:

1. Хичээлийн жилд 35 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.
2. Сургалтын төлөвлөгөөний заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлог болон багшийн нөөц зэрэг хүчин зүйлст үндэслэн ээлжит хичээлийн үргэлжлэх хугацааг сургууль 80 минутаар зохион байгуулж болно.
3. Сургалт дэмжих үйл ажиллагааны цагийг хичээлийн цагт тооцно.
4. Сургалт дэмжих үйл ажиллагааг аль ч хичээлийг зохион байгуулж буй багш удирдаж болно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн  
...А/453 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

АХЛАХ АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д.д	Хичээл	Анги	X	XI	XII	Нийт цаг	
<b>Заавал судлах</b>							
1	Монгол хэл		35	35	35	105	
2	Үндэсний бичиг		70	35	35	140	
3	Уран зохиол		35	35	35	105	
4	Математик		105	105	105	315	
5	Мэдээллийн технологи		35	35	35	105	
6	Физик		70	70		140	
7	Хими		70	70		140	
8	Биологи		70	70		140	
12	Монголын түүх		35	35		70	
13	Нийгэм судлал		70	70		140	
14	Газар зүй		70	70		140	
15	Англи хэл/Орос хэл		105	105	105	315	
16	Биеийн тамир		70	70	70	210	
17	Эрүүл мэнд		35	35	35	105	
18	Дизайн/зураг зүй, технологи		70	70	70	210	
			<b>Дүн</b>	<b>945</b>	<b>910</b>	<b>525</b>	<b>2380</b>
<b>Сонгон судлах</b>							
Хэл	Монгол хэл, бичиг						
	Уран зохиол						
	Англи хэл						
	Орос хэл						
Математик	Математик						
Байгалийн ухаан	Биологи						
	Физик						
	Хими						
Нийгмийн ухаан	Монголын түүх						
	Нийгэм судлал						
	Газар зүй						
	Бизнес судлал						
Дизайн технологи	Дизайн, зураг зүй						
	Техник технологи						
	Мэдээллийн технологи						
Сургууль зохицуулах цаг			70	70	70		
Жилийн нийт цаг			1225	1225	1225	3675	
Долоо хоногийн нийт ачаалал			35	35	35		
Өдрийн нийт ачаалал			7	7	7		

Тайлбар:

- Хичээлийн жилд 35 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна. Сургууль 80 минутаар хичээллэх зохицуулалт хийж болно.
- Сургалтын төлөвлөгөөний заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлог болон багшийн нөөц зэрэг хүчин зүйлст үндэслэн сурагчийн хэрэгцээ сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлнэ.
- Сурагч заавал судлах англи, орос хэлний аль нэгийг судална.
- Сурагч X ангид 4 хичээлийг 7 хоногт 1-2 цагаар, XI ангид 3 хичээлийг 7 хоногт 2-3 цагаар, XII ангид 3 хичээлийг 7 хоногт тус бүр 3-4 цагаар сонгон судална.
- Заавал судлах хичээлийг 10, 11, 12 дугаар ангийн сурагчдаас бүрдсэн холимог бүлгээр хичээллэж болно.
- Заавал судлах болон сонгон судлах хичээл давхацсан тохиолдолд сонгон судлах хичээлийн цаг дээр заавал судлах хичээлийн цагийг нэмж, заавал болон сонгон судлах хичээлийн хөтөлбөрийг баримтлан хичээллэнэ.



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/460

Улаанбаатар хот

Загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн I-II ангийн багшийн журнал хөтлөх заавар, загварыг нэгдүгээр, III-XII ангийн журнал хөтлөх заавар, загварыг хоёрдугаар, анги удирдсан багшийн дэвтэр хөтлөх заавар, загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд энэхүү тушаалаар батлагдсан загварын дагуу багшийн журналыг хэвлэн түгээж, сургалтад хэрэглэх ажлыг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын газар /Т.Ням-Очир/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны "Загвар шинэчлэн батлах тухай" А/283 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн I-III ангийн багшийн журнал, IV-XII ангийн журнал, анги удирдсан багшийн дэвтрийн загвар"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

0301638





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/467

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Бага, дунд боловсролын тухай 7 дугаар зүйлийн 7.3 дэх хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулах, эрүүл мэндийн хичээл заах багш бэлтгэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Боловсролын Хүрээлэн /П.Лхагвасүрэн/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Д.Сүрэнчимэг/-д тус тус даалгасугай.

4. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/-т даалгасугай.

5. Ерөнхий боловсролын сургуульд "Эрүүл мэнд" хичээлийг арга зүйн сургалтаар бэлтгэгдсэн багшаар заалгах, сургалтын хөтөлбөрийг хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар суралцагчийн нас, хөгжлийн онцлогт нийцүүлэн үр дүнтэй зохион байгуулахыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-д даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

0301680



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/496

ҮГИЙНБӨЛГӨӨ ХҮТ

Бодлогын баримт бичиг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэхь хэсэг, Засгийн газрын 2017 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 270 дугаар тогтоолын 3.4.1.1 дэх зорилтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого"-ыг хавсралтаар баталсугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлогыг багш, эцэг эх, олон нийтэд сурталчилан таниулах, хэрэгжүүлэхэд арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т даалгасугай.

3. Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж ажиглахыг Аймаг, Нийслэлийн боловсролын газрын дарга, өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Бодлогын хэрэгжилтэд жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиглахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

001687

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны ... дугаар сарын ... -ны  
өдрийн ... дугаар тушаалын хавсралт



## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

### Нэг. Үндэслэл

Монгол Улс нь 1992 онд Үндсэн Хуулиа ардчиллын зарчимд тулгуурлан шинээр батлан гаргаж, "Хүний эрх, эрх чөлөө" гэсэн Хоёрдугаар бүлэгт 80 орчим эрх, эрх чөлөөг тусгайлан нэрлэж, баталгаажуулсан бөгөөд 14 дүгээр зүйлийн 2-т "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэж заасан.

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд хүүхэд бүр аливаа хүчирхийллээс хамгаалуулах эрхтэй бөгөөд насанд хүртлээ эцэг эх, гэр бүл болон төрийн онцгой халамж, хамгаалалтанд байх шаардлагатай болохыг заажээ.

Түүнчлэн Монгол Улсын Хүүхэд Хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал хэсгийн 6.1 дэх хэсэгт "Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана" гэж заасны дагуу ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхэд бүрийг сургууль, дотуур байрын орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол улсад 2017 оны байдлаар нийт хүн амын 38,5%-ийг 0-18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Үүнээс, 1066 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон, 1758 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон, 187 хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон харамсалтай дүн мэдээ байна. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2017 онд өдөрт 500 дуудлага ирсэн, 2018 онд өдөрт 1200 дуудлага болж нэмэгдсэн нь хүүхэд хамгааллын асуудлыг бодлого, хэрэгжилтийн түвшинд үр дүнтэй зохион байгуулах хэрэгтэй байгааг харуулж байна.

Энэхүү бодлого батлагдсанаар сургууль, дотуур байрын орчинд суралцагчдыг аливаа болзошгүй эрсдэлт нөхцөлд өртөхөөс /цаашид эрсдэлт нөхцөлд өртөх гэх/ урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдээлэл, таамаглалыг хүлээн авах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хяналт үнэлгээний нэгдсэн тогтолцоо бий болж суралцагчийн хамгаалал, аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

### Хоёр. Зорилго

Хамтарсан баг, иргэний нийгэм, салбар, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэх, үл хайхрах байдал, аливаа болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх

чадавхийг нэмэгдүүлэх, сургуулийн орчин дах суралцагчийн хамгааллын үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэгдэнэ.

### **Гурав. Зорилт**

Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого нь дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

- Сургууль, дотуур байранд хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй материаллаг болон нийгэм, сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг ханган ажиллана.
- Мэдээллийг хүлээн авах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг эрсдлээс хамгаалах, түүнийг бууруулахад үнэлгээ хийж, арга хэмжээ авна.
- Хохирогч хүүхдэд боловсролын үйлчилгээг тасралтгүй олгон, хүүхэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

### **Дөрөв. Баримтлах зарчим**

*Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална.*

- Боловсролын байгууллагын сургалтын орчин, сургууль болон дотуур байранд суралцагч бүрийг хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж, тэдний аюулгүй байдлыг хангах;
- Хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд өртсөн, өртөж болзошгүй талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн бол мэдээллийг хүлээн авах, сургууль болон дотуур байрын орчин, нөхцөл нь суралцагч, мэдээлэгчид ээлтэй, тэдэнд хор хөнөөл учруулахгүй байх;
- Боловсролын байгууллагын сургалтын орчин, сургууль, дотуур байранд хүчирхийлэл болон аливаа болзошгүй эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, хянах, үнэлэхэд оролцогч талууд тэгш, идэвхтэй хамтын ажиллагаа, оролцоог эрхэмлэх;
- Хүүхдийг тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцуулахгүй байх;

### **Тав. Хамрах хүрээ**

Хүүхэд хамгааллын бодлого нь өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш, дотуур байрын багш, ажилтан, гэрээт ажилчин, сайн дурын ажилтан, суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад хамаарна.

## Зургаа. Үйл ажиллагааны чиглэл

**Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** *Сургууль, дотуур байранд хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангах талаар*

- Хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлж “Сургуулийн бүс-техникийн ерөнхий шаардлага” стандартын хэрэгжилтийг хангах, орчныг аюулгүй бүс болгох
- Хүүхдийг сургуульдаа ирэх, буцах замын аюулгүй байдлыг судлах, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Дотуур байранд гадны хүн байрлуулахгүй байх асуудлыг дүрэмд тусган мөрдөх
- Хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлыг үр дүнтэй зохион байгуулах
- Сургууль, дотуур байрын орчныг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байхаар тохижуулах, үнэлгээ хийж сайжруулах ажлыг үе шаттай зохион байгуулах
- Хүүхдэд байгалийн гамшиг, онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварт сургах дасгал сургуулилт хийх орчин бүрдүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах
- Ерөнхий боловсролын сургуулийн орчны стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх

*Хүүхдийн эрхийг хангасан нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр*

- Сургалтын байгууллагын багш, ажилтан, суралцагчдын хоорондын нөхөрсөг бус харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, гэр бүлд мэдээлэх, зохицуулах, хүмүүжүүлэн төлөвшүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг орон нутаг, байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулах
- Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, зүй бус хандлага, гэмт хэрэг, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор ганцаарчилсан болон нийт хүүхдэд зориулсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх
- Сургуулийн орчинд хүүхдэд ээлтэй нийгэм, сэтгэлзүйн харилцааны орчинг бий болгоход чиглэсэн нөлөөллийн ажлыг суралцагчдын оролцоотой зохион байгуулах замаар сургуулийн орчинд энэ төрлийн аливаа дарамтгүй болох (хүүхдүүд бие махбод, сэтгэл зүйн дарамт, хэл амаар доромжлогдох, аливаа хэлбэрийн хүчирхийллээс хамгаалагдсан байна.)
- Анги удирдсан багш, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр суралцагч болон тэдний эцэг эх, асран хамгаалагч нарын дунд хүүхдийг аливаа болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдийг хүчирхийллийн бүс, уламжлалт аргаар хүмүүжүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, үүнд



шаардлагатай зардлыг сургуулийн хүүхэд хамгаалалд зориулсан төсвөөс гаргадаг байх

- Сургууль дээр хүүхдийн үүсгэл санаачлагаар байгуулагдсан өөрийн удирдлагын байгууллага болон сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах, хүүхдийн оролцооны байгууллагын ажиллах өрөөтэй болох, дэмжлэг үзүүлэх
- Сургууль, дотуур байрын орчинд зүй бус хандлагыг үл тэвчих соёлыг бий болгох, бие махбодийн шийтгэлийг хориглох талаар бүх багш, ажилтан, суралцагчид мөрдөж хэрэгжүүлэн ажиллах

### **Зорилт 2-ыг хэрэгжүүлэх хүрээнд:**

*Мэдээллийг хүлээн авах, хүүхэд хамгааллын харуу үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг эрсдлээс хамгаалах арга хэмжээ авах чиглэлээр*

- Сургууль, дотуур байрын орчинд зохион байгуулж буй үйл ажиллагааны үеэр дарамт, үл хайхрах байдалд өртсөн, өртсөн байж болзошгүй, хүүхдийн аюулгүй байдал алдагдсан байхаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн талаарх мэдээллийг дамжуулсан суралцагч болон мэдээлэгчид хор хөнөөл учруулахгүй хүлээн авах, шалгах, мэдээллийн мөрөөр шуурхай арга хэмжээ авах тухай “Мэдээллийн журам”-ыг боловсруулан баталж, мөрдөх
- Хүүхдийн эрхийг зөрчсөн талаарх мэдээллийг Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад /хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, цагдаагийн байгууллага, хамтарсан баг, хүүхдийн эрхийн улсын байцаагч/ мэдээлж, тэдэнтэй хамтран ажиллах замаар хүчирхийллийн хор хөнөөлийг багасган, аливаа болзошгүй эрсдэлд дахин өртөхөөс сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Сургууль, дотуур байрын үйл ажиллагаа, гадаад болон дотоод орчинд хүүхдэд учирч болзошгүй нөхцөл байдал, эрсдлийн үнэлгээ хийх, зураглал гаргах ажлыг сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, анги удирдсан багш, дотуур байрын багш, эцэг эхийн оролцоотойгоор үнэлж, зохион байгуулах
- Эрсдлийн үнэлгээнд суурилан эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн шат дараалсан арга хэмжээ авч, хүүхэд бүрийг тэгш хамруулан суралцах, хөгжих, хамгаалах боломжийг бүрдүүлэх, сургалт, сурталчилгаа тогтмол хийх
- Хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг тандан судлах
- Яаралтай үед хүүхэд ашиглаж болох утасны цэг, анхны тусламжийн хайрцаг зэргийг тодорхой цэгт байрлуулах, сурагчдад сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хангах зэрэг зарим боломжит үйлчилгээнүүдийг сургуулийн хүрээнд зохион байгуулах, эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээг хангахуйц байх

*Багш, ажилтан, сайн дурын ажилтан сонгон шалгаруулах,  
ажлын байран дээрх сургалтуудыг тогтмол зохион байгуулах  
талаар*

- Сургууль, дотуур байрын орчинд хүүхэдтэй шууд ба шууд бус харьцах удирдах ажилтан, багш, ажилчин, сайн дурын ажилтан ажилд авахдаа мэргэжлийн мэдлэг чадварыг илтгэх баримт бичгүүдээс гадна өмнөх ажил олгогчийн тодорхойлолт, хүүхдийн эсрэг хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхийг нотлох эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг авч сайтар нягталж шалгах
- Хүүхэдтэй зүй бусаар харьцаж байсан эсэхийг багш, ажилтан сонгон шалгаруулах үзүүлэлтэд заавал оруулах
- Багшийн ёс зүйн дүрмийн заалтуудыг сургууль, дотуур байранд шинээр ажилд орсон хүүхэдтэй шууд ба шууд бус харилцан ажиллах бүх багш, ажилтанд танилцуулж, хүлээн зөвшөөрсөн гарын үсгийг зуруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөхөд хяналт тавих
- Сургуулийн захирал нь сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ажлын байран дахь сургалтыг нийт багш, ажилтанд улирал тутам зохион байгуулж, сургалтын үр дүнг үнэлж, дүгнэх
- Сургуулийн удирдлагын зүгээс Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой шат дараалсан арга хэмжээний тухай ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, хүчирхийллийн хэлбэрүүдийг таних, мэдээлэх, аливаа болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг сургуулийн бүх багш, ажилтнууд, улмаар суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчдын дунд мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах.

**Зорилт 3-ыг хэрэгжүүлэх хүрээнд: Хохирогч хүүхдэд боловсрол тасралтгүй олгох, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр**

- Багш, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрын багш, эцэг эх асран хамгаалагчийн шууд оролцоотойгоор хүчирхийлэлд болон эрсдэлд өртсөн хохирогч хүүхдийг үргэлжлүүлэн суралцах боломж, нөхцөлийг бүрдүүлж, суралцах үйл явцад нь дэмжлэг үзүүлэх ажлыг хамран сургах тойрог харгалзахгүйгээр сургуулийн захирал хариуцан зохион байгуулах
- Хүчирхийлэл, эрсдэлд өртсөн, хохирогч болсон хүүхдэд сэтгэл санааны хямралаа даван туулахад нь туслах, тэдэнд учирсан нийгэм сэтгэл зүй, эрүүл мэндийн таагүй нөлөөллийг багасгах, эргэн хэвийн амьдралдаа ороход нь туслах, зөвлөх үйлчилгээг сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, мэргэжлийн байгууллагатай хамтран үзүүлэх
- Сургууль, дотуур байранд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч байхгүй тохиолдолд орон нутгийн холбогдох байгууллагаас мэргэжлийн дэмжлэг тусалцаа авах, тэдгээр байгууллагын үйлчилгээнд хохирогч хүүхдийг холбон зуучлах үйл ажиллагааг сургуулийн захирал зохион байгуулах

- Сургууль, дотуур байрын үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах, бодлого боловсруулахад эцэг эхийн зөвлөл, олон нийтийг татан оролцуулах, байнгын дэмжлэг, түншлэлийг бий болгох
- Суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчдад сургуулийн хүүхэд хамгааллын бодлого, холбогдох журмыг эцэг эхийн хурал, хэлэлцүүлэг, өдөрлөг, уулзалт, ярилцлага, сургалт зэрэг үйл ажиллагаануудаар дамжуулан танилцуулах, тэдэнд хүүхэд хамгааллын бодлогын хувийг хүргүүлж, сургуулийн хүүхэд хамгааллын багийг танилцуулж ажиллах
- Эцэг эх, олон нийтийн насан туршдаа суралцах ялангуяа хүүхдэд зөв үлгэр дууриал үзүүлэх, харилцах, тэднийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж, нийт эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийг хамруулах

### **Долоо. Удирдлага, зохион байгуулалт**

- Аймаг, нийслэлийн боловсролын газар, сум дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэрийн сургууль, дотуур байрын Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, хяналт, үнэлгээнд шаардагдах төсөв, хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, төсвийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавина.
- Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн байдал, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд гарсан хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдол, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдээ, тайланг тогтмол хугацаанд нэгтгэж, төрийн захиргааны төв байгууллагад улирал тутам илгээнэ.
- Сургуулийн захирал нь сургууль дээрх хүүхэд хамгааллын асуудлыг хариуцах бөгөөд сургуулийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш, эмч, сэтгэлзүйч нарын төлөөлөөс бүрдсэн хүүхэд хамгааллын багтай хамтран зохион байгуулна. Энэхүү баг нь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавина.
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хөрөнгийг сургуулийн жилийн төсөвт тусган, зохих үйл ажиллагаанд зарцуулж, тайланг хагас жил тутам гаргана.
- Сургууль, дотуур байрын орчинд хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх ажилд хяналт тавина.
- Аймаг, нийслэлийн боловсролын газар, сум дүүргийн боловсролын хэлтэс орон нутгийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан хүүхдийн нас бие, танин мэдэхүйн онцлогт тохирсон хүүхэд хамгаалал, хүүхдийг уламжлалт болон эерэг аргаар хүмүүжүүлэх, хүчирхийлэл, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр, модулыг нарийвчлан боловсруулж, сургуулийн удирдлага, багш, ажилтныг сургах,
- Сургуулийн захирал нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж, холбогдох мэдээллийг дээд шатны боловсролын байгууллагад улирал тутам мэдээлнэ.

### Найм. Хяналт үнэлгээ

- Сургууль, дотуур байрын орчны эрсдлийн үнэлгээг сургуулийн захирал, дотуур байрын багш, нийгмийн ажилтан, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын төлөөлөл, эцэг эхийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн баг хийх бөгөөд хүүхдийг болзошгүй эрсдэлд хүргэх өндөр эрсдэлтэй үйл ажиллагааны жагсаалтыг гарган эрсдлийг бууруулах арга хэмжээг үе шаттай авч, хэрэгжүүлэх
- Аймаг, нийслэлийн боловсролын газар, сум дүүргийн боловсролын хэлтэс харъяа нутаг дэвсгэрийн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байр бүрийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг эцэг эхийн зөвлөлтэй хамтран жил бүр хийж, үр дүн бүхий тайланг жил бүрийн 06 дугаар сарын 10-ны дотор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг жил тутам тогтмол үнэлж, үнэлгээний дүнд үндэслэн салбарын хүүхэд хамгааллын бодлогыг эргэн харах, сайжруулах арга хэмжээ авна.

### Ес. Хүрэх үр дүн

- Сургууль, дотуур байранд хүүхдийг сурч, амьдрахад эрүүл, аюулгүй хамгаалагдсан орчин бүрдэнэ.
- Хүүхэд, эцэг эх, багш нар хүүхдийн эрх, хамгааллын талаар нэгдсэн ойлголттой болсноор бусдын ялгаатай байдлыг ойлгосон, хүүхдийг хүндэтгэсэн, хамгаалсан, зүй бус хандлагыг үл тэвчсэн, хохирлыг арилгасан нийгэм сэтгэлзүйн таатай орчин бүрдсэн байна.
- Эцэг эх, иргэд, олон нийт сургуулийн үйл ажиллагаанд бүтээлчээр оролцсоноор хүүхдийн өмнө хүлээх хариуцлага сайжирч, боловсролын үйлчилгээг эрүүл, аюулгүй, эрсдлээс хамгаалагдсан, боловсролд тэгш хамруулсан, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг авах боломж нэмэгдэнэ.

--- оОо ---



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/491

Улаанбаатар хот

Сургалтын төлөвлөгөө шинэчлэн  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөөг нэгдүгээр, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг хоёрдугаар, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөөг гуравдугаар, харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөөг дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан сургалтын төлөвлөгөөг ерөнхий боловсролын тусгай сургуулийн бага, дунд, ахлах ангид 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

3. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн батлах тухай" А/311 дүгээр тушаалын дөрөв, тав, зургаадугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

001766



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 08 дугаар сарын 06 өдрийн тушаалаар тушаалын гуравдугаар хэсэртэй

Сонголлын бархшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө

Д.д	Хичээл, судлагдахуун	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Бүгд
1	Бэлтгэл	80												80
2	Монгол хэл	196	224	231	198	175	175	175	140	70	70	70	70	1922
3	Уран зохиол					70	70	70	70	70	70	70	70	450
4	Бичиг					35	35	35	35	35	35	35	35	245
5	Математик	140	160	165	165	175	140	140	140	140	140	140	140	1845
6	Мэдээллийн технологи					35	35	35	35	35	35	35	35	250
7	Физик					35	35	35	35	35	35	35	35	245
8	Байгалийн ухаан					35	35	35	35	35	35	35	35	245
9	Хими					35	35	35	35	35	35	35	35	245
10	Биологи					35	35	35	35	35	35	35	35	245
11	Нийгмийн ухаан					35	35	35	35	35	35	35	35	245
12	Нийгэм судлал					35	35	35	35	35	35	35	35	245
13	Түүх					35	35	35	35	35	35	35	35	245
14	Урлаг				33	33	33	33	33	33	33	33	33	206
15	Газар зүй					35	35	35	35	35	35	35	35	245
16	Нийгэм ахуйн баримжаа	56	64	66	66	66	66	66	66	66	66	66	66	404
17	Технологи /мэргэжлийн чиг баримжаа/					140	140	140	175	210	210	210	210	1295
18	Англи хэл					33	70	70	70	70	105	105	105	628
19	Биеийн тамир	56	64	66	66	66	66	66	66	66	66	66	66	404
20	Эрүүл мэнд					33	33	33	33	33	33	33	33	211
21	Эрүүл мэнд					33	33	33	33	33	33	33	33	211
22	Тогтвортой агуулгын нийт цаг	528	512	528	561	594	1050	1120	1120	1120	1050	1085	1085	10353
23	Яриа бичиг	56	64	66	66	66	66	66	66	66	66	66	66	404
24	Сонгол дуудлага	28	32	33	33	33	33	33	33	33	33	33	33	159
25	Биет зүйл	56	64	66	66	66	66	66	66	66	66	66	66	318
26	Аязамт хөдөлгөөнт дасгал	28	32	33	33	33	33	33	33	33	33	33	33	159
27	Дохионы хэл	28	32	33	33	33	33	33	33	33	33	33	33	159
28	Хэл засал	28	32	33	33	33	33	33	33	33	33	33	33	159
29	Эмчилгээний биеийн тамир					35	35	35	35	35	35	35	35	245
30	Сургалтын зохицуулах агуулгын нийт цаг	196	224	231	231	231	105	105	105	105	105	105	105	1848
31	Иргэний боловсрол /бс сургахуун/					35	35	35	35	35	35	35	35	140
32	Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа	28	32	33	33	33	35	35	35	35	35	35	35	404
33	Сонгол суралцах хичээлийн цаг					35	35	35	35	35	35	35	35	450
34	Хичээлийн жилийн нийт цаг	28	32	33	33	33	105	105	105	105	105	105	105	999
35	Долоо хоногийн цаг	752	764	792	825	858	1260	1330	1330	1330	1295	1330	1330	13200
36	Өдрийн цаг	23	24	24	25	26	36	38	38	38	37	38	38	318
37	Бүтцийн цаг	4.6	4.8	4.8	5	5	7.2	7.6	7.6	7.6	7.4	7.6	7.6	404

- Тайлбар:
- Хичээлийн жилд I-II анги 32, III-V анги 33, VI-XII анги 35 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.
  - Сургалтын төлөвлөгөөг заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлог болон багшийн нөөц боломжид тулгуурлан тухайн анги, боловсролын түвшинд уян хатан байхаар хэрэгжүүлнэ.
  - Хэл засал, эмчилгээний биеийн тамирын хичээлийг ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулна. I-XII ангид нэг хүүхдэд долоо хоногт 1 цаг орно. Хэл засал, эмчилгээний биеийн тамирын хичээлд хамрагдах шаардлагатай суралцагчийг нарийн мэргэжлийн эмчийн онош, сургуулийн эмнэлэг-сурган хүмүүжүүлэх комиссын шийдвэрээр тогтооно. Дохионы хэл хичээлийг дохионы хэлний өндөр чадвартай багш даана.
  - Сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагийг хичээлийн цагт тооцно. Сургалтыг дэмжих үйл ажиллагааг аль ч хичээл, судлагдахууны багш удирдаж болно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны 02 дугаар сарын 06 бөдрийн хурал дугаар  
тушаальн хоёрдугаар хэсэрт



Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөө

Д.д	Хичээл, судлагдахуун		X	XI	XII	Бүгд
1	Тогтвортой агуулга	Монгол хэл	70	70	70	210
2		Уранзохиол	35	35	35	105
3		Математик	70	70	70	210
4		Мэдээлэл зүй	35	35	35	105
5		Түүх, нийгмийн ухаан	70	70	70	210
6		Байгалийн ухаан	70	70	70	210
7		Мэргэжлийн сургалт	420	420	420	1260
8		Биеийн тамир	70	70	70	210
9		Англи хэл	70	70	70	210
Тогтвортой агуулгын нийт цаг			<b>910</b>	<b>910</b>	<b>910</b>	<b>2730</b>
10	Сургууль зохицуулах агуулга /засан сайжруулах/	Хэл засал	Ганцаарчилсан сургалт 20 минут, бүлгийн сургалт 40 минут			
11		Эмчилгээний биеийн тамир	Ганцаарчилсан сургалт 20 мин			
12	Сургалтыг дэмжих үйл ажиллагаа	Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа	70	70	70	210
13		Сонгон суралцах агуулгын цаг	70	70	70	210
Сургалтыг дэмжих үйл ажиллагааны нийт цаг			<b>140</b>	<b>140</b>	<b>140</b>	<b>420</b>
Хичээлийн жилийн нийт цаг			<b>1050</b>	<b>1050</b>	<b>1050</b>	<b>3150</b>
Долоо хоногийн цаг			30	30	30	
Долоо хоногийн ачаалал			6	6	6	

Тайлбар:

1. Хичээлийн жилд X-XII ангид 35 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.
2. Хэл заслын хичээлийг ганцаарчилсан, бүлгийн хэлбэрээр, эмчилгээний биеийн тамирын хичээлийг ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулна. Хэл засал, эмчилгээний биеийн тамирын хичээлд хамрагдах шаардлагатай суралцагчийг нарийн мэргэжлийн эмчийн онош, сургуулийн эмнэлэг-сурган хүмүүжүүлэх комиссын шийдвэрээр тогтооно. Хэл засал, эмчилгээний биеийн тамирын хичээл нэг хүүхдэд 7 хоногт 1 цаг орно.
3. Мэргэжлийн сургалтын төрлийг суралцагчдын сонирхол, сургуулийн бодит боломжид тулгуурлан сонгож, сургалтыг зохион байгуулна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн тушаалаар душаалын дөрөвдүгээр хавсралт

Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө

Д.д	Хичээл, судлагдахуун	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Бүгд
1	Бэлтгэл	80												80
2	Монгол хэл, бичиг	196	224	231	231	231	140	140	175	175	105	105	105	2058
3	Уранзохиол													490
4	Математик	168	192	198	198	198	175	175	175	140	140	140	140	2074
5	Мэдээллийн технологи													595
6	Хүн ба нийгэм				33	33								66
7	Түүх													35
8	Нийгмийн ухаан													35
9	Хүн ба орчин	56	64	66										325
10	Хүн ба байгаль													186
11	Байгалийн ухаан													66
12	Физик													350
13	Хими													455
14	Биологи													455
15	Дурлах урлаг, технологи	56	64	66	66	66								318
16	Хөгжим	56	64	66	66	66								598
17	Дизайн													318
18	Технологи													595
19	Газар зүй													350
20	Англи хэл													801
21	Биеийн тамир	56	64	66	66	66								808
22	Эрүүл мэнд													311
23	Тогтвортой агуулгын нийт цаг	668	672	693	726	792	980	1155	1190	1190	1155	1155	1155	11531
24	Айзамт хөдөлгөөнт дасгал	28	32	33	33	33								159
25	Асуулгүй байдлын үндэс													159
26	Ахуйн баримжаа													175
27	Хөдөлгөөн орон зайн баримжаа													
28	Улдэгдэл харааг хамгаалах, харааны хүртэхгүйг сайжруулах													
29	Хэл засал													
30	Эмчилгээний биеийн тамир													
31	Мэргэжлийн чиг баримжаа													
32	Мэргэжлийн чиг баримжаа													
33	Дадлага													
34	Сургууль зохицуулах агуулгын нийт цаг	28	32	33	33	33	0	0	35	35	35	35	35	334
35	Иргэний боловсрол /ёс суртахуун/													140
36	Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа	56	64	66	66	66	33	33	35	35	35	35	35	497
37	Сонгон суралцах хичээлийн цаг													455
38	Сургалтыг дэмжих үйл ажиллагааны нийт цаг	56	64	66	66	66	33	33	33	70	140	140	140	1092
39	Хичээлийн жилийн нийт цаг	752	768	792	792	858	1050	1225	1365	1365	1330	1330	1330	12957
40	Долоо хоногийн цаг	23.5	24	24	24	26	30	35	39	39	38	38	38	38
41	Өдрийн цаг	4.7	4.8	4.8	4.8	5.1	6.0	7	7.8	7.8	7.6	7.6	7.6	7.6

Долоо хоногт 1 цаг

Долоо хоногт 2 удаа, бүлгийн сургалт 40 минутаар 1 удаа

Тайлбар:

- Хичээлийн жилд I-II анги 32, III-V анги 33, VI-XII анги 35 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.
- Сургалтын төлөвлөгөөг заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлог болон багшийн нөөц боломжид тулгуурлан тухайн анги, боловсролын түвшинд уян хатан байхаар хэрэгжүүлнэ.
- Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг суралцагчдын авьяас, сонирхол, сургуулийн материаллаг бааз, боловсон хүчний нөөцийг харгалзан зохион байгуулна.
- Засан сайжруулах хичээлийг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулна. Засан сайжруулах хичээлд хамрагдах суралцагчдыг нарийн мэргэжлийн эмчийн болон сургуулийн эмчлэл сурган хүмүүжүүлэх комиссын шийдвэрээр тогтооно.
- Сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагийг хичээлийн цагт тооцно. Сургалт дэмжих үйл ажиллагааг аль ч хичээл, судлагдахууны багш удирдаж болно.



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны ... дугаар сарын ... өдрийн ... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө

Д/д	Хичээл, судлагдахуун	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	БҮГД
1	Бэлтгэл хөтөлбөр	100									100
2	Монгол хэл	162	192	198	198	198	105	195	195	105	1368
3	Уран зохиол						70	70	70	70	280
4	Математик	108	128	132	132	132	105	105	105	105	1052
5	Мэдээллийн технологи						70	70	70	70	280
6	Нийгэм ажуйн баримжаа	81	96	99	99	99	70	70	70	70	754
7	Газарзүй /байгаль шинжлэл/						70	70	70	70	280
8	Түүх, нийгмийн ухаан						70	70	70	70	280
9	Дүрслэх урлаг, технологи						70	70	70	70	280
10	Технологи /мэргэжлийн чиг баримжаа/	54	64	66	66	66					316
11	Хөгжим	27	32	33	33	33	140	175	210	280	805
12	Айзамт хөдөлгөөнт дасгал	27	32	33	33	33	35	35	35	35	298
13	Биеийн тамир	54	64	66	66	66	70	70	70	70	596
14	Эрүүл мэнд						33	33	35	35	206
15	Англи хэл						70	70	70	70	280
<b>Тогтвортой агуулгын нийт цаг</b>		<b>613</b>	<b>608</b>	<b>627</b>	<b>660</b>	<b>660</b>	<b>945</b>	<b>980</b>	<b>1015</b>	<b>1085</b>	<b>7193</b>
16	Хэл засал	Ганцаарчилсан сургалт 20 минут, бүлгийн сургалт 40 минут									
17	Эмчилгээний биеийн тамир	Ганцаарчилсан сургалт 20 минут									
18	Ахуй засал	Ганцаарчилсан сургалт 20 минут									
<b>Сургууль зохицуулах агуулгын нийт цаг</b>		<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
20	Сургалтыг дэмжих үйл ажиллагаа	108	128	132	99	99	35	35	35	35	140
21	Сургалтыг дэмжих үйл ажиллагааны нийт цаг	<b>108</b>	<b>128</b>	<b>132</b>	<b>99</b>	<b>99</b>	<b>70</b>	<b>70</b>	<b>70</b>	<b>70</b>	<b>846</b>
<b>Хичээлийн жилийн нийт цаг</b>		<b>721</b>	<b>736</b>	<b>759</b>	<b>759</b>	<b>759</b>	<b>1015</b>	<b>1050</b>	<b>1085</b>	<b>1155</b>	<b>8039</b>
Долоо хоногийн цаг		22.5	23	23	23	23	29	30	31	33	
Өдрийн цаг		4.5	4.6	4.6	4.6	4.6	5.8	6	6.2	6.6	

- Тайлбар:
- Хичээлийн жилд I-II анги 32, III-V анги 33, VI-IX анги 35 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.
  - Сургалтын төлөвлөгөөг заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлог болон багшийн нөөц зэрэг хүчин зүйлст үндэслэн тухайн анги, боловсролын түвшинд уян хатан байхаар хэрэгжүүлнэ.
  - Хэл засал хичээлийг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр 7 хоногт I-II ангид 2 цаг, III-V ангид 1.5 цаг, VI-IX ангид 1 цаг орно. Эмчилгээний биеийн тамирын хичээлийг ганцаарчилсан хэлбэрээр 7 хоногт I-II ангид 2 цаг, III-V ангид 1.5 цаг, VI-IX ангид 1 цаг орно. Ахуй засал хичээлийг 7 хоногт I-IX ангид 1 цаг орно.
  - Хэл засал, эмчилгээний биеийн тамир, ахуй заслын хичээлд хамрагдах шаардлагатай суралцагчийг сургуулийн эмнэлэг-сурган хүмүүжүүлэх комиссын шийдвэрээр тогтооно.
  - Технологийн хичээлийн төрлийг суралцагчдын сонирхол, сургуулийн бодит боломжид тулгуурлан сонгож, бүлгээр зохион байгуулна.
  - Айзамт хөдөлгөөнт дасгал хичээлийг I-IX ангид хөгжмийн мэргэжлийн багш орно.



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/549

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлалыг хавсралтаар баталсугай.
2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох үүрэг бүхий Үндэсний зөвлөл байгуулж ажиллуулахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баярсайхан/, тус тушаалаар батлагдсан аргачлалыг сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоход ашиглахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Д.Сүрэнчимэг/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД  Ц.ЦОГЗОЛМАА



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 08 дугаар сарын 30  
өдрийн А/549 тушаалын хавсралт

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГАЧЛАЛ

### УДИРТГАЛ

#### 1. Үндэслэл

21 дүгээр зуунд дэлхийн улс орнуудын боловсролын тогтолцоо нь даяарчлагдсан зах зээл, мэдлэгт суурилсан эдийн засгийн нөхцөл бүхий шинэ нийгэмд зохицон амьдрах хувь хүний эрэлтийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэхийн тулд өөрчлөгдөн шинэчлэгдэж байна.

Боловсролын тогтолцооны нэг үндсэн бүрдэл бол сургалтын хөтөлбөр юм. Аливаа улсын ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр нь өөрийн соёл, үнэт зүйл, хөгжлийн чиг хандлага болон боловсролын шинэчлэлийг даган хувьсан өөрчлөгдөж иржээ.

Монгол улсын боловсролын салбарт бодлогын болон бүтэц, зохион байгуулалтын томоохон өөрчлөлт 1990-ээд оноос эрчимжиж, 2006 онд 10 жилийн тогтолцооноос 11 жилийн тогтолцоонд, 2008 онд 11 жилийн тогтолцооноос 12 жилийн тогтолцоонд шилжсэн. Энэхүү боловсролын тогтолцооны шинэчлэлийг даган сургалтын хөтөлбөр хэд хэдэн удаа өөрчлөгдсөн.

Монгол улсад хэрэгжсэн сургалтын хөтөлбөрүүдэд хийсэн SWOT шинжилгээний үр дүнгээс харахад олон улсын чиг хандлага, үндэсний үнэт зүйл, суралцагчийн суралцах нөхцөл байдал тулгуурласан давуу талтай ч, богино хугацааны өөрчлөлт нь сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо алдагдах, үр дүнг дараагийн шинэчлэл, өөрчлөлтөд тусган хэрэгжүүлэх үндэсний болон сургуулийн түвшний тогтолцоо бүрдэж амжихгүй байхад нөлөөлж байна.


Боловсролын шинэчлэлийн болон сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах үйл явц тодорхойгүй, гэнэтийн шинжтэй өөрчлөлтийг ойр ойрхон хийж байгаа менежментийн асуудлуудаас болоод үр дүнтэйгээр боловсролын чанарыг сайжруулах, сургалтын хөтөлбөрийн урт, дунд хугацааны хэрэгжилтийн үр дүнд дүгнэлт хийх боломж бүрдэхгүй байна. Мөн сурах бичиг болон үнэлгээний агуулгад сургалтын хөтөлбөрийн шинэлэг санааг хангалттай тусгаж чадахгүйгээс багшийн заах арга зүй, үнэлгээний даалгаврын тавилд дорвитой ахиц өөрчлөлт гарахгүй байна.

Иймд сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах цогц үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлдэг улс орны туршлагад үндэслэн өөрийн улсын онцлогт тохирсон “Хөтөлбөрийн менежментийн цикл”-ийг хөтөлбөр судлалын практикт нэвтрүүлж, нотолгоонд суурилсан тогтвортой бодлого, төлөвлөлтийг бий болгох нь боловсролын чанар, суралцагчийн сурлагын амжилтад эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

#### 2. Зорилго

Төрөөс дэвшүүлж буй боловсролын зорилгыг хангахын тулд үндэсний, бүс нутгийн болон суралцагчийн бодит нөхцөл байдлыг харгалзан хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах цикл үйл ажиллагааг төлөвлөгөөтэй, зохион байгуулалттай, тасралтгүй дэмжин ажиллах

Зураг 1.1. ХМЦ-ийн үзэл баримтлалын зураглал





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/608

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 276 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Г.Ням-Очир/, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Г.Дуламжав/-т, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

0902276



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 09 дугаар сарын 28-ны  
өдрийн 1608 дугаар тушаалын хавсралт



## ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН ОРЧИНД ГАР УТАС, ЦАХИМ ХЭРЭГСЭЛ БОЛОН СҮЛЖЭЭГ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цэцэрлэг, сургуулийн орчинд хичээл, сургалтын үйл ажиллагааны үеэр сурагч, хүүхдүүдэд ухаалаг гар утас, түүнтэй адилтгах тоног төхөөрөмж ашиглахыг хязгаарлан, гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаандаа мөрдөнө.

1.3. Хичээл, сургалтын үйл ажиллагааны үеэр гэдгийг тухайн өдөр үргэлжлэх сургалтын нийт хугацаагаар ойлгоно.

### Хоёр. Баримтлах зарчим

2.1. Хүүхдийн эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхийг дээдлэх;

2.2. Хичээл, сургалтын үеэр гар утсыг хязгаарлах үйл ажиллагаа нь ялгаварлан гадуурхалтаас ангид байж, тэгш байдлыг хангах;

2.4. Суралцагчдын хөгжил, төлөвшилд эерэгээр нөлөөлж, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

2.5. Сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөлөөр хангах;

### Гурав. Зохион байгуулах үйл ажиллагаа

3.1. Цэцэрлэг, сургуулийн удирдлага нийт багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад энэхүү журмыг танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.2. Цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчид нь хичээлд суух, хичээл заах үедээ гар утас ашиглахыг хориглоно.

3.3. Багш, ажилтан, суралцагч гар утас болон түүнтэй адилтгах цахим хэрэгслээ унтраасны дараа хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлж хэвшүүлэх ажлыг сургуулийн захиргаа зохион байгуулна.

3.4. Хичээл, сургалтын үед суралцагчийн ар гэрээс суралцагчтай яаралтай ярих шаардлага гарсан тохиолдолд дуудлагыг хүлээн авах утсыг жижүүрийн дэргэд байрлуулна.



3.5. Эцэг эх, асран хамгаалагч нь хичээл, сургалтын үеэр хүүхэдтэйгээ яаралтай холбогдох шаардлага гарвал тухайн сургуулийн дуудлага хүлээн авах утсанд хандана.

3.6. Сургуулийн дуудлага хүлээн авах утсанд суралцагчийн нэрээр яаралтай дуудлага ирсэн үед жижүүр болон жижүүр багш суралцагчдад мэдээллийг шуурхай хүргэх бөгөөд суралцагч ангиас гарч хувийн утсаараа ар гэртэйгээ холбогдоно.

3.7. Багш нь хичээл, сургалтын үеэр суралцагчдад гар утас хэрэглүүлэхгүй байхаар хичээлийн бэлтгэл, төлөвлөлт, зохион байгуулалтыг хийнэ.

3.8. Багш нар суралцагчдад нийгмийн сүлжээг (фэйсбүүк, твиттер гэх мэт) ашиглан даалгавар, бие даалт өгөхийг хориглоно.

3.9. Сургалтын танхим, лабораторид цахим хэрэглэгдэхүүн ашиглах талаар сургуулийн дотоод журамд тусгана.

3.10. Спорт болон урлаг заал, номын сан зэрэг нийтийн эзэмшлийн хэсэгт сүлжээ унагаагч төхөөрөмж ашиглана.

3.11. Бага насны хүүхдэд танин мэдэхүйн нэвтрүүлэг, хүүхэлдэйн кино, бичлэгийг үзүүлэх тохиолдолд зурагт, проекторыг ашиглах хугацаа 5 минутаас хэтрэхгүй байна.

3.12. Цэцэрлэгийн сургалтад техник хэрэгсэл ашиглах тохиолдолд эхний эгнээний хүүхэд дэлгэцнээс 1,8-2,0 метр, арын эгнээний хүүхэд 4-6 метр, хоёр хажуу талын хүүхдийн харах өнцөг 20-25 градусаас хэтрэхгүй байна.

3.13. Цэцэрлэгийн бүлгийн өрөөнд лазер принтер болон хувилагч машин зэрэг хэт ягаан туяа ялгаруулдаг тоног төхөөрөмж байрлуулахыг хориглоно.

### **Дөрөв. Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа**

*4.1. Сургуулийн удирдлага нь суралцагчдад гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх талаар сургууль дээр дараах үйл ажиллагааг зохион байгуулна.*

- 4.1.1. Суралцагчдыг интернэт орчноос хэрэгцээт мэдээллийг зөв сонгон авч зүй зохистой ашиглах чадварт сургах;
- 4.1.2. Суралцагчдыг ухаалаг утас, цахим орчны зохистой хэрэглээнд сургах, цахим орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажлыг ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын бодлоготой уялдуулан эцэг эх, асран хамгаалагчтай хамтран зохион байгуулах;
- 4.1.3. Цахим хэрэгсэл, гар утас, интернэт сүлжээний зохистой хэрэглээг бий болгоход шаардагдах чадварыг өсвөр үеийнхэн, тэдний гэр бүл, багш, ажилтан, ажиллагсад эзэмшүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, цахим гадуурхал, дарамт, халдлагын талаар ойлголт, тэдгээрээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хамгаалах хариу арга

хэмжээ авах талаар сургалтыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

- 4.1.4. Цахим орчинд соёлтой оролцох, бусдад хүндэтгэлтэй хандахад чиглэсэн төрөл бүрийн уралдаан, аяныг хүүхдийн оролцоонд тулгуурлан зохион байгуулж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 4.1.5. Суралцагчийн сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, цахим хэрэглээнээс үүдэлтэй эсэхийг тандан судалж, эрсдэлийн үнэлгээг хийх;
- 4.1.6. Суралцагч цахим дарамт, дээрэлхэлд өртсөн тохиолдолд сургуулийн захирал, нийгмийн ажилтан нь эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан багштай хамтран хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг шуурхай үзүүлэх;

### Тав. Бусад

5.1. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдэдээ өөрийнх нь нэр дээр бүртгэлтэй дугаарыг ашиглуулна.

5.2. Эцэг эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд хүүхдийн ухаалаг утас, цахим хэрэглээнд зохих хязгаарлалт, хяналтыг зүй зохистой хэмжээнд тавьж, зөв үлгэр дууриал үзүүлнэ.

5.3. Эцэг эх, асран хамгаалагч нь цэцэрлэг, сургуулийн захиргаанаас зохион байгуулж буй сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцож, хамтарч ажиллана.

5.4. Эцэг эх, асран хамгаалагч нь бага насны хүүхдэд гэрийн нөхцөлд ухаалаг гар утас, цахим хэрэгслийг тоглоом, саатуулах хэрэгсэл болгон ашиглахыг хориглоно.

5.5. Энэхүү журмыг мөрдөж ажиллах, хариуцлага хүлээлгэх талаар байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжилтэд нь цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал хяналт тавина.

---00000---



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2018.10.12 № 1-1/4996  
танай 2018.10.03 ны № 10/11582-Т

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД  
Ц.ЦОГЗОЛМАА ТАНАА**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам батлах тухай” А/612 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4005 дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдье.



Ц.НЯМДОРЖ

08.3258  
Doc.yam a5.2018



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2018 оны 10 сарын 15-ны  
өдрийн 4005 дугаарт бүтэн

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/612

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуульд заасан чиг үүрэг, хамтарсан баг болон дээрх журмын хэрэгжилт, холбогдох зардлыг төсөвт тусгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Насан туршийн боловсролын үндэсний төв, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газар, Насан туршийн боловсролын төвийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

0302235



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 10 дугаар сарын 01-ны  
едрийн 2/612 тоот тушаалын хавсралт



## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ СУУРЬ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАСРАЛТГҮЙ ХАМРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, бие махбодь, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон болон хохирч болзошгүй эрсдэлд байгаа насанд хүрээгүй хүүхдийг түр хамгаалах байранд хамгаалагдах үед суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Бага, дунд боловсролын сургалтын байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд (цаашид “хүүхэд” гэх)-ийг сэтгэл зүйн зөвлөгөө авах, хэвийн байдалд орох хүртэлх хугацаанд журмыг мөрдөнө.

### Хоёр. Ерөнхий зохион байгуулалт

2.1. “Хамтарсан баг” нь нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хүчирхийлэлд өртсөн болон болзошгүй эрсдэлд байгаа насанд хүрээгүй хүүхдийг урьдчилан сэргийлж, түр хамгаалах байранд шилжүүлэн суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах, тэдний суралцах хэвийн нөхцөлийг хангах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Боловсрол, соёл, урлагийн газар, хэлтэс, Насан туршийн боловсролын төв, ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн дараах хэлбэрээр хамтран зохион байгуулна:

2.1.1. Тухайн хүүхдийн боловсрол эзэмшсэн байдалд үнэлгээ хийх;

2.1.2. Хүүхдийн боловсролын баримт бичгийг үндэслэн суралцах түвшин, анги, хэлбэрийг тодорхойлох;

2.1.3. Хүүхдийн боловсролын баримт бичгийг хянах, зөрчлийг арилгах, нөхөн олгох;

2.1.4. Сургалт зохион байгуулахад шаардагдах ном сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн, дүрэмт хувцасаар хангах зэрэг нэмэгдэл зардлыг тухайн боловсролын байгууллагын төсөвт нэмж олгох асуудлыг “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн 19.1.5 дахь заалтыг үндэслэн уламжлан шийдвэрлүүлэх.

## Гурав. Сургалтын зохион байгуулалт

3.1. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхэд хүчирхийлэлд өртсөн нь тогтоогдсон бол "Хамтарсан баг"-ийн дүгнэлтийг үндэслэн эрсдэлт байдал тогтворжих хүртэлх хугацаанд аюулгүй байдлыг бүрэн хангаж, үргэлжлүүлэн сургах ажлыг "сургууль" зохион байгуулна.

3.2. "Хамтарсан баг" хүүхдийг сурч байгаа сургуульдаа үргэлжлүүлэн суралцахад эрсдэлтэй гэж үнэлсэн бол түр хамгаалах байранд хамгийн ойр байршилтай сургуульд түр шилжүүлэн сургана.

3.3. Түр хамгаалах байрны орчинд сургууль байхгүй бол хүүхдийг сургалт зохион байгуулах эрх бүхий төрийн болон төрийн бус сургалтын байгууллагад түр шилжүүлэн сургаж болно.

3.4. Сургуульд огт суугаагүй буюу сургууль завсардсан хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол "Бага, суурь, бүрэн бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах журам"-ын дагуу боловсрол нөхөн олгох сургалтад хамруулна.

3.5. Хүүхдийг сургалтын байгууллагын аль ч хэлбэрээр сургах боломжгүй бол Насан туршийн боловсролын төвийг түшиглэн сургалт зохион байгуулна.

3.6. Насан туршийн боловсролын төвийг түшиглэн сургалтад хамрагдах хүүхдийн суралцах хэлбэр (бие даах, зайны, явуулын)-ийг асран хамгаалагчтай нь зөвшилцсөний үндсэн дээр нөхцөл боломжид нь тохирсон сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, түр суралцах гэрээ байгуулан ажиллаж болно.

3.7. Хүүхдийг ерөнхий боловсролын сургууль болон насан туршийн боловсролын төвөөр суурь боловсролын үйлчилгээнд түр хамруулах, сурах орчны аюулгүй байдлыг хангах, хичээлээс гадуурх үйл ажиллагааг дараах хэлбэрээр зохион байгуулна:

3.7.1. Сургалтын үед эрсдэлгүй хүргэх, авах ажлыг зохион байгуулна.

3.7.2. Хүчирхийллийн улмаас үүсэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн сэтгэл зүйчтэй хамтран зохион байгуулна.

3.7.3. Сургалтын орчинд учирч болзошгүй эрсдэлийг тооцоолж, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.7.4. Дугуйлан, секц, олон нийтийн ажилд оролцуулах, анги хамт олонд нь нийгэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

3.7.5. Сургуулийн нийгмийн ажилтан болон анги удирдсан багш нь гэр бүлийн орчин дахь эрсдэлт байдлыг хэвийн болгоход чиглэсэн ажлыг эцэг эх, баг, хорооны нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулна.

3.8. Сургалтын байгууллага нь "Хамтарсан баг"-ийн дүгнэлтэд үндэслэн эрсдэлийн байдал тогтворжсон хүүхдийг гэр бүлийн орчинд шилжүүлэн сургах ажлыг

аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтэст уламжлан харьяаллын дагуу ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвд шилжүүлнэ.

#### **Дөрөв. Санхүүжилт**

4.1. "Хамтарсан баг" ажиллах, түүнийг санхүүжүүлэх, хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд хамруулахад шаардагдах зардлыг "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д заасан хамтарсан журмаар зохицуулна.

#### **Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

5.1. Сургалтын байгууллага нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд суурь боловсролыг тасралтгүй олгох сургалт зохион байгуулсан тухай тайланг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаар ахлуулсан хамтарсан багт жилд 1 удаа тайлагнаж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

5.2. Бүх шатны Засаг дарга нар хүчирхийлэлд өртсөн хүүхдэд суурь боловсролыг тасралтгүй олгох сургалтын ажлыг хэрэгжүүлсэн тайланг зохих шатны байгууллагад хүргүүлнэ.

-000-





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/747

Улаанбаатар хот

Хичээлийн жилийн бүтцэд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын "Агаарын бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай" 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын 7 дугаар заалт, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 2018/82 дугаар албан бичиг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, Эрүүл мэндийн яамны саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын 2018-2019 оны хичээлийн жилийн 2, 3, 4 дүгээр улирлын хичээллэх болон амрах хугацааг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд сургалтын хөтөлбөр бүрэн хэрэгжсэн байхаар агуулгыг нягтруулах зөвлөмж заавар боловсруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Багш нарт зориулсан сургалтыг суралцагчдын амралтын хугацаанд багтаан зохион байгуулахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Д.Сүрэнчимэг/, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

002815





Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны ..... дүгээр сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Аймаг, сум, тосгон, багийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц

Улирал	Нэгдүгээр улирал										Хоёрдугаар улирал										Гуравдугаар улирал										Дөрөвдүгээр улирал										Сургалтын 7 хоног	
	IX		X		XI		XII		I		II		III		IV		V		VI		IX		X		XI		XII		I		II		III		IV		V		VI			
7 хоног	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42
I	8 долоо хоног										7 долоо хоног										8 долоо хоног										7 долоо хоног										30	
II	A										A										A										A										A	
III	A										A										A										A										A	
IV	A										A										A										A										A	
V	A										A										A										A										A	
VI	A										A										A										A										A	
VII	A										A										A										A										A	
VIII	A										A										A										A										A	
IX	A										A										A										A										A	
X	A										A										A										A										A	
XI	A										A										A										A										A	
XII	A										A										A										A										A	
Анги	8 долоо хоног										7 долоо хоног										8 долоо хоног										10 долоо хоног										33	

Тайлбар:

- 1, 1, 3 дугаар улирлын амралт Даваа гарагт эхэлж, Баасан гарагт дуусна.
- Сурацагчид 3 дугаар улирлын дундуур Цагаан сарын үеэр 1 долоо хоног амарч, 8 долоо хоног хичээллэнэ. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүд тохиож буй 7 хоногт амарна. Шинийн 1, 2-ны өдөр 7 хоногийн Бямба, Ням гарагт тохивол дараа 7 хоногт нь амарна.
- Газар зүйн бүслүүр, цаг уурын онцлог, мал төллөх хугацаанаас хамааран 32 дугаар 7 хоногийн амралтыг 29 дүгээр 7 хоногт шилжүүлж болно.
- Хичээлийн жилийн 40, 41 дүгээр 7 хоногт 3-12 дугаар ангид Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулна.

Тэмдэглэгээ:

A - амралт



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны 11 дугаар сарын 29 өдрийн  
А/Н/Т/Г Дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц

Улирал	Нэгдүгээр улирал									Хоёрдугаар улирал									Гуравдугаар улирал									Дөрөвдүгээр улирал									Сургалтын 7 хоног					
	IX			X			XI			XII			I			II			III			IV			V			VI														
7 хоног	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42
I	8 долоо хоног									7 долоо хоног									8 долоо хоног									7 долоо хоног									30					
II	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног														
III	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									31					
IV	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног														
V	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									33					
VI	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног														
VII	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног														
VIII	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног														
IX	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног														
X	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног														
XI	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног														
XII	8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног									8 долоо хоног														

Тайлбар:

- 1, 2, 3 дугаар улирлын амралт Даваа гарагт эхэлж, Баасан гарагт дуусна.
- Хичээлийн жилийн 40, 41 дүгээр 7 хоногт 3-12 дугаар ангид Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулна.

Тэмдэглэгээ:  
А - амралт



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/762

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах нийтлэг журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2018-2019 оны хичээлийн жилд кабинет, лаборатори шинээр байгуулахад, 2019-2020 оны хичээлийн жилээс бүрэн мөрдөж ажиллахыг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын сайдын 2018 оны 11 дугаар  
сарын 04-ний өдрийн 11 дүгээр  
тушаалын хавсралт



**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД  
КАБИНЕТ, ЛАБОРАТОРИ БАЙГУУЛАХ,  
АШИГЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори /цаашид кабинет, лаборатори гэх/ байгуулах, ашиглахтай холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Суралцагчийн сурах хэрэгцээ, сонирхлыг дэмжих, мэдлэг, чадвараа шинэ нөхцөлд хэрэглэх, шинжлэн судлах арга барилд суралцах, сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц орчин бүрдүүлэх зорилгоор кабинет, лаборатори байгуулж ашиглана.

1.3. Кабинет, лаборатори байгуулах, үр дүнтэй ашиглах, шийдвэр гаргах үйл ажиллагаа нь хамтын оролцоог хангасан, ил тод, нээлттэй, ялгаварлан гадуурхалт болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

1.4. Кабинет, лабораторийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлээр дагнасан болон нэгдмэл хэлбэрээр байгуулна.

1.5. Суралцагчийн хөгжлийг дэмжих чиглэлээр урлаг, спортын кабинет, хүүхэд хөгжлийн танхим байгуулж болно.

1.6. Кабинет, лаборатори нь энэхүү журмын 3 дахь хэсэгт заасан шаардлага хангасан, анги бүлэг, багаар болон ганцаарчлан суралцах боломжтой орон зайн зөв шийдэл бүхий танхим байна.

1.7. Кабинет, лаборатори байгуулах, үнэлэх, санал дүгнэлт, шийдвэр гаргах үйл ажиллагааг сургуулийн түвшинд зохион байгуулна.

**Хоёр. Кабинет, лаборатори байгуулах  
үйл ажиллагааны зохион байгуулалт**

2.1. Кабинет, лаборатори байгуулах саналыг багш, заах аргын нэгдэл эсхүл сургуулийн захиргаа гаргаж болно.

2.2. Багш, заах аргын нэгдлийн хамт олон кабинет, лаборатори байгуулах саналаа жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор сургуулийн захиралд гаргах бөгөөд саналыг багш нарын зөвлөлийн хуралд захирал хэлэлцүүлнэ.

2.2.1. Кабинет, лаборатори байгуулах үндэслэл, шаардлага, нэршил, шаардагдах санхүүгийн тооцооны талаар санал гаргасан багш, заах аргын



нэгдлийн ахлагч, сургуулийн захиргааны зөвлөлийн төлөөлөл багш нарын зөвлөлийн хуралд тус тус танилцуулна.

2.3. Кабинет, лабораторийн тоо, нэршлийг хичээлийн байрын хүчин чадал, хүний болон санхүүгийн нөөц, боломжид үндэслэн багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж тогтооно.

2.4. Багш нарын зөвлөлийн хурлын шийдвэр болон энэ журмын 3 дахь хэсэгт заасан шаардлагад нийцүүлэн кабинет, лаборатори байгуулах ажлыг заах аргын нэгдэл, багш нар хариуцна.

2.5. Кабинет, лаборатори нь энэхүү журмын 3 дахь хэсэгт заасан шаардлага хангаж буй эсэхэд хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт гаргах үүрэг бүхий 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг захирлын тушаалаар томилон ажиллуулна.

2.5.1. Ажлын хэсэгт сургуулийн зөвлөл, ерөнхий боловсролын бусад сургууль, мэргэжил, арга зүйн холбогдох байгууллагаас төлөөлөл оролцуулж болно.

2.5.2. Ажлын хэсэг санал, үнэлгээ, дүгнэлтээ багш нарын зөвлөлийн хуралд танилцуулна.

2.6. Кабинет, лаборатори байгуулах, үйл ажиллагааг үргэлжлүүлэх болон түдгэлзүүлэх, татан буулгах эсэх талаар багш нарын зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийг захирлын тушаалаар баталгаажуулна.

2.6.1. кабинет, лаборатори байгуулах, үйл ажиллагааг үргэлжлүүлэх эсхүл түдгэлзүүлэх, татан буулгах талаар зохион байгуулсан хуралд нийт багшийн 90-ээс доошгүй хувь нь оролцож, тэдний 80-аас доошгүй хувь нь дэмжсэн шийдвэрийг хүчинтэйд тооцно.

2.7. Кабинет, лабораторид жил бүрийн 11 дүгээр сард багтаан үнэлгээ хийж, "тогтвортой үйл ажиллагаатай" гэж үнэлэгдвэл үйл ажиллагааг үргэлжлүүлэх, "хангалтгүй" үнэлэгдвэл хугацаатай даалгавар өгөх эсхүл татан буулгах асуудлыг энэ журмын 2.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

2.8. Кабинет, лаборатори хариуцан ажиллах багшийг заах аргын нэгдлийн саналыг үндэслэн багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, сургуулийн захирлын тушаалаар томилж, чөлөөлнө.

2.9. Кабинет, лаборатори шаардлага хангахгүй байгаа, баяжуулалт, шинэчлэл хийгдээгүй болон үйл ажиллагаа тогтвортой бус болох нь энэ журмын 2.7-д заасан хугацаанаас өмнө нотлогдсон эсхүл тухайн танхим хариуцсан багш албан ёсны хүсэлт гаргасан зэрэг тохиолдолд татан буулгах, хариуцсан багшийг өөрчлөх асуудлыг тухай бүр хэлэлцэж шийдвэрлэнэ.

### **Гурав. Кабинет, лабораторид тавих шаардлага**

3.1. Кабинет, лаборатори нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дүрэм, заавартай байх бөгөөд тэдгээрийг сургалтын менежер хянаж, сургуулийн захирал баталгаажуулна. Дүрэм, зааварт кабинет, лаборатори ашиглах, үйл

ажиллагаанд баримтлах дэг, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хэм хэмжээг тус тус тусгасан байна.

3.2. Кабинет, лабораторид боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, үзүүлэн таниулах материал, урвалж бодис, сурах бичиг, гарын авлага, арга зүйн болон бусад хэрэглэгдэхүүн төвлөрсөн байх бөгөөд тэдгээр нь суралцагчдад хүртээмжтэй байна.

3.3. Лаборатори нь техникийн болон эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ус түгээгүүр, цахилгаан хангамж, агааржуулагч, туршилтад зориулсан ширээ, сандал, тодорхой чиглэлээр туршилт, судалгаа, дадлага ажил хийх тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгаалал болон эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэл, бусад шаардлагатай зүйлээр тоноглогдсон орчин байна.

3.4. Кабинет, лабораторид дараах багц материал заавал байна:

- 3.4.1. холбогдох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө /анги бүрээр/;
- 3.4.2. нэгж хичээлийн буюу бүлэг сэдвийн төлөвлөлт /анги бүрээр/;
- 3.4.3. сурлагын амжилтыг үнэлэх даалгаврын сан /анги, бүлэг сэдвээр/;
- 3.4.4. цахим хичээл, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл;
- 3.4.5. сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материал /аудио, видео, хэвлэмэл ном, сурах бичиг, арга зүйн зөвлөмж, гарын авлага, толь бичиг гэх мэт/;
- 3.4.6. тухайн танхимын онцлогоос хамаарч сургалтын биет болон загвар, зурагт үзүүлэн, урвалж бодис, багаж хэрэгсэл, газрын зураг, глобус гэх мэт;
- 3.4.7. сургалтын хөтөлбөрийн дагуу хийх төсөлт болон дадлага, туршилтын ажлын сэдэв, түүнийг зохион байгуулах зааварчилгаа, шаардагдах урвалж бодис, багаж хэрэгслийн нэгдсэн жагсаалт /анги бүрээр/;
- 3.4.8. суралцагчдын бүтээл.

3.5. Энэхүү журмын 3.4-т заасан багц материалыг анги, сэдэв, агуулга бүрээр ангилан товъёог, катологижуулж хэрэглэхэд тохиромжтой болгоно.

3.6. Багц материалыг суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн тогтмол баяжуулан шинэчилж байх бөгөөд сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, урвалж бодис нь нэр хаяг, ашиглах заавартай байна.

#### **Дөрөв. Кабинет, лабораторийн ашиглалт**

4.1. Кабинет, лаборатори дахь багц материалыг багш нар хамтран ашиглах бөгөөд ашиглалт, баяжуулалтын бүртгэлийг заавал хөтөлнө.

4.2. Энэхүү журмын 3.4-т заасан багц материал байнгын ашиглалтад байгаа эсэхэд сургалтын менежер хяналт тавьж, бүртгэгд тэмдэглэгээ хийнэ.

4.3. Туршилт, дадлага ажил бүхий хичээлийг зориулалтын кабинет, лабораторид зохион байгуулахыг заах аргын нэгдлийн ахлагч, сургалтын менежер хамтран хичээлийн хуваариар зохицуулна.

4.4. Энэхүү журмын 4.3-т зааснаас бусад тохиолдолд техник хэрэгсэл, багаж, сургалтын хэрэглэгдэхүүнийг зөөвөрлөн ашиглах боломжийг кабинет, лаборатори хариуцсан багш зохицуулна.

4.4.1. Кабинет, лаборатори дахь техник хэрэгсэл, багаж, сургалтын хэрэглэгдэхүүнийг зөөвөрлөн хэрэглэх явцад үүссэн эвдрэл, гэмтлийг ашигласан багш хариуцна.

4.5. Кабинет, лаборатори хариуцсан багш нь тухайн танхимд зохион байгуулах үйл ажиллагааны хуваарийг заах аргын нэгдлийн саналд үндэслэн боловсруулж, сургалтын менежерээр баталгаажуулан ажиллана.

4.6. Кабинет, лабораторийн үйл ажиллагааны тайланг хариуцсан багш хичээлийн жилийн төгсгөлд багш нарын зөвлөлд танилцуулна.

### **Тав. Бусад**

3.1. Кабинет, лаборатори хариуцсан ажилласан багшид нэмэгдэл хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгоно.

3.2. Сургуулийн захирлын тушаалыг үндэслэн кабинет, лабораторийн нэр, хариуцсан багшийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн системд сургалтын менежер оруулна.

5.3. Кабинет, лабораторийн эд хогшил болон энэ журмын 3.4-т заасан багц материалыг үндсэн болон эргэлтийн хөрөнгийн бүртгэлд бүртгэнэ.

---000---





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/773

Улаанбаатар хот

Заавар, загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хувийн хэрэг хөтлөх заавар, загварыг хавсралтаар баталсугай.

2. 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн нэгдүгээр ангид элсэгчдэд олгох хувийн хэргийг энэхүү тушаалаар батлагдсан загварын дагуу хэвлэн, нийлүүлэх, өмнөх загвараар хэвлэгдсэн II-XII дугаар ангийн суралцагчийн хувийн хэргийг үргэлжлүүлэн хөтлөх талаар сургалтын менежер, багш нарыг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны "Журам, заавар, загвар батлах тухай" 361 дүгээр тушаалын зургаадугаар хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хувийн хэрэг"-ийн загвар, хөтлөх зааврыг хүчингүй болсонд тооцсугай.



007851





**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
http://www.mojha.gov.mn

2019.01.23 № 1-1/376  
танай 2019.01.11-ны № 1<sup>а</sup>/291-т

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД  
Ц.ЦОГЗОЛМАА ТАНАА**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам батлах тухай" А/812 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 417...8 дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдье.



Ц.НЯМДОРЖ

151600277  
Doc. year 06.2019



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2019 оны 01 сарын 24-ны  
өдрийн 417-д дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/812

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.22 дахь заалт, Бага, дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн зэрэг олгох, хасах журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг 2019 оноос мөрдөж ажиллахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, аймаг, нийслэлийн боловсрол, соёл, урлагийн газар, өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагын удирдлагуудад тус тус даалгасугай.
3. Журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Д.Сүрэнчимэг/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам" А/305 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

1303202

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 12 дугаар сарын 20  
өдрийн 812 дугаар тушаалын хавсралт

## МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХАСАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллага (цаашид "сургалтын байгууллага" гэх)-ын багш, ажилтанд мэргэжлийн зэрэг олгох, хасахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэргэжлийн зэрэг нь их, дээд сургуулийг багш мэргэжлээр төгссөн, сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш, сургалтын менежер, арга зүйч, захирал /цаашид "багш, ажилтан" гэх/-д хамаарна.

1.3. Мэргэжлийн зэрэг нь сургалтын байгууллагын багш, ажилтны албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, үр дүнд хүрсний баталгаа, мэргэжил, ур чадварын өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

1.4. Бага, дунд боловсролын тухай хуулийн 21.4-т заасан мэргэжлийн зэргийг багш, ажилтанд олгоно.

1.5. Мэргэжлийн зэрэг олгох, хасах үйл ажиллагаа нь үр дүнд суурилсан, ил тод, нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

1.6. "Мэргэжлийн зэрэг олгох, хасах" гэдэгт мэргэжлийн зэргийг шинээр олгох, бататгах, бууруулах, хасах үйл ажиллагааг ойлгоно.

1.7. "Мэргэжлийн зэрэг бататгах" гэж эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр өмнө олгосон зэргийн шалгуурыг давтан хангаж буйг баталгаажуулахыг ойлгоно.

1.8. Багш, ажилтанд мэргэжлийн зэргийг шатлал алгасуулан олгохгүй.

1.9. Энэ журмын 2.1-д заасан шалгуурыг бүрэн хангасан багш, ажилтанд Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.2-т заасныг үндэслэн хугацаанаас нь өмнө мэргэжлийн зэрэг олгож болно.

1.10. "Заах аргач багш", "Тэргүүлэх багш" мэргэжлийн зэргийг сургалтын байгууллага, "Зөвлөх багш" мэргэжлийн зэргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус олгоно.

### Хоёр. Мэргэжлийн зэрэг олгох шалгуур

2.1. Мэргэжлийн зэрэг олгоход дараах нийтлэг шалгуурыг баримтална:

2.1.1. Сурлагын амжилт;

2.1.2. Мэргэжил, арга зүйн ур чадвар;

2.1.3. Суралцагч, багш, хамт олон, эцэг, эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж;



#### 2.1.4. Өөрийгөө хөгжүүлсэн байдал.

2.2. Багш, ажилтны албан тушаалын онцлогоос хамаарч мэргэжлийн зэрэгт тавих шалгуур дор дурдсан байдлаар ялгаатай байна.

##### 2.2.1. Багшид мэргэжлийн зэрэг олгоход дараах шалгуурыг баримтална:

Шалгуур	Заах аргач багш	Тэргүүлэх багш	Зөвлөх багш
Сурлагын амжилт	<b>Ерөнхий боловсролын сургуулийн багш</b>		
	Суралцагчдын сурлагын амжилт сургуулийн дунджаас доошгүй байх	Суралцагчдын сурлагын амжилт аймаг, дүүргийн дунджаас доошгүй байх	Суралцагчдын сурлагын амжилт улсын дунджаас доошгүй байх
Мэргэжил, арга зүйн ур чадвар	<b>Ерөнхий боловсролын тусгай сургууль, Насан туршийн боловсролын байгууллагын багш</b>		
	Суралцагчдын сурлагын амжилт 5 хувиас дээш ахисан байх	Суралцагчдын сурлагын амжилт 10 хувиас дээш ахисан байх	Суралцагчдын сурлагын амжилт 20 хувиас дээш ахисан байх
Суралцагч, багш, хамт олон, эцэг, эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж	Мэргэжил, арга зүйн ур чадварын талаар наараас эерэг үнэлгээ авсан байх	Тухайн сургууль, сум, дүүргийн түвшинд: <ul style="list-style-type: none"> <li>багш нарт мэргэжил, арга зүйн сургалт 3-аас доошгүй удаа зохион байгуулсан байх</li> <li>Сургалтын чанар, үр дүнг сайжруулах бүтээлч арга зүй, технологи эзэмшсэн байх</li> <li>Шинээр төгссөн 1-2 багшийг дагалдуулан сургаж, туршлагажуулсан байх</li> </ul>	Аймаг, нийслэлийн түвшинд: <ul style="list-style-type: none"> <li>багш нарт мэргэжил, арга зүйн сургалт 3-аас доошгүй удаа зохион байгуулсан байх</li> <li>Сургалтын чанар, үр дүнг сайжруулах бүтээлч арга зүй, технологи, шинэ санаа түгээсэн байх</li> <li>Дагалдуулан сургасан 3-аас дээш багшийн ажлын амжилт ахисан байх</li> </ul>
	Суралцагч, багш, хамт олон, эцэг, эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын чанар, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлагатай холбоотой үндэслэл, нотолгоотой гомдол суралцагч, эцэг эх, асран хамгаалагчаас гараагүй байх</li> <li>Зохион байгуулсан хичээл, сургалт, бусад үйл ажиллагааны үед эрсдэлт нөхцөл байдал, осол гэмтэл, зөрчил үүсээгүй байх</li> <li>Ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй байх</li> </ul>	



Өөрийгөө хөгжүүлсэн байдал	Өөрийгөө хөгжүүлэх хувийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт
----------------------------	--

2.2.2. Сургалтын менежер/арга зүйч багшид мэргэжлийн зэрэг олгоход дараах шалгуурыг баримтална:

Шалгуур	Заах аргач багш	Тэргүүлэх багш	Зөвлөх багш
Сурлагын амжилт	Сургалтын менежер/арга зүйчийн албан тушаалд ажиллах багш заах аргач ба түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байна.	Хариуцсан хэсгийн суралцагчдын сурлагын амжилт аймаг, дүүргийн дунджаас доошгүй байх	Хариуцсан хэсгийн суралцагчдын сурлагын амжилт улсын дунджаас доошгүй байх
Мэргэжил, арга зүйн мэдлэг, ур чадвар		Ажлын байранд багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт	
		Сүүлийн 2 жилд сум, дүүргийн багш нарт 3-аас доошгүй удаа сургалт, зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулсан байх	Сүүлийн 2 жилд аймаг, нийслэлийн багш нарт 5-аас доошгүй удаа сургалт, зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулсан байх
		Дагалдуулан сургасан 1-2 сургалтын менежер/арга зүйчийн ажлын амжилт ахисан байх	Дагалдуулан сургасан 3-аас дээш сургалтын менежер/арга зүйчийн ажлын амжилт ахисан байх
		Анги дэвших, улсын шалгалт болон чанарын үнэлгээний үр дүнг аймаг, улсын дундажтай харьцуулан дүн шинжилгээ хийж, сурлагын амжилтад ахиц гаргах, багшийг хөгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган үр дүнг жил бүр тооцон ажилласан байх	
Суралцагч, багш, хамт олон, эцэг, эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж		Хариуцсан хэсгийн нийт багш нарын дотор мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь аймаг, дүүргийн дундажаас доошгүй байх	
		<ul style="list-style-type: none"> <li>Ажлын чанар, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлагатай холбоотой үндэслэл, нотолгоотой гомдол багш, эцэг, эх, асран хамгаалагчаас гараагүй байх</li> <li>Сургуулийн нийт багш нарын сэтгэл ханамжийн үнэлгээ 90-ээс дээш хувьтай байх</li> <li>Ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй байх</li> </ul>	
Өөрийгөө хөгжүүлсэн байдал		Өөрийгөө хөгжүүлэх хувийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт	

2.2.3. Сургалтын байгууллагын захирал багшид мэргэжлийн зэрэг олгоход дараах шалгуурыг баримтална:

Шалгуур	Заах аргач багш	Тэргүүлэх багш	Зөвлөх багш
Сурлагын амжилт	Сургалтын байгууллагын захирлын албан тушаалд ажиллах багш заах аргач ба түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байна.	Сургуулийн сурлагын амжилт аймаг, дүүргийн дунджаас доошгүй байх	Сургуулийн сурлагын амжилт улсын дунджаас доошгүй байх
Удирдан зохион байгуулах чадвар		Сургуулийн үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж, сургууль хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг жил бүр тооцон ажилласан байх	Сүүлийн 2 жилд 5-аас доошгүй сургуульд зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулсан байх
		Сүүлийн 2 жилд 2-оос доошгүй сургуульд зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулсан байх	Сүүлийн 2 жилд 5-аас доошгүй сургуульд зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулсан байх
		Дагалдуулан сургасан 1-2 захирлын ажлын амжилт ахисан байх	Дагалдуулан сургасан 3-аас дээш захирлын ажлын амжилт ахисан байх
		Багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдэх чиглэлээр санал, санаачилга гарган ажилласан байх	
		Сургалтын байгууллагын орчинд багш, ажилтан, суралцагч эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн	
Суралцагч, багш, хамт олон, эцэг, эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж		<ul style="list-style-type: none"> <li>Ажлын чанар, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлагатай холбоотой үндэслэл, нотолгоотой гомдол багш, эцэг, эх, асран хамгаалагчаас гараагүй байх</li> <li>Сургалтын байгууллагын хамт олон, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийн сэтгэл ханамжийн үнэлгээ 90-ээс дээш хувьтай байх</li> <li>Ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй байх</li> </ul>	
Өөрийгөө хөгжүүлсэн байдал		Өөрийгөө хөгжүүлэх хувийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт	

### Гурав. Мэргэжлийн зэрэг олгох, хасах үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Мэргэжлийн зэрэг олгох санал, хүсэлтийг багш, заах аргын нэгдэл эсхүл сургалтын байгууллагын удирдлага гаргаж болно.

3.2. Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн хүсэлтийг жил бүрийн 3 дугаар сард сургалтын байгууллагын захиргаанд гаргах бөгөөд хүсэлт гаргагч дараах материалыг бүрдүүлнэ:

- 3.2.1. мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл;
- 3.2.2. мэргэжлийн зэрэгтэй тохиолдолд үнэмлэхийн хуулбар;



3.2.3. энэ журмын 2.2.1, 2.2.2, 2.2.3-т тус тус заасан шалгуур хангасныг нотлох материал.

3.3. Хүсэлт гаргасан багш нь заах аргын нэгдлийн, сургалтын менежер/арга зүйч, захирал нь багш нарын зөвлөлийн хуралд тус тус тухайн мэргэжлийн зэрэгт тавих шалгуур хангасан /нотлох баримт/ талаар танилцуулга хийнэ.

3.4. Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн багшийн бүрдүүлсэн материалыг заах аргын нэгдлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтийг багш нарын зөвлөлийн хуралд танилцуулна.

3.5. Багш, ажилтанд мэргэжлийн зэрэг олгох, хасахтай холбоотой шийдвэр гаргах багш нарын зөвлөлийн хурлыг жил бүрийн 4 дүгээр сард зохион байгуулна. Хуралд нийт багшийн 90-ээс доошгүй хувь нь оролцож, тэдний 80-аас доошгүй хувь нь дэмжсэн тохиолдолд шийдвэрийг хүчинтэйд тооцно.

3.6. Багш нарын зөвлөлийн хурлын шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын захирлын тушаалаар баталгаажуулж, багш, сургалтын менежер/арга зүйч багшид "Заах аргач багш", "Тэргүүлэх багш" мэргэжлийн зэрэг олгоно.

3.7. Мэргэжлийн зэрэг олгосон тухай захирлын тушаалыг нээлттэй мэдээлж, шийдвэрийн хуулбарыг тухайн багш, ажилтанд заавал өгнө.

3.8. Сургалтын байгууллагын захиралд мэргэжлийн зэрэг олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана. Шийдвэр гаргахад тухайн сургалтын байгууллагын багш нарын зөвлөлийн хурлын шийдвэр, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага /цаашид "аймаг, нийслэлийн боловсролын газар" гэх/-ын санал болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэнэ.

3.9. "Зөвлөх багш" мэргэжлийн зэргийн шалгуурыг хангасан гэж үзсэн багш, ажилтны нэрсийн жагсаалт, энэ журмын 2.2.1, 2.2.2, 2.2.3-т тус тус заасан шалгуурыг хангасныг нотлох материал, багш нарын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг сургалтын байгууллага жил бүрийн 5 дугаар сарын эхний хагаст аймаг, нийслэлийн боловсролын газарт хүргүүлнэ.

3.10. "Зөвлөх багш" мэргэжлийн зэргийн шалгуурыг хангасан гэж үзсэн багш, ажилтны материалыг магадлан шалгах, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг аймаг, нийслэлийн боловсролын газрын даргын тушаалаар томилон ажиллуулна.

3.10.1. Ажлын хэсэг шаардлагатай тохиолдолд тухайн мэргэжлийн зэрэгт тавих шалгуурыг нэр дэвшигч хангаж буй эсэхийг ажлын байранд нь очиж магадлан шалгаж болно.

3.10.2. Ажлын хэсэг санал, дүгнэлтээ боловсролын газрын арга зүйн зөвлөлийн хуралд танилцуулна.

3.10.3. Аймаг, нийслэлийн Боловсролын газар нь "Зөвлөх багш" мэргэжлийн зэргийн шалгуурыг хангасан гэж үзсэн багш, ажилтны материал, ажлын хэсгийн дүгнэлт, арга зүйн зөвлөлийн хурлын шийдвэрийг жил бүрийн 6 дугаар сарын эхний хагаст багтаан багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн төв байгууллагад хүргүүлнэ.

3.11. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн төв байгууллага нь “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэгт аймаг, нийслэлийн боловсролын газраас ирүүлсэн нэр дэвшигчийн материалыг магадлан шалгаж, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сард хүргүүлнэ.

3.12. Энэ журмын 3.11-д заасан байгууллагын дүгнэлтийг үндэслэн “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгох эсэх шийдвэрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

3.13. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрт үндэслэн багш, ажилтанд “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийн үнэмлэх олгоно.

3.13.1. “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийн үнэмлэхийн загвар батлах, хэвлүүлэх, олгох, маягт (Хавсралт 1)-ын дагуу мэдээллийн сан үүсгэх асуудлыг багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн төв байгууллага хариуцна.

#### **Дөрөв. Мэргэжлийн зэргийн нэмэгдэл**

4.1. Мэргэжлийн зэрэг шинээр олгосон багш, ажилтанд нэмэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгоно.

4.2. Аймаг, нийслэлийн боловсролын газар, сургалтын байгууллага нь мэргэжлийн зэргийн нэмэгдэлд шаардагдах зардлыг тооцож, жил бүрийн төсөвт тусгана.

#### **Тав. Мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацаа, мэргэжлийн зэргийг хасах**

5.1. Мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацаа 5 жил байна.

5.2. Багш, ажилтан нь сургалтын менежер/арга зүйч, захирлын албан тушаалд дэвшин ажиллах тохиолдолд тэдний мэргэжлийн зэрэг энэ журмын 5.1-д заасан хугацаанд хүчинтэй үйлчилнэ.

5.3. Багш, ажилтанд олгосон мэргэжлийн зэрэг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэгэн адил хүчинтэй байна.

5.4. Багш, ажилтан нь “Заах аргач багш” мэргэжлийн зэргийг нэг удаа бататгаж болох бөгөөд зэргээ ахиулаагүй тохиолдолд “Заах аргач багш” зэрэг нь хүчингүй болно.

5.5. “Тэргүүлэх багш” мэргэжлийн зэргийг хоёр удаа бататгасны дараа энэ журмын 5.6-д заасан зөрчил гаргаагүй тохиолдолд зэргийг дахин бататгахгүйгээр хүчинтэй байна.

5.6. Мэргэжлийн зэрэг олгосон байгууллага дараах тохиолдолд багш, ажилтны мэргэжлийн зэргийг бууруулах эсхүл хасна:

- 5.6.1. 3-аас дээш удаа ажлын үнэлгээ нь 70-аас доош хувьтай үнэлэгдсэн;
- 5.6.2. багш, ажилтны ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн;
- 5.6.3. тухайн мэргэжлийн зэргийн шалгуурыг хангахгүй болсон;
- 5.6.4. хүүхдийн эрхэд халдсан.



5.7. Хүндэтгэн үзэх шалтгаанаар мэргэжлийн зэргээ хугацаанд нь бататгаж, эсвэл ахиулж чадаагүй бол өмнөх зэргийг нэг жил хадгална. Бусад тохиолдолд мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацаа хэтэрсэн бол мэргэжлийн зэргийг хасна.

5.8. Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасны дагуу амаржсаны болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг багш, ажилтны мэргэжлийн зэргийн хүчинтэй байх хугацаанаас хасаж тооцно.

5.9. Багш, ажилтан нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын газарт албан тушаал дэвшин ажиллах хугацаанд тухайн багш, ажилтны мэргэжлийн зэрэг хэвээр хадгалагдана.

### **Зургаа. Бусад**

6.1. Мэргэжлийн зэрэг олгох, хасах үйл ажиллагаанд энэхүү журмын 1.5-д заасан зарчмыг зөрчсөн, шалгуур хангаагүй багш, ажилтанд мэргэжлийн зэрэг олгосон, шийдвэрийн баталгаажилт хууль бус гэж үзсэн тохиолдолд Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 12.3, 12.4-т заасан зөвлөлд багш, ажилтан нь гомдол гаргаж болно.

6.2. Багш, ажилтан гомдол гаргахдаа боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан "Ес зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-д заасныг баримтална.

6.3. Багш, ажилтны гомдлыг энэ журмын 6.2-т заасан журмын 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

6.4. Сургалтын байгууллага мэргэжлийн зэрэг олгосон багш, ажилтны мэдээллийг маягт (Хавсралт 1)-ын дагуу бүртгэж, боловсролын салбарын мэдээллийн системд оруулна.

6.5. Энэхүү журмын 3.2-т заасан материал, багш, ажилтанд мэргэжлийн зэрэг олгох санал дүгнэлт, шийдвэрийг сургалтын байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн төв байгууллага тус тус архивын нэгж үүсгэн архивт шилжүүлнэ.

---000---

Хавсралт 1 \*

СУРГАЛТЫН БАЙГУУЛАГЫН БАГШ, АЖИЛТАНД МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОСОН МЭДЭЭЛЭЛ

Мэргэжлийн зэргийн нэр: .....

Зэрэг олгосон багшийн тоо: .....

№	Овог нэр	Хүйс	Нас	Мэргэжил	Боловсролын зэрэг	Эрхэлж байгаа албан тушаал	Өмнө олгосон мэргэжлийн зэрэг	Шинээр олгосон мэргэжлийн зэрэг эсхүл бататгасан	Мэргэжлийн зэрэг бууруулсан эсхүл хассан	Мэргэжлийн зэрэг олгосон шийдвэрийн дугаар	Зөвлөх багш мэргэжлийн үнэмлэхийн дугаар

Мэдээллийг нэгтгэсэн: .....  
(гарын үсэг, албан тушаал, тамга, тэмдэг)

.....  
(овог, нэр)

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2018 оны 05  
сарын 21 өдөр

Дугаар А/11.6. А/304 А/197

Улаанбаатар хот

"Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг  
дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл  
ажиллагааны төлөвлөгөө" батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хоёр дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.

2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний салбар дундын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир), Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газар (С.Мөнхөөлэй), Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар (М.Баттүвшин)-т тус тус үүрэг болгосугай.

3. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлж байхыг холбогдох яамд, агентлагийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газарт танилцуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Мөнхзул)-т үүрэг болгосугай.





**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2018 оны 12 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар А/309, А/699, А/460

Улаанбаатар  
хот

**Заавар, маягт батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн 3.1.3.3 болон 3.2.2.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх зааврыг нэгдүгээр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн маягтыг хоёрдугаар, Хүүхдийн хувийн хэрэг хөтлөх маягтыг гуравдугаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийн маягтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг оношлох, үнэлэх, төрөлжсөн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг лавлагаа төвүүд болон Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төвүүд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга захирал нарт тус тус даалгасугай.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролд тэгш хамруулах, цэцэрлэг сургуульд хамрагдалтыг сайжруулахад мэргэжил арга зүй, хүний нөөц, тохируулгат орчныг бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад тус тус даалгасугай.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисст даалгасугай.

6. Зааварт холбогдох маягтуудыг боловсруулж, албажуулан нэгдсэн бүртгэл мэдээллийн санд оруулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.



7. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир), Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газар (Т.Ням-Очир), Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар (Б.Дуламжав), Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар (М.Баттүвшин)-т тус тус үүрэг болгосугай.

8. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамдын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.

9. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд (хуучин нэрээр), Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд (хуучин нэрээр), Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/05, А/14, 16 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2018 оны 12-дугаар  
сарын 04 өдөр

Дугаар А/494/..... А/761

Улаанбаатар хот

Үлгэрчилсэн загвар, жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Хүүхдийн эрхийн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийн 3.1.2.4, Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн цэцэрлэгийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг 1 дүгээр, Ерөнхий боловсролын сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг 2 дугаар, Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг 3 дугаар, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрүүл мэндийн кабинетэд байх шаардлагатай эм, багаж хэрэгслийн жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургууль, хүүхдийн цэцэрлэгт эмч, сэтгэл зүйчийг орон тоогоор ажиллуулж, эрүүл мэндийн кабинетыг байгуулан тохижуулж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн эрүүл мэндийн кабинетэд байх эм, багаж хэрэгслийн хангамжийг сайжруулж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Санхүү, хөрөнгө оруулалт газар/Х.Галсанхүү/-т, Эрүүл мэндийн яамны Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газар /Э.Содномжамц/-т тус тус даалгасугай.

4. Сургууль, хүүхдийн цэцэрлэгийн эмчийн мэдлэг, чадвар, мэргэшлийг дээшлүүлэх, холбогдох сургалтын материал, гарын авлагаар хангах ажил зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Эрүүл мэндийн яамны харьяа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.


5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамдын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Д.САРАНГЭРЭЛ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД

Ц.ЦОГЗОЛМАА



**ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭМЧИЙН АЖЛЫН  
БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

**А. АЛБАН ТУШААЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

1. Байгууллагын нэр: Хүүхдийн цэцэрлэг	2. Нэгжийн нэр: .....	
3. Албан тушаалын нэр: Цэцэрлэгийн эмч	3.1 Албан тушаалын ангилал: Төрийн үйлчилгээний албан хаагч	3.2 Албан тушаалын зэрэглэл: ТҮ-5
4. Албан тушаалыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: Цэцэрлэгийн эрхлэгч	4.1 Албан тушаалын ангилал: Төрийн үйлчилгээ	4.2 Албан тушаалын зэрэглэл: ТҮБД-6
5. Албан тушаалын шууд харъяалан удирдуулах албан тушаал: .....	5.1 Албан тушаалын нэр: Багш, туслах багш, тогооч, гал тогооны туслах ажилтан, үйлчлэгч	5.2 Албан тушаал, эрхлэгчдийн тоо .....

**Б. АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ**

<b>Албан тушаалын зорилго</b>	Хүүхдийн эрүүл мэндийн талаар батлагдсан бодлого, шийдвэрийг байгууллагын түвшинд хэрэгжүүлэх, цэцэрлэгийн хүүхэд, багш, ажилтнуудад эмнэлгийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлж, сургалт, сурталчилгаа зохион байгуулах.	
<b>2. Албан тушаалын үндсэн зорилт</b>	<b>2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</b>	
1. Эрүүл мэндийн талаар батлагдсан бодлого, холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг тухайн цэцэрлэгийн түвшинд хариуцаж, боловсролын салбарын эрүүл, аюулгүй байдлын талаарх дүрэм, журам, орчны стандартын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх.	1. Эрүүл мэндийн талаар батлагдсан бодлого, холбогдох шийдвэр, сургуулийн өмнөх боловсролын салбарын эрүүл, аюулгүй байдлын талаарх дүрэм, журам, стандартын хэрэгжилт тогтворжсон байна. 2. Байгууллагын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа, эрүүл аж төрөх, ажиллахад чиглэсэн зөв хэм хэмжээ бүрэлдсэн байна.	



<p>2. Хүүхэд, багш, ажиллагчдад эмнэлгийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж, хүүхдийг өвчлөл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэн хүүхдийн өвчлөлийг бууруулах, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</p>	<p>1. Хүүхдийн эрүүл мэнд, тэдгээрт нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх орчин бүрдсэн байна.</p> <p>2. Цэцэрлэгийн сургалтын орчны стандарт, холбогдох эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм, журам хэрэгжсэн байна.</p> <p>3. Хүүхдийн эрүүл мэндэд ээлтэй сургалт, хөгжлийн орчин бүрдэж, хүүхэд хамгаалал, хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдал, тэдгээрт тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.</p>
<p>3. Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаа, хөгжлийн орчныг хүүхдэд ээлтэй болгох, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчдад эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх ажлыг төр, иргэний нийгэм, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.</p>	<p>1. Хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол мэдлэг сайжирсан байна.</p> <p>2. Цэцэрлэгийн хамт олон, эцэг, эх, асран хамгаалагчдын эрүүл мэндийн боловсролын түвшин дээшилсэн байна.</p> <p>3. Эмчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг байнга сахин биелүүлнэ.</p>
<p><b>3. Албан тушаалын үндсэн үйл ажиллагаа</b> <span style="float: right;"><b>3.1.</b></span></p>	
<p><u>Албан тушаалын 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд:</u></p>	
<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын байрны чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой бодлого, хууль, тогтоомж, хөтөлбөр, тушаал, шийдвэрийг хүүхэд, багш, ажилтнуудад сурталчлан таниулах, хэрэгжүүлэх, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаатай уялдуулах;</li> <li>- Цэцэрлэгийн хамт олны дунд эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон болох хөдөлгөөн өрнүүлж, мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах;</li> <li>- Эрүүл мэндийн сайн дурын үйл ажиллагаанд багш, ажилтнуудыг татан оролцуулах, хамтран ажиллах;</li> <li>- Байгууллагын дотоод хяналт шалгалтын болон хүүхэд хамгааллын багийн бүрэлдэхүүнд багтан ажиллах;</li> <li>- Холбогдох төрийн, төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах.</li> </ul>	<p><b>20 хувь</b></p>
<p><u>Албан тушаалын 2 дугаар үндсэн зорилтын хүрээнд:</u></p>	
<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн эрүүл мэндийг үзлэгийг жил бүр хийж, картыг бүрэн хөтөлж тэмдэглэх, тэдний амны хөндийн эрүүл мэнд, жин</li> </ul>	<p><b>35 хувь</b></p>



<p>өндрийн хэмжилт, нүдний хараа шалгах үзлэгийг товллолын дагуу хийж, суралцагч, ангийн багш, эцэг эх, асран хамгаалагчдад тухай бүр танилцуулан зөвлөгөө өгөх;</p> <ul style="list-style-type: none"><li>- Хүүхдийн ариун цэвэр, эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, үнэлгээ хийх, эмчлэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийж, эрүүлжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх ажлыг холбогдох эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага, эмч нартай хамтран зохион байгуулах;</li><li>- Багш, ажиллагчид, суралцагчид, эцэг эхийн дунд халдварт болон халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах, бие бялдраа чийрэгжүүлэх, эрүүл аж төрөх ёсны талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;</li><li>- Сурагчдын дунд сэтгэцийн эрүүл мэндийн байдал, хорт зуршлын хэрэглээний талаарх тандалт судалгаа хийж, үнэлгээ өгч, сургалт сурталчилгаа хийх;</li><li>- Дархлаажуулалтыг холбогдох эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах, хүүхдийг цэцэрлэгт элсэн орох, шилжин ирэх, цэцэрлэг, сургууль төгсөх үед түүний дархлаажуулалтад хамрагдсан бичиг баримтын бүрэн байдлыг шалгаж, картад хавсаргах;</li><li>- Халдварт өвчин гарсан үед авах хариу арга хэмжээний талаар цэцэрлэгийн захиргаа, бүлэг удирдсан багш нарт зөвлөх, мөн халдварт болон эрсдэлт өвчин гарсан тохиолдолд ариутгал, халдваргүйтгэлийг холбогдох эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;</li><li>- Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдийг нийгмийн ажилтантай хамтран илрүүлж, нууцыг хадгалах, харьяалах цагдаагийн байгууллагад мэдээлэх, хариу арга хэмжээ авах;</li><li>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, суралцагчийн нас, бие бялдар, сэтгэлзүйн онцлогт тохирсон хөдөлгөөн болон сэргээн заслын эмчилгээ, тусламжийг холбогдох эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага, эмч, мэргэжилтэн нартай хамтран зохион байгуулах;</li><li>- Цэцэрлэгийн хамт олны эрүүл мэндийн түвшинг холбогдох эрүүл мэндийн байгууллага, эмч нартай хамтран жил бүр тогтоож, ажиллах;</li><li>- Ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлэн эрүүл мэндийн кабинетийг хүүхэд, ажилчлагчдад ээлтэй байдлаар байгуулах, ашиглах, тогтмол баяжуулан, тохижуулах арга хэмжээг цэцэрлэг, сургуулийн удирдлага, хамт олонтой хамтран зохион байгуулах;</li><li>- Хүүхдүүдэд сургалт зохион байгуулж, сайн санааны туслагч эмч, улаан загалмайн идэвхтэн зэрэг хөдөлгөөн өрнүүлж, хүүхдүүдийг сургагчаар бэлтгэн ажиллах;</li><li>- Суралцагчид, багш ажилчдад эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх.</li></ul>	<p>35 хувь</p>
--	----------------

<p><u>Албан тушаалын 3 дугаар үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны орц, норм, норматив, илчлэг, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хадгалалт, хамгаалалт, нэр төрөл, боловсруулалт, дээж авалт, ариун цэвэр халдваргүйжилтэд хяналт тавих;</li> <li>- Цэцэрлэгийн гал тогооны газрын ариун цэвэр, өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журмын хэрэгжилт, хоолны цэс, орц, норм, илчлэг, түгээлт, амт чанарт хяналт, тавих;</li> <li>- Цэцэрлэгийн багш, туслах багш, цэцэрлэгийн тогооч, гал тогооны бусад ажилтны эрүүл мэндийн байдалд байнгын хяналт тавьж, түвшинг тогтоон энэ асуудлаар орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, эмч нартай хамтран ажиллах, эрүүлжүүлэх арга хэмжээ авах;</li> <li>- Багш, ажиллагчид, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдын дунд халдварт болон эрсдэлт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах, бие бялдраа чийрэгжүүлэх, эрүүл аж төрөх ёс, эрүүл мэндийн анхан шатны тусламж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх;</li> <li>- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулахад эрүүл мэндийн багш нарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай үед хичээл заах;</li> <li>- Багш, бусад ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, бие бялдыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхны тусламж, хөдөлгөөн, цэвэр агаар, эрүүл аюулгүй хоол, хүнс зэрэг сэдвээр сургалт сурталчилгаа хийж, эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах;</li> <li>- Цэцэрлэгийн анги танхимын ариун цэвэр, эрүүл ахуйн байдалд хяналт тавьж, холбогдох асуудлыг судлан цэцэрлэгийн захиргаанд санал тавьж шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газарт мэдэгдэж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг цэцэрлэгийн захиргаатай хамтран зохион байгуулах;</li> <li>- Анги, бүлгүүдийн цэвэрлэгээ, ариутгалын бодисын ашиглалт, цагаан хэрэглэл, гар нүүрийн алчуурын угаалт, ариутгалд хяналт тавьж, зөвлөгөө өгөх;</li> </ul> <p><u>Албан тушаалын зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цэцэрлэг, орон нутгийн түвшинд судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэх;</li> <li>- Сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх;</li> <li>- Цэцэрлэгийн эмчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдах, бусад цэцэрлэгийн эмч нартай туршлага солилцох;</li> <li>- Эмчийн ёс суртахууны хэм хэмжээг тогтмол сахих.</li> </ul>	<p>10 хувь</p>
--	----------------



## В. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

(Шинэчлэн боловсруулсан журмаар зохицуулна)

	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
1.1.Ерөнхий шаардлага:	Боловсрол	Анагаах ухааны боловсрол олгох их, дээд, дунд сургуулийг дипломын болон бакалавр зэрэгтэй төгссөн байх	Дээд боловсролын диплом, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
	Мэргэжил	Хүний их эмч, бага эмч, сувилагчийн мэргэжлийн дипломтой байх	Хүний эмч, сувилагч, эрүүл ахуйч
	Мэргэшил	Төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдсан буюу мэргэшлийн үнэмлэхтэй байх	Хүүхдийн эмчийн төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдсан буюу мэргэжлийн үнэмлэхтэй байх
	Туршлага	Эмчлэх болон сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх	2 ба 5 жилийн хугацаатай эмчлэх үйл ажиллагаа эрхэлсэн байх
	Ур чадвар	Хувь хүн, байгууллагын эрүүл ахуй, эрүүл мэндийг тулгамдсан асуудлыг мэргэжлийн хүрээнд зөв томъёолох, шийдвэр гаргах; Хамт олонд нөлөөлөх; Багаар ажиллах; Хариуцлага хүлээх; Ёс суртахууны хэм хэмжээг алдалгүй сахиж, ажлын ур чадвар, гүйцэтгэлээр бусдыг манлайлах; Ачаалал даах.	Компьютерийн зохих програмуудыг хэрэглэх;  Мэдээлэл боловсруулах;  Судалгаа хийж, дүгнэлт гаргах, тайлан боловсруулах;  Харилцааны ур чадвар эзэмшсэн байх.
1.2.Тусгай шаардлага:		Хүүхэд, багш, эцэг, эх асран хамгаалагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чадвартай байх	Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх; Холбогдох хууль тогтоомж, дүрэм зааврыг сайтар судалж, хэрэгжүүлэх; Гамшгийн үед дайчлагдах, бэлэн байдлыг хангаж ажиллах.

### Г. АЛБАН ТУШААЛ ЭМЧИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА, АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ


1. Албан тушаалын харилцах субъект		
1.1. Байгууллагын дотор талд байгаа (Шууд харилцах субъект)	1.2. Байгууллагын гадна талд байгаа (Шууд бус харилцах субъект)	
<ul style="list-style-type: none"> <li>• Бага насны хүүхэд</li> <li>• Цэцэрлэгийн эрхлэгч, багш нар</li> <li>• Бусад ажилтан</li> <li>• Цэцэрлэг, сургуулийн зөвлөлийн дарга, гишүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бусад цэцэрлэгийн багш, ажилтан</li> <li>• Эцэг эх, асран хамгаалагч</li> <li>• Орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагын ажилтан</li> <li>• Боловсрол, соёл, урлагийн газрын ажилтнууд</li> <li>• Эрүүл мэндийн газрын ажилтнууд</li> <li>• Аймаг, дүүргийн эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төв</li> </ul>	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааг биелүүлээгүй, харицлагагүй хандсан, үүсгэн байгуулагч, Боловсрол, соёл, урлагийн газар, Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн газраас өгсөн үүрэг даалгаврыг чанартай биелүүлээгүй, мэргэжил, ёс зүйн зөрчил гаргасан, ажлын байранд тавигдсан шалгуур, шаардлагыг хангаагүй тохиолдолд байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн хууль, бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.	
3. Албан тушаалын нөөц, хэрэгсэл	3.1. Санхүүгийн	<ul style="list-style-type: none"> <li>• Цалин хөлс нь ТҮ-5 гэсэн зэрэглэлээр Засгийн газрын хүчин төгөлдөр эрх зүйн актуудаар тогтоосон албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлээс бүрдэх;</li> <li>• Жилийн хөдөлмөрийн хөлс /албан тушаалын цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл/</li> <li>• Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу нийгмийн баталгаагаар хангагдах</li> <li>• Хуулийн дагуу олгогдох тэтгэмж, урамшуулал</li> </ul>
	3.2. Материалын	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын хувцас,</li> <li>• Ажлын өрөө, байр /Эрүүл мэндийн кабинет/</li> <li>• Эрүүл мэндийн анхны болон яаралтай тусламж үзүүлэх багаж хэрэгсэл тоног төхөөрөмж, ариутгалын бодис, эм, боолтын материал,</li> <li>• Холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр,</li> <li>• Мэргэжлийн болон яаралтай тусламжийн ном хэвлэл, гарын авлага,</li> <li>• Компьютер</li> <li>• Үзлэгийн ор</li> <li>• Бичгийн хэрэгсэл</li> <li>• Энэхүү тушаалын 4дүгээр хавсралтаар батлагдсан эм, эмнэлгийн багаж, хэрэгслээр хангах болон бусад</li> </ul>
	3.3. Хүний нөөцийн	<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагын ажилтнуудтай хамтран ажиллах</li> <li>• Байгууллагын орчинд ёс зүйтэй, биеийн болон сэтгэлзүйн дарамтгүй харилцаагаар хангагдах</li> </ul>



	3.4. Бусад	• Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах
4. Албан тушаалын нөхцөл	4.1. Ердийн нөхцөл	• Ердийн, ажлын орчин тоос шороо, чимээ шуугин, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх
	4.2. Онцго нөхцөл	• Шаардлагатай үед нэмэлт ачаалалтай ажиллах

#### Ё. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсгийн дарга:	Албан тушаалын тодорхойлолтыг хянасан мэргэжлийн комиссын дарга:
Албан тушаалын нэр: .....	Албан тушаалын нэр: .....
(Гарынүсэг) (Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр)	(Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр)
20... оны ... дугаар сарын ... –ны өдөр	20... оны ... дугаар сарын ... –ны өдөр
<b>Албан тушаалын тодорхойлолтыг эцэслэн баталсан томилох эрх бүхий албан тушаалтан:</b>	
Албан тушаалын нэр: .....	
(тамга) .....	
(Гарынүсэг) (Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр)	
20... оны ... дугаар сарын ... -ны өдөр	



**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЭМЧИЙН АЖЛЫН  
БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

**А. ТАНИЛЦУУЛГА**

<b>1. Байгууллагын нэр:</b> Ерөнхий боловсролын сургууль	<b>2. Нэгжийн нэр:</b>	
<b>3. Ажлын байрны нэр:</b> Ерөнхий боловсролын сургуулийн эмч	<b>3.1. Албан тушаалын ангилал:</b> Засгийн газрын тогтоолд зааснаар	<b>3.1. Албан тушаалын зэрэглэл:</b> Засгийн газрын тогтоолд зааснаар
<b>4. Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</b> Ерөнхий боловсролын сургуулийн захирал	<b>4.1. Албан тушаалын ангилал:</b> Засгийн газрын тогтоолд зааснаар	<b>4.1. Албан тушаалын зэрэглэл:</b> Засгийн газрын тогтоолд зааснаар
<b>5. Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаал:</b>	<b>5.1. Албан тушаалын нэр</b>	<b>5.2. Албан тушаал эрхлэгчдийн тоо:</b>

**Б. АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ**

<b>1. Ажлын байрны зорилго:</b> Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, багш, ажиллагчдад эмнэлгийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах	
<b>2. Ажлын байрны үндсэн зорилт:</b>	<p>1. Суралцагчид, багш, ажиллагчдад эмнэлгийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах,</p> <p>2. Төр, иргэний нийгэм, салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурлан сургуулийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх</p>
<b>3. Ажлын байрны гол үйл ажиллагаа:</b>	
<b>3.1. Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд:</b>	Хугацаа, хуваарь
- Суралцагчдын эрүүл мэндийг үзлэгийг жил бүр хийж, картыг бүрэн хөтөлж тэмдэглэх, мөн тэдний амны хөндийн эрүүл мэнд, жин өндрийн хэмжилт, нүдний хараа шалгах үзлэгийг товллын дагуу	50%

<p>хийж, суралцагч, ангийн багш, эцэг эхэд тухай бүр танилцуулан зөвлөгөө өгөх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дархлаажуулалтын үйл ажиллагааг холбогдох эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах, суралцагчийг сургуульд элсэн орох, шилжин ирэх, сургууль төгсөх үед түүний дархлаажуулалтад хамрагдсан бичиг баримтын бүрэн байдлыг шалгаж, картад хавсаргах;</li> <li>- Халдварт өвчин гарсан үед авах хариу арга хэмжээний талаар сургуулийн захиргаа, анги удирдсан багш нарт зөвлөх, мөн халдварт болон эрсдэлт өвчин гарсан тохиолдолд ариутгал, халдваргүйтгэлийг холбогдох эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;</li> <li>- Багш, ажиллагчид, суралцагчид, эцэг эхийн дунд халдварт болон халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах, бие бялдраа чийрэгжүүлэх, эрүүл аж төрөх ёсны талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;</li> <li>- Суралцагчийн нас, хүйс, биеийн хөгжлийн онцлогт тохируулан нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх;</li> <li>- Сурагчдын дунд сэтгэцийн эрүүл мэндийн байдал, хорт зуршлын хэрэглээний талаарх тандалт судалгаа хийж, үнэлгээ өгч, сургалт сурталчилгаа хийх;</li> <li>- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулахад эрүүл мэндийн багш нарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;</li> <li>- Сургуулийн хоолны газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, холбогдох стандартын хэрэгжилт, "Үдийн цай/хоол"-ны орц, норм, норматив, илчлэг, бүтээгдэхүүний нийлүүлэлт, боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, нэр төрөл, ариун цэвэр халдваргүйжилтэд хяналт тавих;</li> <li>- Сурагчдын дунд сайн санааны туслагч эмч, улаан загалмайн идэвхтэн зэрэг хөдөлгөөн өрнүүлж, сургагчаар бэлтгэн ажиллах.</li> <li>- Суралцагчид, багш ажилчдад эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх.</li> </ul>	
<p><u>3.2.Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын байрны чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой эрүүл мэндийн бодлого, хууль, тогтоомж, хөтөлбөр, тушаал, шийдвэрийг суралцагчид, ажиллагчдад сурталчилан таниулах, хэрэгжүүлэх;</li> <li>- Суралцагчдын ариун цэвэр, эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, үнэлгээ хийх, эмчлэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийж, эрүүлжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх ажлыг холбогдох эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага, эмч нартай хамтран зохион байгуулах;</li> <li>- Сургууль, дотуур байр, анги танхимын ариун цэвэр, эрүүл ахуйн байдалд хяналт тавьж, холбогдох асуудлыг судлан сургуулийн захиргаанд санал тавьж шийдвэрлүүлэх, шаардлагатай</li> </ul>	<p>50%</p>



	<p>тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газарт мэдэгдэж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг сургуулийн захиргаатай хамтран зохион байгуулах;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн, багш, суралцагчдын дунд эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон болох хөдөлгөөн өрнүүлж, мэргэжиларга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах;</li> <li>- Эрүүл мэндийн сайн дурын үйл ажиллагаанд суралцагч, багш, ажилтнуудыг татан оролцуулах, хамтран ажиллах;</li> <li>- Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдийг нийгмийн ажилтантай хамтран илрүүлж, нууцыг хадгалах, харьяалах цагдаагийн байгууллагад мэдээлэх, хариу арга хэмжээ авах;</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн нас, бие бялдар, сэтгэлзүйн онцлогт тохирсон хөдөлгөөн болон сэргээн засалтын эмчилгээ, тусламжийг холбогдох эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага, эмч, мэргэжилтэн нартай хамтран зохион байгуулах;</li> <li>- Мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх, сургалт, судалгаа хийх;</li> <li>- Сургуулийн хамт олны эрүүл мэндийн түвшинг холбогдох эрүүл мэндийн байгууллага, эмч нартай хамтран жил бүр тогтоож, ажиллах;</li> <li>- Ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлэн эрүүл мэндийн кабинетийг суралцагч, ажилчлагдад эзлтэй байдлаар байгуулах, ашиглах, тогтмол баяжуулан, тохижуулах арга хэмжээг сургуулийн удирдлага, хамт олонтой хамтран зохион байгуулах;</li> <li>- Байгууллагын дотоод хяналт шалгалтын болон хүүхэд хамгааллын багийн бүрэлдэхүүнд багтан ажиллах;</li> </ul>
--	---

## В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Ажлынбайрандтавигдахшаардлага	1.1. Ерөнхий шаардлагууд	Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Анагаах ухааны боловсрол олгох их, дээд, дунд сургуулийг дипломын болон бакалавр зэрэгтэй төгссөн байх	-Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
		Мэргэжил	Хүний их эмч, бага эмч, сувилагчийн мэргэжлийн дипломтой байх	Үндсэн мэргэшлийн сургалтанд хамрагдсан байх
		Мэргэшил	Төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдсан буюу мэргэшлийн үнэмлэхтэй байх	Хүүхэд хамгааллын чиглэлийн сургалтад хамрагдсан байх
		Туршлага	Эмчлэх болон сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	2 ба 5 жилийн хугацаатай эмчлэх үйл ажиллагаа эрхэлсэн байх
		Урчадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжлээрээ ажиллах чадвартай</li> <li>• Нууц хадгалах</li> <li>• Багаар ажиллах чадвартай</li> <li>• Харьцааны соёлтой</li> <li>• Судалгааны арга зүй эзэмшсэн</li> </ul>	



		<ul style="list-style-type: none"> <li>• Бүтээлч санаачлагатай</li> <li>• Ачаалал даах</li> <li>• Компьютерийн мэдлэгтэй, хэрэглээний программуудыг эзэмшсэн</li> <li>• Хариуцлага хүлээх</li> <li>• Гадаад хэлний зохих мэдлэгтэй</li> <li>• Ёс суртахууны зөрчил гаргаагүй байх</li> </ul>
	1.2.Тусгай шаардлага:	<ul style="list-style-type: none"> <li>▪ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах,</li> <li>▪ Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх,</li> <li>▪ Холбогдох хууль тогтоомж, дүрэм зааврыг сайтар судалж, хэрэгжүүлэх,</li> <li>▪ Гамшгийн үед дайчлагдах, бэлэн байдлыг хангаж ажиллах</li> </ul>

### Г. БУСАД ХҮЧИН ЗҮЙЛС

#### 1. Ажлынбайрныхарилцахсубъект:

1.1. Байгууллагын дотор талд байгаа: - Сургуулийн захирал, - эрүүл мэндийн багш, бусад багш,ажиллагчид, суралцагчид.	1.2. Байгууллагын гадна талд байгаа: - Аймаг, нийслэл сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, БСУГ, ЭМГ, ЭМТөв, нэгдсэн эмнэлэг болон бусад төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, - Суралцагчдын эцэг эх
--	--


2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааг биелүүлээгүй, харицлагагүй хандсан, үүсгэн байгуулагч, Боловсрол, соёл, урлагийн газар, Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн газраас өгсөн үүрэг даалгаврыг чанартай биелүүлээгүй, мэргэжил, ёс зүйн зөрчил гаргасан, ажлын байранд тавигдсан шалгуур, шаардлагыг хангаагүй тохиолдолд байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн хууль, бусадхууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.
--	--

3. Ажлын байрны Нөөц хэрэгсэл	3.1.Санхүүгийн	<ul style="list-style-type: none"> <li>- Үндсэн цалинг Засгийн газрын тогтоолын дагуу тооцож олгох,</li> <li>- Цол, зэргийн нэмэгдэл олгох</li> <li>- Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу нийгмийн баталгаагаар хангагдах</li> <li>- Хуультогтоомжийн дагуу нэмэгдэл, бусад нэмэгдэл, урамшуулал олгох.</li> </ul>
	3.2.Материалын	<ul style="list-style-type: none"> <li>-Ажлын хувцас,</li> <li>-Ажлын өрөө, байр /Эрүүл мэндийн кабинет/</li> <li>-Эрүүл мэндийн анхны болон яаралтай тусламж үзүүлэх багаж хэрэгсэл тоног төхөөрөмж, ариутгалын бодис, эм, боолтын материал,</li> <li>-Холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр,</li> <li>-Мэргэжлийн болон яаралтай тусламжийн ном хэвлэл, гарын авлага,</li> <li>-Компьютер</li> </ul>

		-Үзлэгийн ор -Бичгийн хэрэгсэл -Энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан эм, эмнэлгийн багаж, хэрэгслээр хангах болон бусад
	3.3.Хүний	- Байгууллагын ажилтнуудтай хамтран ажиллах - Байгууллагын орчинд ёс зүйтэй, биеийн болон сэтгэлзүйн дарамтгүй харилцаагаар хангагдах
	3.4.Бусад	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах
4. Ажлын байрны Нөхцөл	4.1. Ердийн нөхцөл	Ажлын орчин тоос шороо, чимээ шуугин, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх
	4.2. Онцгой нөхцөл	

#### Д.БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлынбайрнытодорхойлолтыгхянасан:	Ажлынбайрнытодорхойлолтыгзөвшөөрсөн:
<p>.....</p> <p>(Ажлын байрны тодорхойлолтыг хянасан албан тушаалтны эцэг эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр )</p> <p>.....</p> <p>(гарын үсэг)</p> <p>.... оны ... дугаар сарын ...-ны өдөр</p>	<p>.....</p> <p>(Ажлын байрны тодорхойлолтыг зөвшөөрсөн албан тушаалтны эцэг эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр )</p> <p>.....</p> <p>(гарын үсэг)</p> <p>.... оны ... дугаар сарын ...-ны өдөр</p>



**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН  
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

**А. ТАНИЛЦУУЛГА**

1. Байгууллагын нэр: Ерөнхий боловсролын сургууль	2. Нэгжийн нэр:	
3. Ажлын байрны нэр: Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч	3.1. Албан тушаалын ангилал: Засгийн газрын тогтоолд зааснаар	3.1. Албан тушаалын зэрэглэл: Засгийн газрын тогтоолд зааснаар
4. Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Ерөнхий боловсролын сургуулийн захирал	4.1. Албан тушаалын ангилал Засгийн газрын тогтоолд зааснаар	4.1. Албан тушаалын зэрэглэл Засгийн газрын тогтоолд зааснаар
5. Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаал:	5.1. Албан тушаалын нэр	5.2. Албан тушаал эрхлэгчдийн тоо:

**Б. АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ**

1. Ажлын байрны зорилго: Сургуулийн сэтгэл зүйчийн мэргэжлийн үйлчилгээг суралцагч-хамт олон-гэр бүлд хүргэж, суралцагчийн сэтгэл зүйг зөв төлөвшүүлэх арга зүйн удирдлагаар багш, ажиллагчдыг хангаж, хамтран ажиллаж, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх	
2. Ажлын байрны үндсэн зорилт:	<p>1. Суралцагчийн эрүүл мэндийн болон сэтгэцийн тулгамдсан асуудлын эрсдлийн үнэлгээ хийж, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх,</p> <p>2. Хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчид, багш, ажиллагчдад сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих чиглэлээр сургалт зохион байгуулах</p>
3. Ажлын байрны гол үйл ажиллагаа:	
3.1. Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд:	Хугацаа
- Суралцагчийн зан үйл, биеэ авч явах байдал, харилцааны болон бусад сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг тодорхойлон, дүгнэлт гаргаж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;	50%



<ul style="list-style-type: none"> <li>- Суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш нартай ганцаарчилсан ярилцлага хийж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;</li> <li>- Сэтгэл зүй, сэтгэцийн тулгамдсан асуудалтай, зан үйлийн болон сэтгэл хөдлөлийн хувьд анхаарал татсан хүүхдүүд, тэдний гэр бүл, багш нартай тусгайлан төлөвлөгөө боловсруулан нийгмийн ажилтантай хамтран ажиллах;</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг тодорхойлон, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш нарт сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх;</li> <li>- Анги, хамт олонд тулгуурласан сэтгэл зүйн зөвлөгөө, ярилцлага хийж, сэтгэл зүйн тусламж үзүүлэх;</li> <li>- Ёс зүйн хэм хэмжээг чанд сахин мөрдлөг болгон ажиллах, хувь хүний нууцлалыг чанд сахин ажиллах,</li> <li>- Суралцагчийн нас, бие бялдар, сэтгэлзүйн онцлогт тохирсон хүүхэд хөгжүүлэх бодлого хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад сургуулийн нийгмийн ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх;</li> </ul>	
<p><u>3.2.Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийг хөгжүүлэх, сургах үйл явцад сэтгэл зүйн таатай, эрүүл орчинг бүрдүүлэх зорилгоор анги, хамт олон, анги удирдсан багш, удирдах ажилтан, эцэг, эхэд зориулсан сэтгэл зүйн сургалтуудыг зохион байгуулах;</li> <li>- Хөгжлийн нэг үеэс нөгөөд шилжин орох нөхцлийг хүүхдэд бүрдүүлэх, нийгэмшихэд нь туслах зорилгоор эцэг эх, асран хамгаалагч, багш нарт сургалт явуулах;</li> <li>- Суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилчлагчдад БСШУСЯ, ЭМЯ-наас батлагдсан сургалтын материалын дагуу сургалт хийх;</li> <li>- Суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, багш нарт сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хийх;</li> <li>- Сэтгэл зүйн судалгаа, шинжилгээ хийх, илтгэл зөвлөмж боловсруулах;</li> </ul>	50%



## В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

2. Ажлынбайрандтавигдахшаардлага	3. Ерөнхий шаардлагаагууд	Үзүүлэлт	Зайлшгүйшаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Сэтгэл зүйн мэргэжлийн бакалаврын зэрэгтэй байх	-Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
		Мэргэжил	- Сэтгэл зүйч - Сэтгэл засалч	Үндсэн мэргэшлийн сургалтанд хамрагдсан байх
		Мэргэшил	Сэтгэл зүй, сэтгэл заслын чиглэлээр мэргэшсэн байх	-Хүүхэд хамгааллын чиглэлийн сургалтад хамрагдсан байх
		Туршлага	Хүүхдийн сэтгэл зүйн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх	2 ба 5 жилийн хугацаатай эмчлэх үйл ажиллагаа эрхэлсэн байх
		Урчадвар	- Мэргэжлээрээ ажиллах чадвартай - Нууц хадгалах - Багаар ажиллах чадвартай - Харьцааны соёлтой - Бүтээлч санаачлагатай - Ачаалал даах - Компьютерийн мэдлэгтэй, хэрэглээний программуудыг эзэмшсэн - Хариуцлага хүлээх	
1.2.Тусгай шаардлага:		- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах, - Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх, - Гамшгийн үед дайчлагдах, бэлэн байдлыг хангаж ажиллах		


## Г. БУСАД ХҮЧИН ЗҮЙЛС

1. Ажлын байрны харилцах субъект:	
1.3. Байгууллагын дотор талд байгаа:	1.4. Байгууллагын гадна талд байгаа:
- Сургуулийн захирал, - Эрүүл мэндийн багш, бусад багш,ажиллагсад, сурагчид.	- БСШУСЯ - ЭМЯ - Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газар - Сэтгэл судлалаар боловсрол олгодог их, дээд сургууль, хүрээлэн - Төрийн болон иргэний нийгмийн байгууллага - Хүүхдийн эцэг эх, асран хамгаалгч - Бусад
2. Хүлээх хариуцлага	Ажлын байрны зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааг биелүүлээгүй, харицлагагүй хандсан, үүсгэн байгуулагч, Боловсрол, соёл, урлагийн газар, Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн газраас өгсөн үүрэг

	даалгаврыг чанартай биелүүлээгүй, мэргэжил, ёс зүйн зөрчил гаргасан, ажлын байранд тавигдсан шалгуур, шаардлагыг хангаагүй тохиолдолд байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн хууль, бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.	
3. Ажлын байрны Нөөц хэрэгсэл	3.1.Санхүүгийн	<ul style="list-style-type: none"> <li>- Үндсэн цалинг Засгийн газрын тогтоолын дагуу тооцож олгох,</li> <li>- Цол, зэргийн нэмэгдэл авах</li> <li>- Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу нийгмийн баталгаагаар хангагдах</li> <li>- Хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл, бусад нэмэгдэл, урамшуулал олгох.</li> </ul>
	3.2.Материалын	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох хууль тогтоомж хөтөлбөр,</li> <li>- Мэргэжлийн болон яаралтай тусламжийн ном хэвлэл, гарын авлага,</li> <li>- Ажлын өрөө байр,</li> <li>- Үзлэгийн ор,</li> <li>- Ширээ сандал,шүүгээ,</li> <li>- Сэтгэл зүйн тест, аргачлал</li> <li>- Компьютер, холбогдох программ хангамж</li> <li>- Бичгийн хэрэгсэл болон бусад</li> </ul>
	3.3.Хүний	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын ажилтнуудтай хамтран ажиллах</li> <li>- Байгууллагын орчинд ёс зүйтэй, биеийн болон сэтгэлзүйн дарамгүй харилцаагаар хангагдах</li> </ul>
	3.4.Бусад	Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр хамрагдах
4. Ажлын байрны нөхцөл	4.1. Ердийн нөхцөл	Ажлын орчин тоос шороо, чимээ шуугин, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх
	4.2. Онцгой нөхцөл	

#### Д. БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг хянасан:	Ажлын байрны тодорхойлолтыг зөвшөөрсөн:
<p>.....</p> <p>(Ажлын байрны тодорхойлолтыг хянасан албан тушаалтны эцэг эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр )</p> <p>.....</p> <p>(гарын үсэг)</p> <p>.... оны ... дугаар сарын ...-ны өдөр</p>	<p>.....</p> <p>(Ажлын байрны тодорхойлолтыг зөвшөөрсөн албан тушаалтны эцэг эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр )</p> <p>.....</p> <p>(гарын үсэг)</p> <p>.... оны ... дугаар сарын ...-ны өдөр</p>



Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны 12 сарын 04 өдрийн А/Б/... А/Б/ дугаар хамтарсан тушаалын 4 дүгээр хавсралт

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрүүл мэндийн кабинетэд байх шаардлагатай эм, багаж хэрэгслийн жагсаалт

№	Эм, багаж хэрэгслийн жагсаалт	Хэмжих нэгж	Тоо ширхэг
<b>Эмнэлгийн анхан шатны тусламжийн эм:</b>			
1	Яаралтай тусламжийн бикс	Ш	1
2	Кордиамин 1% -1.0	Ш	2
3	Аналгин 1% -1.0	Ш	5
4	Викасол 1% - 1.0	Ш	5
5	Новокаин 1%-1.0	Ш	20
6	Бөөрөн таваг/лотушка/	Ш	2
7	Кальция глюконат 10%-10.0	Ш	5
8	Денатурат, нашатырь спирт/, тус бүрээс	Гр	100-200
9	Бинт, хөвөн, тус бүрээс	Ш	5
10	Иод, метилийн хөх, тус бүрээс	Гр	10-200
11	Халууны шил	Ш	2
12	Чангалуур	Ш	2
13	Мэс заслын хямсаа, хавчуур	Ш	5
14	Нэг удаагийн зүү, тариур /гр тус бүрээс/	Ш	10
15	Хросол	Ш	20
16	Парацетамол	табл	20
17	Ибобруфен	табл	10
18	Ношпа	табл	20
19	Мезимфорте	табл	20
<b>Эмчийн өдөр тутмын үзлэгт шаардагдах багаж хэрэгсэл</b>			
1	Даралтын аппарат, чагнуур, тус бүрээс	Ш	1
2	Уушгины багтаамж хэмжигч	Ш	1
3	Уушгины багтаамж хэмжигчид ашиглах хошуу, ариутгагч	Ш	20
4	Хүчилтөрөгчийн багтаамж хэмжигч/Puls oximeter/	Ш	5
5	Биеийн жин, өндөр хэмжигч, тус бүрээс	Ш	1
6	Биеийн бэлхүүс хэмжих туузан метр	Ш	3
7	Гар, нурууны хүч хэмжигч, тус бүрээс	Ш	1
8	Хараа шалгах хүснэгт, багаж	Ш	1 багц
9	Биеийн бодисын солилцоо хэмжигч "Ганита" аппарат	Ш	1
10	Биеийн болон эрхтэн тогтолцооны бүтэц, зохион байгуулалтыг харуулсан муляж, эрүүл мэндийн үзүүлэн таниулах хэрэгсэл	Ш	Хэрэгцээгээр
11	Үзлэгийн бүртгэлийн маягт, журнал	Ш	Хэрэгцээгээр
12	Суралцагчдын карт	Ш	Хүүхдийн



			тоогоор
13	Хэл дарагч	Ш	100
<b>Кабинетийн тохижилтод шаардагдах хэрэгсэл</b>			
1	Эмчийн ширээ, сандал	Ш	1
2	Өвчтөн үзэх үзлэгийн ор, хаалт, тус бүрээс	Ш	1
3	Компьютер, принтер	Ш	1
4	Баримт, материал хадгалах, эм хадгалах шүүгээ, тус бүрээс	Ш	1
5	Шил сав ариутгагч	Ш	5
6	Эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны гарын авлага, материал	Ш	Хэрэгцээгээр
7	Зөөврийн кварц	ш	1
8	Ариутгалын бодис	төрөл	Хэрэгцээгээр
9	Буйдан	ш	1
10	Сургалтын самбар, үзэг	ш	1
11	Бусад шаардлагатай зүйлс		Хэрэгцээгээр





